

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY


Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2013. 09 сар. №17, 18 (051, 052)

www.mongolianeconomy.mn

Монгол, Их Британи улсын
хооронд дипломат харилцаа
тогтоосны 50 жилийн ойд
зориулсан тусгай дугаар

МОНГОЛ, ИХ БРИТАНИЙН ТҮҮХЭН ТҮНШЛЭЛ



Barbour®



Four Seasons

LUXURY APARTMENTS & PENTHOUSES



ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Герман Стандарт ХХК нь 2013 оны төслийн хүрээнд Баянгол дүүргийн 4-р хороо, 2-р хороолол, Ханбүргэдэй худалдааны төвийн хойно байрлах "GS Four Seasons" хотхоны 1-р ээлжийг 2014 оны 3-р улиралд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.

"GS Four Seasons" хотхон нь Хавар, Зун, Намар, Өвөл гэсэн 4-н блоктой, 160 айлын 10 давхар орчин үеийн технологийн шийдэл бүхий орон сууц юм.

ТӨЛӨВЛӨЛТ

- | | |
|--------------------------------|---|
| B1 - Автомашины зогсоол | F8-F11 - Пентхаус |
| F1 - Үйлчилгээний төв | Өрөө - 2-4 |
| F2-F7 - Орон сууц | Талбай - 52.2м ² -109м ² |



Утас: 7000-7007, 8810-7007, 8610-7007
И-мэйл: info@gsc.mn,
Веб хаяг: www.gsproperty.mn

SIEMENS

Schneider Electric

KOHLER

Roto

KNAUF

REHAU

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
ОРЧУУЛАГЧ:

Теренс Эдвардс
Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Х.Хулан

ДИЗАЙНЕР:
Вэб мастер:

Ш.Оюундарь
Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Барянжав /9409-2904/
Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ

РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг. VI хороо,
Их сургуулийн гудамж. АВ center. 503 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж глаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетиin бүх салбар

"Макс" супермаркетиin бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



50 жил гэдэг богино биш хугацаа. Буурал түүхийн багагүй хугацаанд манай хоёр улс хамтын хөгжил, цэцэглэлийн өөр өөрийн өнгө аясаар хөгжсөөр ирсэн билээ. Өнгөрсөн он жилүүдэд хоёр улсын хамтын ажиллагаа олон салбарт өргөжин тэлсэн төдийгүй цаашдын хөгжлийн бодлогоо тодорхойлоод байна. Алс холд орших Англи алсрах хугацааны эцэст монголчуудтай

ойр дотно түншийн нөхөрлөлөөр харьцах ирээдүйн бодлого тодорхой болсон гэсэн үг.

Их Британийн ЭСЯ-тай хамтран Английн боловсрол, шинжлэх ухаан, ногоон хөгжлийн бодлого, авлигын тэмцэл болоод Монголд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааны түүхэн нугачааны талаарх олон нийтлэл, ярилцлагыг багтаасан хоёр улсын дипломат харилцааны тэмдэглэлт жилд зориулсан сэтгүүлийнхээ тусгай дугаарыг уншигч, захиалагч таны гарт хүргэж байгаадаа баяртай байна.

Бид энэхүү дугаарын талаар олон сарын өмнөөс ярьж, төлөвлөж, Английн ЭСЯ-тай нягт хамтран ажилласны дүнд шинэхэн дугаар маань та бүхний гар дээр очиж байна. Английн соёл, аялал жуулчлал, хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулалтын бодлоготой газар дээр нь очиж танилцахын тулд сэтгүүлийн тусгай баг өнгөрсөн долоодугаар сард Лондон хотноо ажилласан байгаа. Английн Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлагын захирал, Лондонгийн Олимпын хорооны дарга нартай ярилцлага хийхээс гадна Лондоны Хөрөнгийн биржийн үйл ажиллагаатай танилцаж, Лондон дахь монголчуудтай уулзаж ярилцсан юм. Түүнээс гадна дэлхийн сэтгүүл зүйн хөгжлийг тодорхойлдог The Financial Times, The Economist-сэтгүүлийн редакцид зочилж, мэргэжил нэгт нөхдийнхөө тэргүүн туршлагаас хуваалцсан нь миний хувьд мартагдашгүй үйл явдал болсон юм.

Ийнхүү Их Британи улс Монгол Улстай ямар харилцаа, хамтын ажиллагаатай хөгжиж ирсэн, түүхэн хөгжлийнхөө явцад юу хийж амжуулсан, цаашдын хөгжлөө ямар чиглэлээр тодорхойлсон зэргийг энэхүү тусгай дугаарт бодитоор, баримтаар харуулахыг хичээлээ.

Бидэнтэй хамтарч ажиллаж, санаа оноогоо хуваалцаж, бас шүүмжилж, урамшуулж, мөн Лондонд ажиллах хөтөлбөрийг боловсруулж, бүх асуудлыг зохицуулж өгсөн Их Британийн Элчин сайд Кристофер Стюарт болон Элчин сайдын яамны хамт олонд гүнээ талархснаа илэрхийлье. Манай сэтгүүлийн хувьд Английн Элчин сайдын яамтай хамтарч ажилласнаар англи стандарт гэж юу болохыг мэдрэхийн зэрэгцээ маш том туршлага, мэдлэг хуримтлуулсан хамтын ажиллагаа боллоо гэж ойлгож байна.

Бидний хамтын ажиллагаа цаашид олон зүйл дээр үргэлжилнэ гэдэгт итгэлтэй байна. Хоёр улсын түншлэл, ирээдүйн харилцаанд амжилт хүсье.

Д.БЭХБАЯР

ХАРИЛЦАА

- 8** Эхлэл болсон 1893 он
- 10** Н.Тулга: Хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллах шаардлага бий
- 11** Кристофер Стюарт: Туршлага хуваалцах саналыг монголын талд дэвшүүлсэн
- 13** Англи дахь Монгол судлал
- 14** Фото мэдээ
- 16** Британийн тэнгэр доорх Монгол аялгуу



ЭДИЙН ЗАСАГ

- 18** Монгол Улсын мега төслүүд
- 20** Ник Байрд: Монголыг сонирхож буй компаниуд олон бий
- 22** Түүхэн түншлэл
- 26** Авлигагүй бүс
- 28** Алгасаж үл болох Англи

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

- 30** Их Британийн тогтвортой хөгжил
- 31** Ногоон хөгжлийн тасалбар
- 33** Шинжлэх ухааны арал
- 36** Лондон хоттой түншилснээр Монголын эдийн засгийн өсөлт хурдацтай нэмэгдэнэ
- 38** Эерэг хөгжил
- 39** Олимпийн хотхонд хөгжил үргэлжилсээр
- 42** Үнэт зүйлийн үнэтэй зүтгэл
- 43** Хувьслаас хувьсгал руу

БИЗНЕС

- 46** Сайн түншлэл ямар ч өөрчлөлтийг давж гардаг
- 48** Бизнес гүүр
- 49** Хосгүй бүтээл Их Майдар
- 51** Монгол улсын төлөө зүтгэе

БОЛОВСРОЛ

- 54** Ирээдүйн захиалга
- 55** Р.Амаржаргал: Монгол Улстай харилцаа тогтоосон анхны барууны орон бол Их Британи
- 56** Английн амжилтын оньс
- 62** Английн эрүүл мэндийн тогтолцоо
- 65** The Economist, Financial Times-ийн редакцид зочиллоо

МОНГОЛ УЛС

МЭНДЧИЛГЭЭ



Монгол, Их Британийн хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулан “Mongolian Economy” сэтгүүл тусгай дугаар гаргаж байгааг талархалтайгаар хүлээн авч байна.

Монгол Улс хоёр хөрштэйгээ тэнцвэртэй гадаад бодлого явуулахад манай “гуравдагч хөрш”-үүд, тэр дундаа Их Британи улс чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Монгол Улсын тусгаар тогтнолыг Баруун Европын орнууд дундаас анхлан хүлээн зөвшөөрсөнд Их Британийн Засгийн газарт бид талархаж явдаг.

Монгол Улсад ардчилал, зах зээлийн эдийн засгийг бэхжүүлэх үйлсэд Британи улс түншийн чухал үүрэг гүйцэтгэж, манай хоёр талын харилцаа тогтвортой, идэвхжиж, илүү прагматик болж байна.

Хоёр талын хамтын ажиллагааны чухал механизм болох Монгол, Их Британий төр, засгийн байгууллагууд оролцож, харилцан сонирхсон сэдвээр санал солилцох талбар болох Монгол, Их Британийн Дугуй ширээний 10 дугаар уулзалтыг өнгөрөгч арваннэгдүгээр сард амжилттай зохион

байгуулсан.

Монгол Улсын Цөмийн зэвсэггүй статуст НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын таван гишүүн дахин баталгаа гаргах, Монгол Улс Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын гишүүнээр элсэх болон Европын Холбоотой “Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр” байгуулах явцад Их Британийн Засгийн газар тогтмол дэмжлэг үзүүлж ирсэн нь манай хоёр улсын олон улсын тавцан дахь хамтын ажиллагаа өргөжиж байгааг илэрхийлнэ. Мөн манай хоёр улсын зэвсэгт хүчин олон улсын энхийг сахиулах ажиллагаанд идэвхтэй оролцож байгаад мөн баяртай байна.

Ирэх 50 жилийн хугацаанд бид олон олон амжилтаар дүүрэн хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Сэтгүүлийн энэхүү тусгай дугаараас Монгол, Их Британийн өнгөрсөн хагас зууны харилцааны талаар Та бүхэн сонирхолтой, соргог мэдээлэл олж авна гэдэгт найдаж байна.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД
ЛУВСАНВАНДАНГИЙН БОЛД

ИХ БРИТАНИ

МЭНДЧИЛГЭЭ



Мongolian Economy” сэтгүүлийн тусгай дугаарыг гаргахад багахан ч атугай хувь нэмэр оруулж байгаадаа миний бие баяртай байна. Их Британи, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан танай редакциас хоёр улсын харилцааны талаар тусгай дугаарыг гаргаж байгаа нь цагаа олсон зүйл юм. Үнэн хэрэгтээ энэ тусгай дугаар нь өнгөрсөн 50 жилийн туршид манай хоёр улсын харилцаа ямар түвшинд хөгжсөнийг харуулах гэрч гэлтэй. Энэ хугацаанд бид бие биенээ сайн мэдээд зогсохгүй зөвхөн дотнын анд нөхдийн хооронд байдаг харилцан итгэлцэл дээр үүсдэг тэрхүү нандин харилцааг бий болгож чадсан гэж бодож байна.

Миний бие өнгөрсөн оны арваннэгдүгээр сард Лондон хотноо болсон Их Британи, Монгол Улсын хоорондох дугуй ширээний ярилцлага, уулзалтад оролцсон болно. Манай хоёр улсын хооронд бүрэн хэмжээний уулзалт жилд хоёр удаа зохиогддог болсон нь бидний харилцаа цаашид улам өргөжин тэлэхийг харуулж буй хэрэг. Хоёр улсын хооронд шинээр гарч ирж буй худалдааны харилцааг Их Британи улс бүхэлд нь шинэчлэн сайжруулах хүсэл сонирхолтой. Их Британи Монголд машин механизм, уул уурхайн тоног төхөөрөмж, хувцас, оёмол бүтээгдэхүүн, хүнс, ундаа зэрэг олон төрлийн бараа, бүтээгдэхүүн экспортолдог. Монголд Шотланд виски маш их **илүүтэй танигдсан** бүтээгдэхүүн юм байна гэж би ойлгосон. Үүний нэгэн адил Монголд үйлдвэрлэсэн архи, дарсыг Английн дэлгүүрүүдээр

тун удахгүй худалдаалах байх гэж найдаж байна. Мэдээж Их Британи руу Монголоос экспортлох чухал бараа бол ноос, ноолууран бүтээгдэхүүн юм.

Их Британи боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт Монгол Улстай харилцаагаа дэвшилтэт шатанд гаргахыг зорьж буй. Өнөөдөр Монголын боловсролын тогтолцоонд Кэмбрижийн олон улсын шалгалт голлох шалгуур болж чаджээ. Ийнхүү бид хамтран ажилласнаар манай хоёр улс цаашид соёлын эрх тэгш ойлголтыг хөгжүүлэх, харилцан ашигтай эдийн засгийн боломжийг хөхиүлэн дэмжих, хоёр улсын ард иргэдийн хувьд хэн хэнд нь ашигтай биет хөрөнгийг бий болгох боломжтой юм.

Монгол Улс нэг намын тогтолцооноос ардчилал руу шилжин орсон нь бүс нутгийнхаа бусад орны хувьд үлгэр жишээ загвар болж чадсан. Энэ онд болсон Ерөнхийлөгчийн сонгууль үүнийг гэрчилж буй. Гэхдээ Монгол Улсын хөгжил дан ганц эдийн засгийн өсөлтөөр хязгаарлагдахгүй. Энэ нь Монгол Улсын дэлхийн тавцанд эзлэх байр суурь юм. Тухайлбал, Монгол Улс Ардчилсан орнуудын хамтын нөхөрлөлийн тэргүүнээр ажиллах хугацаандаа ажлаа нэр төртэй гүйцэтгэсэн, түүнчлэн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын гишүүнчлэлд элсэн орж, улмаар дэлхий дахинд энхтайвныг тогтоох үйлст гар бие оролцож байгаа зэргийг дурдаж болно.

Хоёр улсын хоорондох харилцаа цаашид улам хөгжин цэцэглэнэ гэдэгт миний бие итгэл төгс байгаагаа энэ дашрамд илэрхийлэхэд таатай байна.

ИХ БРИТАНИЙН ГАДААД ХАРИЛЦАА,
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЯАМНЫ ТӨРИЙН САЙД
ХЮГО ЖОРЖ УЙЛЬЯМ СВАЙР

ТҮҮХ

ЭХЛЭЛ БОЛСОН 1893 ОН

Д.ЗОЛБОО

Монгол, Их Британи хоорондын дипломат харилцаа 50 насыг “зооглож” буй ч хоёр улсын худалдааны замнал түүнээс ч урт настай. Түүхт бичвэрүүдийг эргэн сөхвөөс тэртээ 1893 онд Их Британийн худалдаачид анх манай улсад хонь, тэмээний ноос, малын арьс шир зэргийг худалдан авахаар зочилж байжээ. Ийнхүү 1907 онд Англиар овоглох худалдааны анхны пүүс үйл ажиллагаагаа эхлүүлсэн аж. Түүнчлэн 1905-1907 онуудад тус улсын худалдааны пүүсүүд 200 хүртэлх мянган пүү ноосыг Хятадаар дамжуулан Европ руу нийлүүлсэн тухай баримтыг Академич Б.Ширэндэв

нэгэн өгүүлэлдээ тэмдэглэсэн байдаг.

Их Британи тэргүүтэй гаднын хөрөнгө оруулалттай худалдааны олон байгууллага байсныг түүхэн баримтууд нотлох. Тухайлбал, 1922 онд Англи, Америкийн худалдааны таван пүүс үйл ажиллагаа эрхэлж байсан бол хоёр жилийн дотор 62 болж өссөн баримт бий. Түүгээр ч зогсохгүй 1923 онд тэдгээрийн нийт хөрөнгө хоёр сая мексик доллар (нэг мексик доллар 1.97 ам.доллартай тэнцэж байсан)-аар хэмжигдэж байсан бол 1925 онд зөвхөн Английн компаниудын хөрөнгө оруулалт 4.5 сая мексик долларт хүрч байжээ.

Их Британиас угшилтай худалдааны байгууллагууд зөвхөн Их хүрээнд бус аймаг, сумдад сал-

бартай байсныг “The Fur and Wool D.Biedermann” компанийн Улиастайд эрхэлж байсан худалдаа гэрчлэх аж. Түүнчлэн “Wilson and C”, “Forb-ers and C” гэх мэт компаниуд манай улсад суурин төлөөлөгчөө илгээж байлаа. Энэ мэтээр Монгол Улсад гадаадын, тэр дундаа Английн бизнес эрхлэгчдийн тоо олширсоор байв. Улмаар 1927 онд БНМАУ-ын анхдугаар яармаг худалдаа зохион байгуулагдаж, нийт 150 мянган төгрөгийн худалдааны орлогын дийлэнх хувийг Англи, Америкийн компаниуд бүрдүүлсэн гэдэг.

1923 онд худалдааны нийт эргэлт болох 14.730 мянган мексик долларын 4.5 саяыг Их Британийн худалдааны байгууллагууд бүрдүүлж байж. ▶



1973 онд хоёр орны хооронд байгуулсан худалдааны гэрээнд талууд гарын үсэг зурав. Улаанбаатар хот



Баруун гар талаас Монгол Улсын Гадаад харилцааны сайд Л.Болд, Их Британи улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Кристофер Стюарт

► Монгол, Их Британи 1963 онд анхлан дипломат харилцаа тогтоосноор хоёр улсын хоорондох худалдаа өргөжин тэлж, тоног төхөөрөмж захиалах, ангийн үсний дуудлага худалдаанд оролцох зэргээр гадаад худалдааг хөгжүүлснээр жилдээ 400 мянган мексик долларын арилжаа хийх боломж бүрдсэн. Улмаар 1966 онд МАХН-ын 278-р тогтоолоор тус улстай худалдаа хийхийг Гадаад худалдааны яаманд зөвшөөрсөн байдаг.

Монголчуудын ардчилал, шинэчлэлийг эх орондоо авчрах үйл явцыг англичууд дэмжсээр ирсэн. Үүний хүрээнд, 1991 онд манай улстай Эдийн засаг, хамтын ажиллагааны хэлэлцээр болон Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах хэлэлцээрийг үзэглэсэн нь эдийн засгийн салбарт гарсан хамтын ажиллагааны таатай нөхцлийг бүрдүүлсэн юм. Тухайлбал, 1991 онд “Марлик инженеринг” компани анх Монголд шууд хөрөнгө оруулалт хийснээс хойш эдүгээ Их Британийн хөрөнгө оруулалттай нийт 118 компани үйлчилгээ эрхэлж байна. Тус улс

50 гаруй сая ам.долларын хөрөнгө манай улсад оруулсан нь тэргүүлэх 11-т багтах үзүүлэлт юм. 2011 оны дүнгээр Их Британи манай улсаас 20390.5 мянган ам.долларын бараа, бүтээгдэхүүн худалдаж авсан бол 4704.8 мянган ам.доллартай тэнцэх таваарыг Монголд нийлүүлсэн байна.

Ийнхүү хоёр орны худалдаа эдийн засаг ирэх жилүүдэд улам өргөжин тэлэх төлөв харагдаж буйн

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт /сая ам.доллар/

Улсаар	2006	2007	2008	2009	2010	2011
Бүгд	2,977.0	4,009.3	5,779.0	4,023.1	6,108.6	11,415.9
Британи	47.6	35.9	183.2	139.4	87.3	67.4
Импорт	9.0	13.8	17.4	12.5	20.0	47.4
Экспорт	38.6	22.1	165.8	126.9	67.4	20.0

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2011. УБ., 2012

зэрэгцээ газарзүйн холын байршлыг үл харгалзан Английн компаниудын Монгол Улсад хөрөнгө оруулах сонирхол улам нэмэгдсээр байгаа юм. ■

Монгол Улсад бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтад эзлэх хувь, аж ахуйн нэгжийн тоо /мянган ам.доллар/

Улс	Их Британи	Аж ахуйн нэгжийн тоо
Нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь	1.26	1.15
Нийт	50,923.32	118
1990-2004	25,813.2	61
2005	6,347.9	14
2006	9,013.4	12
2007	2,429.0	10
2008	6,057.7	15
2009	72.1	4
2010	289.8	2

Эх сурвалж: Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын газрын албан мэдээ <http://www.investmongolia.com/fifta>

МОНГОЛЫН ЭЛЧИН САЙД

Н.ТУЛГА: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ШААРДЛАГА БИЙ

Э.ЗОРИГТ

“Mongolian Economy” сэтгүүлийн сурвалжлах баг Монгол Улсаас Их Британи улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Н.Тулгатай Лондон хотноо ярилцсан юм.

-Хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа өмнө нь ямар байсан, ирэх жилүүдэд ямар өнгө төрхтэй байх талаар Та эхлээд сонирхуулахгүй юу?

-Тэртээ 1963 онд Их Британи улс нь манай улстай дипломат харилцаа тогтоосноос хойш даруй 50 жилийн хугацаа өнгөрчээ. Энэхүү хугацаанд хоёр орны харилцаа хэвийн хөгжиж ирсэн. 1990 оны ардчилсан хувьсгалын үйл явцыг Их Британи улс анхнаас нь дэмжиж ирсэнд бид талархаж байдаг юм.

Өмнөх жилүүдэд хоёр талын харилцаа гол төлөв улс төр, соёл, боловсролын салбарт тодорхой солилцоо явагддаг бол худалдаа, эдийн засгийн харилцаа эхлэл төдий л байлаа. Харин өнөөгийн нөхцөлд харилцан ашигтай зарчимд тулгуурласан эдийн засгийн агуулгаар хурдацтай хөгжих боломжтой байна. Эдийн засгийн хамтын ажиллагааны эхлэл амжилттай тавигдсан. Тухайлбал, Лондонд төвтэй “Рио Тинто” компани нь “Оюутолгой” төслийн хувь нийлүүлэгч болж, Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж байна. Энэ нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд онцгой нөлөөтэй стратегийн том төсөл юм. Мөн дэлхийд алдартай Лондонгийн



Хөрөнгийн бирж Монгол Улсад хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг олон улсад хүлээн зөвшөөрсөн зарчимд нийцүүлж хөгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаа өрнөж байна. Английн олон компани Монгол Улсын эдийн засагт бодитой хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллаж эхэлсэн.

-Экспорт, импортын хэмжээний тухайд тоо дурьдвал?

-Бараа бүтээгдэхүүний экспорт, импортыг нийт эргэлтээр тооцвол энэ хэмжээ нь хоёр талын эдийн засгийн харилцааны ач холбогдлыг төдийлэн илэрхийлдэггүй. Тухайлбал, өнгөрсөн оны мэдээллээр манай улс Англиас 50 гаруй сая ам.долларын бараа бүтээгдэхүүн худалдан авсан бол эргүүлээд дөнгөж 10 гаруй сая

ам.долларын экспорт хийсэн байх жишээтэй. Бидний зүгээс харилцааг зөвхөн бараа бүтээгдэхүүний эргэлтээр хардаггүй. Өнөөдрийн байдлаар Их Британийн эдийн засгийн 70 гаруй хувийг үйлчилгээний тэр дундаа банк, санхүү, даатгал, хөрөнгө оруулалт, мэргэжлийн үйлчилгээний салбар бүрдүүлдэг. Эдгээр салбарын онцлог нь итгэлцэл. Өөрөөр хэлбэл, Их Британийн хууль эрх зүйн орчин, санхүү, хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалтад олон улс итгэдэг гэсэн үг. Тиймээс уул уурхайн салбарыг суурилан хөгжиж буй Монгол Улсын хувьд энэхүү туршлагаас суралцах бодит шаардлага байгаа юм. Зарим улс Их Британийн гол хуулиудыг шууд орчуулж хэрэглээд амжилтад хүрсэн туршлага байдаг. Энэ утгаараа миний бие тус орны эдийн засаг дахь төрийн бодлогын ололт амжилтаас Монголын хөрсөнд тохируулж, нутагшуулж болох туршлагыг олж, судалж, боловсруулахыг чухал гэж үздэг. Мөн хөрөнгө оруулалтын хувьд ч Англи улстай цаашид хамтран ажиллах шаардлага бий.

-Монголын бараа бүтээгдэхүүн Их Британийн зах зээлд нэвтрэх боломж байгаа юу?

-Маш чухал асуулт байна. Саяхан миний бие Шотландад томиллолтоор ажиллаад ирлээ. Шотланд нь Британийн ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гол бүс нутаг, Британидаа төдийгүй Европдоо өндөр чанарын ноолууран бүтээгдэхүүний гол үйлдвэрлэгч. Сонирхуулахад Шотландын үндэсний хувцас “Килт” гэдэг банзалыг ноолууран даавуугаар хийдэг. Гэтэл ▶

▶ Шотландын үйлдвэрүүд зарим түүхий эдээ, тухайлбал ноолууран ээрмэл утсаа 100 хувь гаднаас импортлож авдаг юм байна. Тэгэхээр магадгүй эхний ээлжинд ноолууран хувцас эдлэл гэхээсээ илүү ноолууран утас нийлүүлэх боломжтой. Энэ талаарх эхний уулзалтуудыг Шотландын Засгийн газрын түвшинд болон бизнесийн төлөөллийн хүрээнд саяхан хийсэн. Тэдний талаас тодорхой сонирхол бий. Харин үүнийг бодит ажил болгох нь Монголын компаниудаас шалтгаалах юм.

Бидний зүгээс энэ оны намар Шотландын Эдинбург хотноо Монголын ноос, ноолууран эдлэлийн бизнес өдөрлөгийг зохион байгуулах чиглэлээр төлөвлөн ажиллаж байна. Удахгүй би Шотландын Британийн Засгийн газрын сайд Майкл Моортой энэ асуудлаар уулзаж ярилцана. Тодорхой үр дүн гарна гэдэгт итгэлтэй байгаа. Шотландын Засгийн газрын тэргүүн Алекс Салмонд мөн энэ жил Монголд айлчлал хийж магадгүй. Энэхүү айлчлалын үеэр хоёр талын ноос, ноолуурын болон бусад салбарын асуудлаар ярилцаж, тодорхой тохиролцоонд хүрэх боломжтой.

-Хоёр орны дипломат харилцааны тэмдэглэлт жилийн хүрээнд ямар ажлууд хийж байна вэ?

-Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 116 тоот тогтоолоор дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар шийдвэр гарч тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. Зарим ажлыг амжилттай хийж дуусгалаа, зарим нь хэрэгжилтийн шатандаа явж байна.

Тухайлбал, Кембрижийн их сургуультай хамтран Монгол Улсын улс төр, эдийн засгийн ирээдүйн хандлагын талаар олон улсын онол, практикийн хурлыг энэ оны гуравдугаар сард Кембриж хотноо амжилттай зохион байгууллаа.

Хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, Монгол-Их Британийн харилцааны түүхийн талаар ном, эмхэтгэл бэлтгэн хэвлүүлэх ажил үр дүнтэй явагдаж байна. Цаашид ч соёл урлаг, спортын чиглэлээр тодорхой ажлууд хийнэ. Тухайлбал, Английн

алдарт Ливерпулын хөл бөмбөгийн багтай хамтарч Монголд хөл бөмбөг хөгжүүлэх төсөл дээр ажиллаж байна.

Тэмдэглэлт ой тохиож буй энэ оны хувьд Их Британийн талаас өндөр хэмжээний айлчлалууд төлөвлөгдөж байгааг энд дурдахад таатай байна. Лондон хотын Ситигийн Лорд, Захирагч Рожер Гиффорд Монголд айлчлахаар хугацаа товлогдон

бэлтгэл ажил хангаж байна. Мөн Их Британийн Худалдаа хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан Төрийн сайд, Британийн Гадаад хэрэг, хамтын нөхөрлөлийн яамны сайд нарын айлчлал энэ оны эцсээр болно гэсэн хүлээлттэй буй. Цаашид хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа улам бүр өргөжин хөгжих боломжтой гэдэгт би итгэлтэй байна. ■

АНГЛИЙН ЭЛЧИН САЙД

КРИСТОФЕР СТЮАРТ: ТУРШЛАГА ХУВААЛЦАХ САНАЛЫГ МОНГОЛЫН ТАЛД ДЭВШҮҮЛСЭН



Х.ХУЛАН

Их Британи улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Кристофер Стюарттай ярилцлаа.

-Түүхийг эргээд сөхвөл харилцаа

50 жилийн өмнөөс эхлэв үү, эсхүл түүнээс ч өмнө эхэлсэн юм болов уу?

-Тавин жилийн өмнө ч гэсэн манай хоёр орон харилцаатай байсан бөгөөд гол төлөв утга зохиолын туурвил, бүтээлийн талбарт өрнөж байжээ. Тухайлбал, Жеоффри Чосерын XIV зуунд бичсэн "Canterbury tale" ёгт үлгэрийг дурдаж болох юм. Хоёр улсын хувьд өөрсдийн хил хязгаараас хол давсан нийтлэг өв, соёлтой тул олон зууны туршид бий болж, хөгжсөн харилцан бие биенээ мэдэх гэсэн чин хүсэл эрмэлзэл нь биднийг өөрийн эрхгүй татсаар ирсэн нь эргэлзээгүй юм.

"Mongolian Economy" сэтгүүлийн энэхүү тусгай дугаарт манай хоёр улсын хоорондох харилцаа бидний хамтдаа бүтээсэн түүхэн он жилүүдэд улам хөгжин цэцэглэсээр ирснийг гэрчлэх олон салбарыг хамарч байгаагаараа онцлог. Эдгээр салбарт тогтвортой хөгжил зэрэг хоёр улсын хооронд өргөжин тэлж буй байгаль, орчны асуудлаарх хамтын ажиллагаа орно. Түүнчлэн боловсрол болон эрүүл мэндийн салбарт хамтын ажиллагаагаа ▶

▸ бэхжүүлэхэд чиглэсэн нийтлэлүүд багтсан болно. Шотландын Эдинбург хотноо жил бүрийн наймдугаар сард зохиогддог Их Британийн Хатан хааны нэрэмжит цэргийн үзүүлэн тоглолтод Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын харьяа Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн баг бүрэлдэхүүн оролцсон. Олон нийтийн анхаарлыг татсан энэ үйл явдал хоёр улсын хоорондох соёлын харилцааг улам бэхжүүлсэн бөгөөд тэмдэглэлт ойн хүрээнд зохион байгуулж буй онцлох арга хэмжээнүүдийн нэг байв.

-Хоёр орны хоорондын харилцааг та хэрхэн үнэлж байна. Цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ямар үйл ажиллагаа төлөвлөж байгаа бол?

-Өнгөрсөн тавин жилд бидний харилцаа урт замыг туулсан. Үүнд, нэг талаас харилцаагаа цаашид олон талбарт хөгжүүлэх хүрээнд хийгдэж буй ажлууд бий. Нөгөө талаас хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх болон мэдлэг, туршлагаа янз бүрийн талбарт хуваалцах тал дээр тодорхой боломж бий. Энэ онд бидний хэрэгжүүлж буй гол төслүүд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтрах, мөн боловсрол, эрүүл мэндийн салбарт хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэх чиглэлээр ид өрнөж байна.

Монгол Улсын цаашдын хөгжлийн шийдэгдэх энэ чухал үе шатанд Их Британи улстай харилцах харилцаандаа илүү дотно, үр өгөөжтэй түншлэлийг бий болгосноор томоохон гэрээ, хэлцэл хийх боломжтой. Үүний гол зангилаа нь хамтын үнэ цэнэ болон харилцан итгэлцлийн байр сууринаас хамтдаа урагшлахад өөрсдийгөө зориулж буй зорилгоо улам өргөжүүлэхэд оршино.

-Та манай улсад ирээд нэгжилийн нүүр үзэж байна. Энэ хугацаанд амжуулсан гол ажлуудаасаа ярина уу?

-Өнгөрсөн онд хамтын ажиллагааны хүрээнд олон ажил хийгдсэн. Ялангуяа бид батлан хамгаалах асуудлаарх хамтын хэлэлцээрээ дэвшилтэт шатанд гаргаж чадсан. Тухайлбал, хоёр улсын зэвсэгт хүчний хоорондох харилцааг сайжруулж, салбарын болон аюулгүй байдлын асуудлаар ойр дотно хамтын ажиллагааны суурийг тавьсан.

Батлан хамгаалахын санамж бичиг үйлдсэн.

Түүнчлэн Монгол Улсын бага болон дунд боловсролын сургуулиудыг Кэмбрижийн боловсролын тогтолцоо руу шилжүүлэх зэрэг асуудалд дэвшил гарсан. Эрүүл мэндийн салбарын туршлагатай мэргэжилтнүүд солилцох хөтөлбөрийг хэрэгжүүлж, өөрсдийн мэдлэг, экспертизээ түлхүү хуваалцаж эхэлсэн. Мөн Их Британийн зүгээс өргөн хүрээг хамрах туршлагаа хуваалцах саналыг Монголын талд дэвшүүлээд байгаа. Учир нь манай улс харилцан ашигтай хөрөнгө оруулалтын туршлагаараа хөгжилтэй гүрнүүд дундаа тэргүүлдэг гэж ойлгодог. Энэ салбарт бидний хийж чадах зүйлээс ч илүү сайн гэрээ, хэлцэл хийх боломжтой бөгөөд Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой манай улсын туршлага, нэвтэрхий ухаан, экспертизийг хуваалцах боломж улам нээгдээсэй гэж хүсч байна.

Эцэст нь хэлэхэд Монгол Улсын ногоон хөгжлийг дэмжих, Мянганы хөгжлийн зорилт дуусгавар болох 2015 оноос хойшхи Монгол Улсын хөгжлийн чиг, хандлагыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх тал дээр НҮБ-тай нягт хамтран ажиллаж байгаа болно. Их Британи улсаас үзүүлж болох хамгийн сайн туршлага, мэдлэгийг хуваалцах, үүний тулд хоёр орны хувьд харилцан хамгийн ашигтай байх тэдгээр зүйлт бид анхаарч буй.

-Ойрын ирээдүйд ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байна вэ?

-Лондон хотын дарга Рожер Гиффорд энэ сард Монгол Улсад айлчлах гэж байгаа бөгөөд тэрбээр Их Британийн санхүүгийн төв хамгийн том хотыг захирдаг нэгэн. Тэрбээр манай улсын санхүүгийн салбарын томчуудын нэг учраас Улаанбаатар хотод айлчлал хийж байгаа нь түүний хувьд, түүний бараа бологсод, бизнесийн төлөөллийн хувьд ч Монгол Улсын цаашдын хөгжил, цэцэглэлтэд чухал ач холбогдолтой, салбарын голлох бизнесийн хүмүүстэй ажил хэргийн уулзалт хийж, холбоо тогтоох сайхан боломж нээгдэж буй хэрэг юм. Түүний айлчлал нь Монгол Улсын хувьд ч гэсэн дэлхийн хамгийн нөлөө бүхий санхүүгийн төвтэй хамтран ажиллах гойд онцгой боломж байх

болно.

-Бизнес, хөрөнгө оруулалтын салбар дахь хоёр орны хамтын ажиллагааны амжилтын үндэс Таны бодлоор юу вэ?

-Хоёр орны хоорондох хамтын ажиллагаа цаашид амжилттай байх гол үндэс нь өнөөгийн салбарыг цаашид хөгжүүлэх, мөн хоёр орны хувьд харилцан ашигтай байх боломжоор хангах гадагш, дотогш чиглэсэн хөрөнгө оруулалт хийх боломжтой шинэ салбаруудыг нээж өгөх. Ялангуяа боловсролын салбарт хамтын ажиллагаа ид өрнөж байгаа миний бие харж байгаа бөгөөд яг л энэ арга барилаа цаашид хадгалах нь чухал юм. Тухайлбал, Их Британид олон монгол оюутан суралцуулах тал дээр БШУЯ-тай хамтран ажилласнаар Их Британид сургууль төгсөгчдийн тоо улам нэмэгдэнэ. Цаашид харилцаагаа улам сайжруулснаар бид хоёр улсын бизнесийн байгууллага, компаниудын хоорондоо бизнес хийх боломжийг улам нэмэгдүүлэх боломжтой. Түүнчлэн бидний зүгээс харилцан санал болгож буй зүйлс маань хоёр орны хувьд аль алинд нь зохист хэмжээнд ойлгогдож буй эсэхийг баталгаажуулж байх шаардлагатай.

Бид хамтдаа хийж бүтээх зүйлс их байгаа нь эргэлзээгүй. Тус тусын бизнесийнхний боловсролыг буй боломжийнхоо хэрээр анхаарах нь бидний хичээл зүтгэлд юуны түрүүнд тавигдах ёстой зүйл. Лондонд Монгол Улсаас суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд Н.Тулгаа энэхүү мэдээллийг түгээхээр шургуу ажиллаж байгаа нь миний бие Улаанбаарт ажиллаж байгаагаатай яг адилхан. Үүнээс гадна амжилттай хамтын ажиллагааг бэхжүүлэх гүн гүнзгий бөгөөд харилцан итгэлцэл бүхий харилцааг бий болгох хэрэгтэй юм. Энэхүү харилцаа нь хэн хэндээ харилцан ашигтай, нээлттэй, ил тод, шударга өрсөлдөөн бий болгоход чиглэх болно. Эдгээр нь бизнесийн амжилттай түншлэл, удаан хугацаанд тогтвортой харилцааг авчрах боломжтой. Монгол Улсын хөгжлийн хамгийн чухал цаг үед эдгээр хүсэл эрмэлзэлдээ хүрэхэд дэмжлэг болох чухал үйл явдлуудын нэгээхэн хэсэг болж байгаадаа миний бие маш баяртай байна. ■

СУДАЛГАА

АНГЛИ ДАХЬ
МОНГОЛ СУДЛАЛ

Монгол судлаач Алан Сандерс, Хар балгас

Х.ХАЛИУН

Даяаршил хэмээх нэр томъёо олон түмэнд танигдахаас өмнө улс хоорондын харилцаа холбоо нь дипломат бодлогын нэгэн чухал хэсэг байв. Энэхүү ойлголтыг дэлхийн томоохон эзэнт гүрнүүдийг эзэрхэн ноёрхож байсан англичууд ч монголчууд ч хэрэгжүүлж байсан билээ. Тухайлбал, Англи, Монголын хооронд тогтоож байсан харилцааны талаар Хенри Ховортын “Монголчуудын Түүх”, Самуэль Коулрижийн “Хубилай Хаан”, Жеймс Гилморын “Монголчуудын дунд” зэрэг бүтээлд өгүүлсэн байдаг. Түүнчлэн түүхч Эдуард Гиббоны (1737-1794) зургаан боть бүхий “Ромын эзэнт гүрний уналтын түүх” номонд Чингис хааны гаргасан хууль цаазыг сайшаан магтсан бол яруу найрагч, гүн ухаантан Самуэль Коулриж (1772-1834) “Хубилай Хаан” шүлэгтээ монголчуудын амьдралыг мөрөөдлийн зураглалаар дүрсэлжээ.

Ийнхүү XIX зууны хэл судлаач, түүхч, шинжлэх ухааны салбарынхан болон шашны тэргүүнүүд нь Монголын тухай анхны бүтээлүүдийг туурвисан аж. Британийн улс төрч, түүхч, геологич Ховорт (1842-1923) 1876-1888 оны хооронд Монголын түүхийн талаар гурван боть ном гаргасан нь Монгол

судлалд томоохон хувь нэмэр оруулсан.

Ховортын дараа Английн шинжлэх ухааны ололтыг түгээн дэлгэрүүлэх зорилготой шашны тэргүүн нар Монгол нутгаар аялахын зэрэгцээ шинжилгээ, бүтээлээ туурвиж байжээ. Тухайлбал, шашны зүтгэлтэн Жеймс Хилмор 1870-1871 онд Монгол орноор аялж амьдарч байхдаа гурван ном бичиж үлдээснийг дурдаж болно.

Дэслэгч Жералд Чарльз Бинстийд (1885-1915) Монголд байх хугацаандаа худалдаа болон улс төрийн нөхцөл байдлын талаар тайлан мэдээлэл бэлтгэдэг байжээ. Түүний аяллынхаа үеэр авсан гэрэл зургууд түүхийн ховор баримт болж үлдсэн байна. Хэдийгээр тэрбээр Монголын тухай ном туурвиагүй боловч түүний бичсэн “Халх сүм хийдийн ахуй” нэртэй өгүүлэл нь олон судлаачийн анхаарлыг татдаг аж.

XX зууны эхэн хагаст Британи дахь Монгол судлал нь хязгаарлагдмал хэвээр байв. Лондоны их сургуулийн Дорно ба Африкийн судлалын тэнхимд Монгол судлалын багшаар ажиллаж байсан судлаач Алан Сандерсийн бичсэнээр Их Британи Монголыг улс төрийн хувьд сонирхоогүй ч дэлхийн II дайны дараа манай тусгаар тогтнолыг бусад орноос түрүүлэн хүлээн зөвшөөрчээ. МУИС-ийн Монгол судлалын тэнхимийн эрхлэгч Ж.Бат-Ирээдүй “Алс Дорнодын судлаач Овен Латтимор болон Өвөр Монгол гаралтай нэрт профессор Онон Өргөнгөө нар Америкаас Англид очсоноор Монгол судлал дахин сэргэсэн хэмээн нийтлэлдээ тэмдэглэсэн нь бий. Үнэхээр ч 1963 онд Англид “Англи-Монголын нийгэмлэг” байгуулагдсанаараа Англи дахь монголч эрдэмтдийн үйл ажиллагааг

сэргээхэд том үүрэг гүйцэтгэсэн юм.

Лондонгийн их сургуулийн профессор Чарльз Бауден анх 1955 онд Монголын нууц товчооны дараа орох нэр хүндтэй бүтээл “Алтан Товч”-ийн судалгааг хийж хамгийн түгээмэл хэрэглэгчтэй Монгол-Англи толийг туурвижээ.

ВВС агентлагт сэтгүүлчээр ажиллаж байсан Алан Сандерс Монголын улс төр, эдийн засгийн талаар хэдэн арван нийтлэл, ном бичсэн нь бий. Тэрбээр Англи-Монголын дугуй ширээний уулзалтыг уламжлал болгосон бөгөөд үүсгэн байгуулагчдын нэг билээ. Түүний “БНМАУ: Ерөнхий хөтөч” (1968), “Монголын түүхийн толь бичиг” (1996, 2003, 2010), “Ярианы монгол хэл” (Бат-Ирээдүйтэй хамтарч), “Анхан шатны иж бүрэн сурах бичиг” (1999) зэрэг нь олон судлаач, оюутан, эрдэмтдийн оюуны санд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

Судалгаа шинжилгээний ажилд бүхий л амьдралаа зориулсан Онон Өргөнгөө нь Азийн тухай сэтгүүлийг үндэслэсэн нь эдүгээ ирээдүйн судлаачдыг олноор нь бэлтгэхэд зохих ёсны хувь нэмрээ оруулж байна. Түүний “Монголын нууц товчоо: Чингис хааны амьдрал” хэмээх ном нь XIII зууны сор болсон бүтээлийг англи хэлээр дахин амилуулснаар олон уншигчийн талархлыг хүлээжээ.

Кэмбрижийн их сургуулийн профессор Кэролин Хамфри Монгол, Орос, Хятад, Энэтхэгийн талаар хэдэн зуун нийтлэл, эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн нэгэн. Түүний 2010 онд гаргасан “Цагийг эзэлсэн хийд: Монголын буддизмын талаар” ном нь түүний 1995 онд хийсэн Өвөр Монголын Урад нутгийн Мэргэн хийдийн судалгааны ажлын тайланг дэлгэрэнгүй тусгасан байна.

Түүнчлэн Кэмбрижийн их сургуулийн хувьд Ази судлалын тэнхим Монгол судлалын хөтөлбөрөө гүнзгийрүүлсэн бол Лийдсийн их сургуулийн дэргэдэх Зүүн Ази судлалын тэнхим энэ чиглэлийн сургалтаа зогсоосон байна. Харин Лондонгийн их сургуулийн Дорно ба Африкийн судлалын тэнхим дээр сүүлийн 18 жил монгол хэлний хичээл ороогүй байна. Өнөө үед Монголын түүх, соёлын талаар олон зуун ном Английн их, дээд сургууль, номын сангуудад байдаг ч Монголын талаар судлах сонирхолтой бие даасан судлаач, багш болон оюутнууд цөөн байх аж. ■

ФОТО МЭДЭЭ

Одоогоос 100 жилийн өмнө Жеральд Чарльз Бийнстийд Монгол Улсын нийслэл Өргөөг зорьж байсан түүхтэй. Их Британийн цэргийн Эссэкс хорооны дэслэгч манай орноор нэг бус удаа аялж, тухайн үеийн аж амьдралын талаар сонирхолтой дурсамж, тэмдэглэл үлдээсэн нь бий. Аяллын тэмдэглэлдээ арилжаа наймаа, эдийн засгийн үйл ажиллагаанаас эхлээд Монголын сүм хийд, иргэдийн амьдралыг бодитоор дүрсэлсэн аж. Тэрбээр олон гэрэл зураг үлдээсэн байна. Тэдгээр нь манай түүхийн санд ховор нандин дурсгал болж мөнхөрсөн юм. Монголын Үндэсний түүхийн музейд энэ оны зургаадугаар сарын 25-30-ны хооронд Бийнстийдийн гэрэл зургаар үзэсгэлэн гаргасан билээ. Түүхийн ховор зургийн заримаас нь толилуулж байна.



Сүжигт гүн, гэргий, ах лам, хүүгийн хамт Өргөө хотноо



Өргөө хотын худалдааны захын нэг булан




Аяны хувцастай лам



Сүжигт гүнгийн хошуу. Момбын сүмийн дэргэд бүрээ үлээж байгаа нь



Сүжигт гүнгийн хошууны лам нар, хүүхдүүд



Саруул Гүнгийн хошуу засаг



Саруул гүнгийн хошуу. Гэрийн дээр хэлхэж өлгөсөн хийморийн дарцаг



Сахил, санваараа зөрчсөн лам нарт оноох дөнгө шийтгэл



Сүжигт гүнгийн лам банди нар



Чин Вангийн Хошууны сүм хийд



Эдинбург хотноо зохион байгуулсан Цэргийн хөгжмийн олон улсын наадамд оролцож буй Монгол Улсын Зэвсэгт хүчний Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн. 2013.8 сар

СОЁЛ УРЛАГ

БРИТАНИЙН ТЭНГЭР ДООРХ МОНГОЛ АЯЛГУУ

Энэ жил тохиож буй 50 жилийн ойн хүрээнд Монгол болон Их Британийн талаас олон арга хэмжээ хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Эдгээрийн нэг нь тус улсын Эдинбург хотноо зохион байгуулсан Цэргийн хөгжмийн олон улсын наадамд Монгол Улсын Зэвсэгт хүчний Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүнийг анх удаагаа оролцуулах асуудал байсан юм.

Энэхүү наадам нь 1950 оноос хойш зохион байгуулагдаж байгаа дэлхийн цэргийн хөгжимчдийн томоохон үзүүлбэрүүдийн нэг бөгөөд уг тоглолтыг жил бүр 200 гаруй мянган үзэгч үздэгийн 35 орчим

хувь нь хилийн чанадаас очдог байна. Наадмын үеэр цэргийн хөгжимчдийн үзүүлбэрээс гадна оролцож буй орны талаар танилцуулга, үндэсний онцлогыг илэрхийлсэн бусад арга хэмжээг өргөнөөр зохиодог нь улс орноо сурталчлах томхон завшаан болдог. Энэ жилийн наадмын бас нэг онцлог нь цог жавхланта Хатан Хааны хаан ширээнд заларсны 60 жилийн ойтой давхацсанаараа илүү олон жуулчны анхаарлыг татжээ.

Эдинбург хотноо “Рояль Эдинбург Милитари Тату-2013” олон улсын цэргийн хөгжмийн наадам 2013 оны наймдугаар сарын 2-24-ний өдрүүдэд өдөр бүр 1-2 тоглолт хийсэн байна. Манай цэргийн хөгжимчдийн ▶



Эдинбург хотноо. Цэргийн хөгжмийн олон улсын наадам

» төлөөлөл тус наадамд оролцож байгаа нь хоёр орны дипломат харилцааны бэлгэдэл төдийгүй Монгол Улсын түүх, соёл, урлаг, зан заншил, уламжлалыг олон улсад сурталчлах чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

Эдинбург хотын түүхт цайзын дэргэд тусгайлан засаж тохижуулсан цэнгэлдэх хүрээлэнд Монгол Улсын Зэвсэгт хүчний Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн, 70 гаруй цэргийн алба хаагч, мөн БНСУ, Шинэ Зеланд, Мексик, Оман, Мальта, Шотланд, Ирланд болон Их Британийн цэргийн үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн оролцон “Гайхамшигт эх дэлхий” сэдвийн

дор олон улсын цэргийн хөгжмийн наадам үргэлжилжээ.

Тус цэргийн хөгжмийн олон улсын наадамд манай урлаг соёлын салбараас оролцуулсан нь Их Британи улстай харилцаа хамтын ажиллагаагаа улам гүнзгий түвшинд өргөжүүлэх цэрэг улс төрийн чухал ач холбогдолтой аж.

Энэхүү арга хэмжээнд Монгол Улс өөрийн иргэний агаарын тээврээр Эдинбург хотод хүрэлцэн очсон нь бас нэг онцлог үйл явдал олсон юм.

Монгол Улсын цэргийн хөгжимчдийн тоглолтыг олон хүн үзэж сонирхсон бөгөөд англичууд Чингис хааны үр садын авьяас билгийг бахдан биширсэн байна. ■

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

МОНГОЛ УЛСЫН МЕГА ТӨСЛҮҮД

Б.АЛТАЙ



Тавантолгой

Дэлхийд коксжих нүүрсний нөөцөөрөө эхний аравт багтах Тавантолгойн орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Улаан нуурын хөндийд буй. Уг стратегийн орд нь зургаан тэрбум тонн нүүрсний нөөцтэй бөгөөд үүний 1.4 тэрбум нь коксжих нүүрс бол 4.6 тэрбум нь эрчим хүчний нүүрс. Тус ордыг төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” компани эзэмшиж байна. Ирэх 2016 он гэхэд Тавантолгойн ордоос жилдээ 20 сая тонн нүүрс олборлохоор тооцож буй. Тус ордын Баруун цанхийн уурхай өнгөрсөн наймдугаар сард нүүрснийхээ анхны экспортыг хийлээ.

Тавантолгой орд нь Зүүн, Баруун цанхиас бүрдэх бөгөөд жилд тус бүр 20 сая тонн нүүрс олборлох дэлхийд тэргүүлэх хэмжээний уурхай болох зорилт тавьсан. Баруун Цанхи ордын нөөцийн тухайд олон улсын Жорк стандартаар 1.2 тэрбум тонн гэж тогтоожээ. Баруун Цанхиас 2014 онд дөрөв, 2015 онд 12, 2017 онд 20 сая тонн нүүрс олборлож, 2016 онд нүүрс баяжуулах, угаах үйлдвэр ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.

Уурхайн эрчим хүчний асуудлыг шийдвэрлэхээр Засгийн газраас Тавантолгойн ордын Зүүн цанхийн уурхайг түшиглэн 300 мВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барих зөвшөөрөл олгоод байна. Одоогийн байдлаар цахилгаан станц барих судалгааны ажил дууссан бөгөөд техник эдийн засгийн үнэлгээ /ТЭЗҮ/-г дахин нягталж байгаа аж. Уг станцын ажлыг энэ онд эхлүүлж 2016 онд

эхний хэсгийг ашиглалтад өгөх юм.

Цахилгаан станцыг ашиглалтад оруулахад 600-800 сая ам.доллар шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоо бий. Эхний ээлжинд Монгол Улсын Хөгжлийн банкнаас 50 сая ам.доллар олгоод байна. Үүнээс 1.9 сая ам.доллар нь төслийн үйл ажиллагааны зардал болох аж. Цахилгаан станц барьж байгуулснаар орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах боломж бүрдэх юм байна. Цахилгаан станцыг гурван жилийн хугацаанд барьж байгуулах бөгөөд оргил үедээ 3000 орчим ажлын байр, үйлдвэрлэлийн хэвийн үе шатанд 500 гаруй шинэ ажлын байр бий болох юм.

Цахилгаан станц нь Европын холбооны байгаль орчны стандартад нийцсэн орчин үеийн хуурай аргын технологи ашиглах тул байгаль орчинд ээлтэй байх аж. Төлөвлөж буй боловсруулах үйлдвэр жилд дунджаар 13.4 сая тонн коксжих нүүрс, 3.8 сая тонн засврын бүтээгдэхүүн буюу эрчим хүчний нүүрс үйлдвэрлэж экспортод гаргах юм.

Оюутолгой



Дэлхийн гурав дахь том зэсийн уурхай. Зэс, алт, мөнгө, молибден агуулсан уг орд нь Улаанбаатар хотоос өмнө зүгт 600 км, Монгол, Хятадын хилээс хойд зүгт 80 км-ын зайд Өмнийн говь нутагт оршдог. Оюутолгой төслийн Баяжуулах үйлдвэр нь цагт 100 мянган тонн, жилд 35 сая тонн зэсийн баяжмал боловсруулах хүчин чадалтай. Үйлдвэрлэлийн хүчин чадлаараа Монгол Улсын хамгийн

► том бүтээн байгуулалт төдийгүй өндөр технологи бүхий аж үйлдвэрийн цогцолбор юм.

Уурхай 2019 оноос бүрэн хүчин чадлаараа ажиллах бөгөөд 2017 он гэхэд гүний уурхайг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Учир нь нийт баялгийн 80 гаруй хувийг далд уурхайгаас олборлоно. Тиймээс ирэх зургаан жилийн хугацаанд төслийн барилга, бүтээн байгуулалтын ажил үргэлжилнэ гэсэн үг. Одоогийн байдлаар “Рио Тинто” компаниас далд уурхайн хөрөнгө оруулалтаа түр зогсоогоод байна. Тус орд нь хамгийн багадаа 50 жилийн хугацаанд ашиглахуйц хэмжээний нөөцтэй. Оюутолгой төслийн эхний үе шатын нийт хөрөнгө оруулалт нь 6.2 тэрбум ам.долларт хүрээд байна. Уг төсөл нь Монгол Улс дахь томоохон ажил олгогч юм. 2020 гэхэд төслийн үр дүнд Монголын эдийн засаг 35 хувиар өсч, төслөөс жилд дунджаар 800-900 тэрбум төгрөгийн орлого олох юм.

Шинэ төмөр зам



“Шинэ төмөр зам төсөл нь Монголын улс төр, эдийн засаг, нийгэмд асар их нөлөө үзүүлэх мега төсөл” хэмээн Монгол Улсын Засгийн газрын тэргүүн Н.Алтанхуяг онцлон тэмдэглэсэн. Өнөөдрийн тооцоогоор төсөлд шаардагдах санхүүжилт 5.5 тэрбум ам.доллар. Уг төсөл хамрах хүрээ болон хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ дэлхийн түвшнийх. Шинээр барих төмөр замын урт нь 1800 км.

“Шинэ төмөр зам” төслийг эрчимжүүлэхэд Засгийн газар “Чингис бонд”-ын хөрөнгөнөөс Хөгжлийн банкаар дамжуулан 200 сая ам.долларын санхүүжилт олгохоор зөвшөөрч дээрх хөрөнгөнөөс “Монголын төмөр зам” ТӨХК-д 83.3 сая ам.доллар шилжүүлсэн. Төслийн хүрээнд Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэл нийт 267 км төмөр зам тавих бүтээн байгуулалтын ажил өрнөж байна.

Шинэ төмөр замыг барьснаар Оюутолгой, Тавантолгой зэрэг ордоос олборлох эрдэс баялгийг Сайншандын аж үйлдвэрийн цогцолборт хүргэж, нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Мөн дээрх бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд хүргэх, Дулааны V цахилгаан станц зэрэг нийгэм эдийн засгийн бусад мега төслийг амжилттай хэрэгжүүлэх суурь болно гэж Засгийн газраас онцолж буй. Шинээр барихаар төлөвлөсөн төмөр замын бодлого нь дэд бүтцийн салбарт төдийгүй

уул уурхайн салбарын хөгжилд томоохон хувь нэмэр оруулахын зэрэгцээ экспортыг нэмэгдүүлэх эерэг талтай. Түүнчлэн дотоодод олборлож буй ашигт малтмалыг олон улсын зах зээлд нэвтрүүлэх “гүүр” төсөл хэмээн тодотгосон билээ.

“Шинэ төмөр зам” төслийн нэгдүгээр болон хоёрдугаар үе шат буюу Тавантолгой–Сайншанд–Баруун-Урт-Хөөт–Чойбалсан, Хөөт-Нөмрөг, Таван толгой–Гашуун сухайт чиглэлийн 1800 км орчим төмөр замыг барьж байгуулах ажлыг дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагчдын оролцоотойгоор 2016 он гэхэд дуусгахаар төлөвлөөд байна. Нэг км төмөр замын суурь бүтцийг 2.5-2.8 сая ам.доллараар барих урьдчилсан тооцоо бий. Төмөр замын төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төрөөс эхний ээлжинд санхүүжүүлж байгаа.

Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор

Үндэсний хэмжээний томоохон төслийн нэг нь Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор. Тус төсөл нь Монгол Улсад аж үйлдвэрийн эрин үеийг эхлүүлэх онцгой ач холбогдолтой. Төслийн мастер төлөвлөгөөг АНУ-ын “Бэктэл” компани боловсруулжээ. Төсөл амжилттай хэрэгжсэнээр 2019 он гэхэд сүүлийн үйлдвэр ашиглалтад орно гэж тооцож байгаа. УГ төсөл нь “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” нэртэй төрийн өмчийн оролцоотой хаалттай хувьцаа компани нэрийн дор үйл ажиллагаа явуулж байна. Цогцолбор ашиглалтад орсноор 12 мянган ажлын байр шинээр бий болохын зэрэгцээ уул уурхайд ажиллах хүмүүсийн тоо 68 мянгад хүрнэ. Цогцолборын мастер төлөвлөгөөний дагуу нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь 10 тэрбум 986 сая ам.доллар гэсэн урьдчилсан тооцоо гарчээ.

Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт баригдах аж үйлдвэрийн цогцолбор нь стратегийн хэд хэдэн давуу талтай. Тус цогцолбор нь Оюутолгой, Тавантолгой болон зүүн бүсэд буй газрын тосны сав нутагт байрлана. Төсөл хэрэгжсэнээр 2013-2021 онд ДНБ дунджаар 15.8 хувиар өсөх боломжтой. Үүний 57 хувь аж үйлдвэрийн салбарт, 14 хувь нь газрын тос боловсруулах үйлдвэрт ногдох аж.

Бусад төсөл:

- Нүүрс химийн үйлдвэр ►►



- Газрын тос боловсруулах үйлдвэр / өдөрт 25-30 мянган баррель тос боловсруулна/
- Зэс хайлуулах үйлдвэр /жилд 300 мянган тонн зэс боловруулна/
- Барилгын материалын үйлдвэр /жилд нэг сая тонн цемент дотоодын зах зээлд нийлүүлнэ/
- Ган болон төмөрлөгийн үйлдвэр / жилд 4.5 тонн үрлэн төмөр үйлдвэрлэнэ/
- Хорголжин төмрийн үйлдвэр
- Ангижуулсан төмрийн үйлдвэр
- Дулааны цахилгаан станц

Дулааны V цахилгаан станц

Улаанбаатар хотыг дулааны шинэ эх үүсвэрээр хангах V цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгчээр Япон, Солонгос, Франц, Монголын хамтарсан консорциум шалгарсан. Тус консорциум нь станцын ажлыг 1.2 тэрбум ам.долларын өртгөөр 3.6 жилийн хугацаанд барьж ашиглалтад оруулах бөгөөд зардлаа 25 жилийн дотор нөхөж улсад хүлээлгэн өгөх аж. Арав гаруй жилийн турш цаасан дээр хэдэнтээ сүндэрлэсэн V цахилгаан станцын төсөл ийн бодит ажил хэрэг болох нь ээ. Уг нь энэ онд багтан V ДЦС-ын эхний блокыг барьж ашиглалтад оруулахаар байсан ч товлосон хугацаанд төсөл хэрэгжсэнгүй.

Тус станц нь жилд хоёр сая тонн орчим нүүрс хэрэглэх бөгөөд нүүрсний хэрэглээ нь манай улсын нүүрс олборлолтыг нэмэгдүүлж, салбарын хөгжилд томоохон туслалцаа үзүүлэх юм. Цахилгаан станцыг Баянзүрх дүүргийн 11-дүгээр хорооны нутаг дэвсгэр болох Хөлийн голын хөндийд 43 га талбайд байгуулахаар Засгийн газраас баталсан. Станцын хүчин чадал нь 450 мВт.

Станцын төсөлд шалгарсан дөрвөн орны консорциум нь Францын хамгийн том цахилгаан үйлдвэрлэгч болох "GDF Suez", Солонгосын "Posco energy", Японы "Sojitz Corporation", Монголын "Newcom LLC" групп гэсэн компаниудаас бүрдэж байгаа юм. Төслийн байгаль орчны үнэлгээг энэ онд багтаан хийх аж. ■



ЗОЧИН

НИК БАЙРД: МОНГОЛЫГ СОНИРХОЖ БУЙ КОМПАНИУД ОЛОН БИЙ

Б.ЭНХЦЭЦЭГ

Ник Байрд нь 2011 оноос Их Британийн Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлагт Гүйцэтгэх захирлаар дэвшин ажиллаж эхэлсэн байна. Үүний өмнө тэрбээр тус улсын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны яамны харьяа Европын Холбооны албаны даргаар ажиллаж байжээ. "Mongolian Escopoty" сэтгүүлийн тусгай баг Лондон дахь сурвалжлагынхаа үеэр Их Британийн Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлагт зочилж, түүнтэй ярилцсан юм.

-Монголын сэтгүүлчдийг хүлээн авч, ярилцаж байгаад талархаж байна. Ер нь ямар хүчин зүйлс Их Британийг дэлхийн хэмжээний түнш болгодог вэ гэдгээс ярилцлагаа эхэлье?

-Би Их Британи улсыг гурван шалтгааны үүднээс шилдэг хамтрагч гэж үнэлдэг. **Нэгдүгээрт**, манай улсын эдийн засаг өргөн хүрээнд төрөлжсөн байдаг. Тийм учраас манай компаниудын бүхий л талбар дахь үйл ажиллагаа дотоодынхоо төдийгүй бусад улсын эдийн засгийн хөгжлийг дэмжиж байна. **Хоёрдугаарт**, Английн компаниуд гаднын улс орнуудтай нягт түншилж ажилладаг. Тэд зөвхөн гэрээлсэн бизнесийн ашиг хөөцөлддөггүй. Өөрөөр хэлбэл, Английн компаниуд байгаль орчинд дэмжлэг үзүүлж, боловсон хүчний сургалт, голлох төслүүдэд дэд бүтцийн бүтээн байгуулалтыг авчирдаг. **Гуравдугаарт**, хөрөнгө оруулахад хамгийн тааламжтай орон. Өндөр хөгжсөн томоохон эдийн засагтай орнууд дундаа манай эдийн засгийн орчин хамгийн нээлттэй нь бөгөөд Европ тивдээ нэгдүгээрт ордгийг баттай хэлэх байна.

-Томоохон орнуудын эдийн засаг бүдчиж буй энэ үед дэлхийн хөрөнгө оруулалт, гадаад худалдааны орчинд ямар өөрчлөлт, сорилтууд гарч ирж байна вэ?

-Дараагийн эринд эдийн засгийн бодит өсөлт Ази, Латин Америк, Африкийн орнуудаас хамаарахаар байгаа нь өнөөдөр ▶



Фотг Э.Зоригт

Их Британийн Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлагийн
Гүйцэтгэх захирал Ник Байрд

► стратегийн хамгийн том асуудал болж буй. Европ, Америк зэрэг хөгжингүй орны хувьд үүнд дасан зохицож ажиллах шаардлагатай. Үүний тулд бидний үзүүлж буй үйлчилгээ, бүтээгдэхүүн тэдгээр улсын хэрэгцээ, шаардлагад нийцэж буй эсэхт анхаарал хандуулах хэрэгтэй болж буй. Мөн тус орнуудын хөрөнгө оруулалт нээлттэй байх ёстой. Энэ нь Их Британийн Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлагийн туйлын зорилго. Шинээр гарч ирж буй зах зээлүүдтэй экспортын салбараараа холбогдож, хөрөнгө оруулалт татах нь бидний бас нэг гол чиглэл.

-Танай агентлаг Монголд төлөөлөгчтэй. Тэгвэл Монгол Улс дахь үйл ажиллагааны гол баганууд нь юу вэ?

-Манайх Монгол тэргүүтэй олон улсад биднийг төлөөлсөн баг, хамт олонтой. Тэдний хувьд аливаа компанийн бизнесийн үйл ажиллагаа том, жижгээс үл хамааран тодорхой үйлчилгээ үзүүлдэг. Тухайлбал, тодорхой нэг улсын зах зээлийн судалгаа, хууль эрх зүй, зохицуулалтын асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгдөг. Гэхдээ бид бизнесийн үйл ажиллагаа явуулах бүрэн чадвартай компаниудтай харилцан холбоотой хамтран ажилладаг.

-Өнөөдөр Монгол Улсад ямар төрлийн дэмжлэг хэрэгтэй байна гэж та бодож байна вэ?

-Их Британийн компаниудын хувьд Монгол ихээхэн сонирхол татсан зах зээл байгаа. Хурдан өсч буй зах зээл хэдий ч манай компаниудад төдийлэн сайн танигдаагүй байна. Тиймээс өнөөдөр гол асуудал нь Монголд эдийн засгийн бодит өсөлтийг бүрдүүлэгч уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, жижиглэнгийн тэргүүтэй салбарт гарч ирж буй боломжуудыг манай компаниуд илүү сайн олж харахад чиглэж байна. Харилцан мэдээлэл солилцох шаардлагатай.

-Танай агентлагийн Монгол дахь урт хугацааны бодлого, чиглэл юу вэ. Үйл ажиллагаагаа хэрхэн тэлэхээр зорьж байна вэ?

-Бид Монголын эдийн засгийн хөгжлийн голлох талбаруудад өөрсдийн ур чадвар болон компаниудаа нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тэр дундаа уул уурхайн салбарт нягт уялдаж ажиллах хүсэл бий. Монголын компаниудтай аль хэдийнэ хамтраад эхэлчихсэн. Тухайлбал, манай томоохон компаниуд, тэр дундаа "Рио Тинто" болон ханган нийлүүлэгч сүлжээ компаниуд уул уурхайн салбарт төхөөрөмж, үйлчилгээг үзүүлэх тухай юм. Аажимдаа тус салбарын бүхий л шатанд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дотоодын хүний нөөцийн чадавхыг өсгөхөд туслахыг мөн хүсч байна.

Улмаар Монголын хөгжүүлэхийг хүсч буй бусад талбарт ч хамтрах сонирхолтой байгаа. Ингэснээр эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, бусад салбараа чадавжуулахад хэрэгтэй дэд бүтцийг шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ. Монголын эдийн засгийн хөгжлийн ирээдүйн түвшин, төрөлжилтэд тохирох мэргэжилтнүүдээ бэлтгэж чадах боловсролын системтэй болох, мөн эрүүл мэндийн салбараа төрөлжүүлэхэд бид туслахыг хүсч байгаа.

Манай улсын олон банк санхүүгийн байгууллага Монголын томоохон төслүүдийн санхүүжилтэд оролцох сонирхолтой байгаа. Монголд дундаж давхаргынхан нэмэгдэх тусам жижиглэнгийн бизнес эрхлэгчдийн хувьд илүү сонирхолтой боломжууд гарч ирж буй нь харагдаж байна. Хэдийгээр бусад улстай харьцуулахад Монголын дундаж давхаргын хүн ам бага ч үүнээс үл шалтгаалсан хөгжлийн өндөр үзүүлэлт энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын сонирхлыг өдөөж байна.

-Их Британийн жижиг, дунд, том хэмжээний бизнес эрхлэгчдээс аль нь илүүтэй Монголыг сонирхож байна вэ?

-Зах зээл нь өөрөө одоохондоо шинэ, танил бус байгаа учир эрсдэл үүрэх чадвар бүхий хөрөнгөтэй томоохон компаниуд л эхэлж орж байна. Үүний хажуугаар "адал явдал хайгч" жижиг компаниуд ч бий. Тэдний үйл ажиллагааны туршлагыг харж байгаад бусад нь ч дагаад ороод ирнэ. Гагцхүү хууль эрх зүйн орчин, бизнес эрхлэхэд гардаг асуудлууд, боломж бололцоо юу байна гэдэг тал дээр мэдлэг, мэдээлэл тэдэнд өгөх хэрэгтэй. Монголыг сонирхож буй Англи компаниуд олон байна.

-Уул уурхайн салбарт Английн компаниуд хөрөнгө оруулаад эхэлчихсэн ч бусад салбарыг сонирхох төдий байна гэж ойлгож болох уу?

-Тийм, хүсэл сонирхол өндөр байна. Монголын хөгжил ►

► хурдтай урагшилж, дэд бүтцээ хөгжүүлэх тусам энэ сонирхол бодит гэрээ болж хувирах нь мэдээж.

-Танай улсын бизнесийнхний хувьд Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэхэд тулгарч буй хүндрэлүүд юу байна вэ?

-Бизнесийнхэн тодорхой, таамаглаж болохуйц зохицуулалттай орчныг хүсдэг. Хоёрдугаарт, тэдэнд томоохон төслүүдийн талаарх мэдээлэл түрүүлж хүрдэг. Голлох төслүүд олон нийтэд хүртээмжтэй, ил тод байх нь компаниудыг ихээхэн хөшүүрэгддэг. Монголын гэлтгүй бүх зах зээлд энэ хамаатай. Энэ л тэднийг татах соронз. Тэд зах зээлүүдийн хооронд шилжилт хөдөлгөөн хийж, хаашаа ч явж чаддаг хүмүүс шүү дээ.

-Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Оюутолгойг тойрсон шуугиан Монголыг сонирхож буй Английн компаниудад хэрхэн нөлөөлж байна вэ?

-Манай компаниудын сонирхож буй шинэ зах зээлүүдэд ялгаатай сорилтууд бий. Хууль эрх зүйн орчин өөрчлөгдөх асуудал бий. Олон улсын хөрөнгө оруулалтын орчинд шинээр гарч ирсэн улсуудын Засгийн газар хуульдаа өөрчлөлт оруулж тохируулах шаардлага гардаг. Харин хэр хурдан хугацаанд хуулиа сайжруулж, түүнийгээ тогтвортой мөрдөх нь чухал. Хөрөнгө оруулалт тогтвортой эрх зүйн орчинд л орж ирдэг.

-Монгол дахь бизнесийн боломжуудыг хэрхэн үнэлж байна вэ. Хөрөнгө оруулалтаа үргэжлүүлэн нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл, давтан хөрөнгө оруулалт татах зах зээл байж чадаж байна уу?

-Мэдээж тийм. Монгол илүү танил болох тусам Английн компаниудад илүү дөхөм болно.

-Өнөөгийн нөхцөлд Монголын ирээдүйг хэрхэн тодорхойлж байна вэ?

-Шинэ, зорилготой, өөрчлөлтөөр өөрийгөө цэнэглэж байгаа байдал нь хөгжил, хөрөнгөө иргэддээ жигд тарааж, хурдтай өсөн дэвжихийг хүсч буйг харуулж байна. Ийм нөхцөл байдалд буй улсууд хөрөнгө оруулалтын хуулиа өөрчилж, илүү сайн хөрөнгө оруулалтуудыг татах чадварт суралцдаг. Томоохон гүрнүүдээс ирэх хөрөнгө оруулалтыг дагаад авьяас чадал,

сургалт, боловсрол гэхчлэн олон баялаг ороод ирнэ. Энэ бол элгэмсэг эдийн засгийн үр дүн.

-Манай улсад жижиг, дунд компаниуд олноороо үйл ажиллагаа явуулдаг. Тэдний зүгээс танай байгууллагаас ямар төрлийн дэмжлэг авч болох вэ?

-Олон улсад үйл ажиллагаагаа тэлэх сонирхолтой ямар ч компанид Монгол дахь манай төлөөлөгчийн газар туслахад бэлэн. Бид жижиг, дунд бизнесийнхэнтэй Англид хэрхэн бизнес эрхэлдэг талаар ярилцах болно. Энэ тун ойлгомжтой бөгөөд энгийн үйл явц. Манай улсад бизнес эхлүүлэхэд ердөө л 13 хоног шаарддаг ба энэ нь Европт хамгийн хурданд тооцогддог. Их Британид хууль эрх зүйн орчин ихээхэн нээлттэй, ил тод, элгэмсэг байдаг. Урьдчилж тооцоогүй ямар нэг асуудал гарч ирэхгүй гэдгийг баталж байна. Жишээлбэл, манай машин үйлдвэрлэлийн салбар Герман,

Энэтхэг, Япон тэргүүтэй гаднынхны "гарт" байдаг. Гэсэн ч улсдаа ихээхэн өгөөжтэй салбарт тооцогддог юм. Түүнчлэн дэд бүтцийн салбар ч тэр чигтээ гаднынхны өмчлөлд бий. Бид олон улсын эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалтад нээлттэй орон бөгөөд тэдний оролцоог бүрэн хангадаг улс.

-Гаднын зах зээлүүд рүү хараагаа чиглүүлж буй манай компаниудад юу гэж зөвлөх вэ. Англи улсын хувьд тодорхой дагаж мөрдөх шаардлага байдаг уу?

-Тийм онцгойлсон тусдаа шаардлага байхгүй. Хөгжингүй орнуудад хүрээгээ тэлэхээр зэхэж байгаа бол Их Британи зорих ёстой эхний зах зээл гэдгийг хэлье. Английг дэлхийд гарах гарцаа болгож ашиглах нь хамгийн оновчтой. Англи бол санхүүгийн төв. Тиймээс англичуудтай хамтран ажиллах боломжийн олон үүдийг нээнэ гэж хэлмээр байна. ■

ЛОНДОНГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖ

ТҮҮХЭН ТҮНШЛЭЛ

Б.ЦЭЦЭЭ

Санхүүгийн ертөнцийн зүрхэнд оршдог Лондонгийн хөрөнгийн бирж нь дэлхийн эдийн засгийг атгалцдаг олон "акул" компаниудын хувьд "гэр" нь. Үүдээр нь ороход нам гүм ил хуль орчин угтах нь хөдөлгөөнгүйдээ бус хөгжил нь хэтийдсэнд оршино. Лондонгийн хөрөнгийн биржийн арилжаа электрон системд бүрэн шилжчихсэн учир өнөөдөр тус байгууллагын танхимд "авна, зарна" гэх хашгираан түүх болон үлджээ. Харин үүний оронд өдөр мэт гэрэлтэх саруул танхим, Лондонгийн хөрөнгийн бирж гэсэн

гурван үг, тус биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны өсөлт, бууралтыг харуулсан дөрвөн хана дүүрэн дэлгэц угтана. "Jonathan's Coffee-house" нэрээр 1698 онд мэндэлж "Royal exchange" буюу өндөр дээд хэмжээний арилжаа хийгддэг талбар байсан тус хөрөнгийн биржид өнөөдөр Английг илэрхийлэх хаан удмын бэлгэ тэмдэг бүхий логоноос өөр хуучны гэх зүйл үгүй ажээ.

Монгол Улс дэлхийн санхүүгийн зах зээлд хүргэх гүүрээр Лондонгийн хөрөнгийн биржийг сонгоод нэгэнтээ хоёр жил өнгөрлөө. Албан бус тоогоор 300 жилийн түүхийг эргэн сөхдөг Лондонгийн хөрөнгийн бирж ►



Фотог Э.Зоригт

“Mongolian Economy” сэтгүүлийн сэтгүүлчид Лондонгийн хөрөнгийн биржийн Анхдагч зах зээлийн орлогч дарга Жон Эдвардстай ярилцаж байгаа нь. 2013.07 сар

хамгийн хөгшин тоглогчдын нэг ч хамгийн төрөлжсөн, амьд зах зээлд тооцогддог. Зах зээлийн үнэлгээ нь 3.2 тэрбум ам.доллараас давсан тус хөрөнгийн талбар дэлхийд хэмжээгээрээ дөрөвт эрэмблэгдэж байна. Лондонгийн хөрөнгийн биржийн үйл ажиллагааны гишүүнчлэлд 400 гаруй томоохон оролцогч байгууллага, тухайлбал, хөрөнгө оруулалтын банк, үнэт цаасны брокерууд багтдаг. Бусад хөрөнгийн зах зээл дундаа хамгийн “олон улсжсан” хөрөнгийн зах гэдгийг 70 гаруй орны 3000 гаруй компанийн хувьцаа арилжаалагдаж буйгаас харж болох. Хэрэв Америкийн хөрөнгийн биржүүд дотоодын аваргууддаа, Хонконгийн хөрөнгийн бирж Хятадын их далайд найддаг бол Лондонгийн хөрөнгийн бирж дэлхийд найддаг. Өөрөөр хэлбэл, тэд олон улсад гар дүрэхэд хамгийн гүн, хөрвөх чадвар өндөртэй төрөлжсөн хөрөнгийн санг санал болгодог. Тиймээс Монгол Английн хөрөнгийн зах зээлийг бус олон улсын санхүүгийн талбарыг дэлхийд хүрэх гүүрээр сонгосон юм.

“Mongolian Economy” сэтгүүлийн тусгай баг өнгөрсөн долдугаар сард

Лондонгийн хөрөнгийн биржид зочилсон бөгөөд тус биржийн Анхдагч зах зээлийн орлогч дарга Жон Эдвардстай уулзаж ярилцсан юм. Тэрбээр “Бид Монгол, Лондонгийн хөрөнгийн зах зээлийн хоорон дахь зайг богиносгохыг зорьж байна” хэмээн ярьсан билээ.

Манай улсын хөрөнгийн зах зээлийн “хөшгийг” нээхэд гар бие оролцож буй Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран ажиллахаар “Ажлын мастер гэрээ”-нд талууд 2011 онд үзэглэсэн. Ардчилалд хөл тавьсны дараахан буюу 1991 онд өмч хувьчлалын зорилгоор байгуулагдаж байсан манай улсын хөрөнгийн зах зээлийн нэхэх түүх ердөө 22 жил. Өмч хувьчлалын цэнхэр, ягаан тасалбараар гараагаа эхэлсэн Монголын хөрөнгийн зах зээл улсынхаа хөгжлийн хурдыг нэгэнт гүйцэхээ больсныг дэлхийн туршлага, эдийн засгийн өндөр өсөлт харуулах болсон. Санхүүжилтийн өгөөж өндөртэй аргуудын нэг учир эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр болдог хөрөнгийн зах зээлийг хөл дээр нь босгох нь монголчуудын хувьд сонголт бус шаардлага.

Тиймээс Английн хөрөнгийн зах зээлийн мэдлэг туршлагаар хөгжилд дөтлөн хүрэхээр гараас нь атгалцсан. Анхдагч зах зээлийн орлогч дарга Жон Эдвардс “Бид өнөөдөр Лондонгийн хөрөнгийн биржийн үйл ажиллагаа, дүрэм, журмыг бүрэн хуулж, Монгол хэл рүү орчуулж тавих гээгүй. Монголын хөрөнгийн биржид өвлүүлэх туршлага, мэдлэг байгаатай адил бид ч танайхаас сурах юм бий. Энэ бол зөвхөн бидний зааварлах үйл явц бус хамтын хүчээр бүтэх хөгжил. Цаашлаад Монголын хөрөнгийн биржтэй хөрөнгө оруулагч, зөвлөх, шинжээч нарын өргөн сүлжээ гэхчлэн байгаа бүхнээ харамгүй хуваалцана” гэдгээ хэлж байсан юм. Харин Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай “Энэ бол зөвхөн ноу хау биш. Хууль эрх зүй, бизнесийн орчинтой холбоотой цогц хөгжлийн асуудал” хэмээн учирлав.

Монголын хөрөнгийн бирж өнгөрсөн хоёр жилийн хугацаанд холбогдох дүрэм журмаа өөрчилж, олон улсын хөрөнгийн зах зээлд хувьсгал хийсэн “Миллениум Ай Ти” (MIT) хэмээх дэлхийн хамгийн хурдан арилжааны системийг Лондонгийн

• **2009 он. Гуравдугаар сар**

ЛХБ группын төлөөлөн удирдах зөвлөл Хавьер Ролетийг гүйцэтгэх захирлаар томилов

• **2009 он. Есдүгээр сар**

Миллениум Ай Ти” дэлхийн хамгийн хурдан арилжааны системийг хүлээн авав.

• **2009 он. Арванхоёрдугаар сар**

ЛХБ групп есөн хөрөнгө оруулалтын банкны нийлж байгуулсан өрсөлдөгч арилжааны талбарын дийлэнх хувьцааг худалдан авч олон улсын хөрөнгө оруулалтын банкуудтай бүх Европын арилжааны түншлэлийг байгуулав.

• **2010 он. Арваннэгдүгээр сар**

ЛХБ групп нийгэмд тустай санаачлагуудыг дэмжих хүмүүнлэгийн байгуулав.

• **2011 он. Нэгдүгээр сар**

Европын сэргээн босголтын банкнаас евробусийн хамгийн том үнэт цаасны хадгаламжийн төв “Monte Titoli” –г батлав. Түүнчлэн Монголын хөрөнгийн биржтэй хамтарч ажиллах түншлэлийн гэрээ байгуулав.

• **2011 он. Арванхоёрдугаар сар**

ЛХБ групп FTSE группын 50-иас дээш хувийг эзэмших болсноор стратегийн хяналт тавих бүрэн эрхтэй болсон билээ.

• **2012 он. Хоёрдугаар сар**

“Google” компанитай хийсэн гэрээний үрээр арилжааны мэдээллийг дэлхий даяарх хэрэглэгчид тэр дор нь авах боломжтой болов.

• **2012 он. Гуравдугаар сар**

ЛХБ групп олон улсы хөрөнгийн биржүүдийн гүйлгээгээ хийлгэдэг“ LCH. Cleargnet” клиринг хаусын 60 хувийг эзэмших болов.

• **2012 он. Дөрөвдүгээр сар**

ЛХБ групп Итали, Их Британийн хамтарсан технологийн “Gatelab” компанийн 67 хувийг эзэмшиж эхлэв.

• **2013 он. Дөрөвдүгээр сар**

FTSE групп болон TMX групп компаниудын тогтмол орлого дээр тулгуурладаг индексээ нэгтгэж FTSE TMX Global Debt Capital Markets байгуулав.

• **2013 он. Тавдугаар сар**

ЛХБ групп LCH.Cleargnet клиринг хаусын худалдан авалтыг эцэслэв.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

• **1991 он**

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор улсын өмч хувьчлалыг эхлүүлэх, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг байгуулав.

• **1992-1995 он**

Улсын үйлдвэрийн 475 газрыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж 8.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 96.1 сая ширхэг хувьцааг МХБ-ээр дамжуулан борлуулсан.

• **1994 он**

Үнэт цаасны анхны хууль батлагдаж Үнэт Цаасны Хороо байгуулагдаж, МХБ-ийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж байсан 29 брокерийн пүүсийг хувьчлав.

• **1995 он**

Бэлэн мөнгөний арилжаа буюу үнэт цаасны хоёрдогч зах зээлийг эхлүүлсэн.

• **1995 он**

ЗГ-ын 170 тоот тогтоолоор МХБ-ийн түр дүрмийг шинэчлэн баталснаар МХБ нь зөвхөн үнэт цаас арилжих, түүнтэй холбоотой ажил үйлчилгээ эрхлэх зорилго бүхий төрийн өмчийн, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн статустай болсон.

• **1996 он**

Анхны Засгийн газрын бонд гарсан.

• **1999 он**

Электрон арилжааг нэвтрүүлсэн ба анхны Топ-75 Индекс-ийг бий болгосон.

• **2001 он**

Анхны компанийн бонд гарсан.

• **2002 он**

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсан.

• **2003 он**

Засгийн газрын 72 тоот тогтоолоор Монголын хөрөнгийн биржийг үнэт цаасны арилжаа болон хуулиар хориглоогүй бусад ажил, үйлчилгээ эрхлэх төрийн өмчит өөрийгөө зохицуулах хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулсан.

• **2003 он**

МХБ болон ҮЦТТХТ - ийг салган 2 тусдаа байгууллага болгосон.

• **2006 он**

Өмнөд Солонгос улс болон Турк улсын хөрөнгийн биржүүдтэй хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан.

• **2008 он**

МХБ нь Ази, Номхон Далайн бүсийн хөрөнгийн биржүүдийн холбоонд элсэн орсон.

• **2011 он**

Төрийн өмчийн хороо, Монголын хөрөнгийн бирж болон Лондонгийн хөрөнгийн бирж групп “Ажлын мастер гэрээ” байгуулсан.

• **2013 он. Тавдугаар сар**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн нийт гишүүдийн 75 хувийн саналаар баталлаа. ■

ажиллагаа төвлөрөөд байна. Тус агентлаг нь Англи болон хилийн чанад дахь авлигын хэргийг мөрдөх, хэрэг үүсгэх тал дээр тэргүүлэх зэрэгтэй оролцож байгаа юм. Агентлагийн харьяа Хууль бус орлоготой тэмцэх тасаг гэж бий. Тасаг нь залилан болон авлигын хэргийг аль алинтай нь холбоотой хөрөнгийг хязгаарлах, царцаах, хураах зэрэг үүрэг гүйцэтгэж байна. Лондоны Цагдаагийн газар болон Нийслэлийн Цагдаагийн газар авлигатай тэмцэх тусгай тасаг хүртэл байгуулсан нь авлигатай тэмцэх анхан шатны нэгжид ихээхэн ач холбогдол өгдөг ажээ.

Нийслэлийн Цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст Хилийн чанад дахь авлигатай тэмцэх тасаг байдаг. Тус тасаг нь Олон улсын хөгжлийн газраас санхүүждэг байна. Түүнчлэн Хууль зүйн яамнаас худалдааны байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэхэд хэрэглэх боломжтой дүрэм, журмыг ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлэх удирдамж гаргажээ. Уг удирдамжийн долдугаар хэсэгт “Авлигаас урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлэхгүй байх” гэсэн заалт оруулж өгсөн байна. Үүний дагуу хэрэгт татагдсан аливаа худалдааны байгууллага өөрийгөө өмгөөлөх боломжоор хангагдаж байгаа юм. Энэхүү удирдамж нь гаднын ямар нэгэн компани авлигаас урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй гэсэн хэрэгт унах эрсдэлтэй. Харин хэрэгт холбогдсон компани нь тус улсын Хөрөнгийн биржэд бүртгэлтэй бол Англид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй аж.

“Бурхан биднийг заавал амжилтад хүрэхийг шаардаагүй. Харин зүтгэхийг л шаарддаг юм” гэж Тереза эхийн хэлсэн үг бий. Үүнтэй адил авлигатай тэмцэх нь иргэн бүрийн чин хүсэл. Түүнийг амьдран буй нийгмээсээ холдуулах нь татвар төлөгч хэн бүхний итгэл үнэмшил аж. Муу засаглалын үр дүнд урган төлжиж буй авлигын эсрэг Англи улс хууль эрх зүйн хүрээнд дорвитой шинэчлэл хийх болсныг дээр дурдсан. Тэд бүс нутгийн хэмжээнд, цаашилбал дэлхий нийтэд хандсан манлайлын үүрэг гүйцэтгэх хэмжээний хуулийн

АНУ, Их Британийн авлигын эсрэг хэрэгжүүлж буй бодлого

ОУАЭХ	Нийтлэг үндэслэл	Английн Авлигын эсрэг хууль
Гаднын орнуудын Засгийн газрын албаны хүн, улстөрчид	Гаднын албаны хүмүүсийн авлигын хэрэг	Хувийн хэвшлийнхний дундах авлига зэрэг Засгийн газрын бус албаны хүмүүс хамрагдана
Гаднын орны албаны хүмүүст авлига хэлбэрээр өгөх төлбөрийг гэмт хэрэгт тооцно	Байхгүй	Тухайн төлбөрийг авлига хэлбэрээр төлсөн эсэх нь хамаагүй
Авлига хүсэх, хүлээж авах, хүлээн зөвшөөрөхийг хориглохгүй	Авлигын төлбөр	Авлига хүсэх, хүлээн авах, хүлээн зөвшөөрөх үйлдлийг гэмт хэрэгт тооцно
Үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төлбөрийг хүлээн зөвшөөрсөн /Засгийн газрын тогтсон үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төлбөр/	Зарим нэг төлбөрийг хориглосон	Үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ямар ч төлбөрийг хориглоно
Хатуу чанд хариуцлага оногдуулах заалт байхгүй	Зарим гэмт хэрэгт шаардлагатай	Авлига болон өндөр албан тушаалтны гэмт хэргээс
Гэмт хэрэг тус бүрт таван жилийн хорих ял оногдуулна	Гэмт хэргийн ял, шийтгэл	Гэмт хэрэг тус бүрт арван жилийн хорих ял оногдуулна
Бүртгэл болон бичилтийн заалтуудад дэлгэрэнгүй нягтлан бодох бүртгэл шаардлагатай	Нягтлан бодох бүртгэл	2006 оны Английн Компанийн хууль (386, 387-р заалт): компаниуд нягтлан бодох бүртгэл хөтлөх үүрэгтэй
Бараа сурталчлах болон гэрээт үүргээ биелүүлэх үүднээс үндэслэл бүхий бодит зардал төлснөө өмгөөлөх боломжтой	Байхгүй	Компанийн гэмт хэрэгт зориулсан хангалттай дүрэм, журамтай байх нь өмгөөлөх ганцхан боломж

шинэчлэлийг эхлүүлээд байгаа нь энэ. Жишээлбэл, Хууль зүйн яамны удирдамжид бараа, бүтээгдэхүүн болон үйлчилгээ үзүүлэх, холбоо харилцаа тогтоох зорилгоор зохистой хэмжээг нь тааруулсан үндэслэлтэй хүлээн авалтын арга хэмжээг гэмт хэрэгт тооцохгүй аж. Харин тухайн хүлээн авалт нь хэн нэгнийг хууль, тогтоомжид заасан холбогдох үүргээ зөрчихөд хүргэж, гаднын төрийн өндөр албан тушаалтанд нөлөөлөхөд хүргэсэн тохиолдолд авлигын хэрэг гэж үздэг байна. Удирдамжид хүлээн зөвшөөрөгдөх хүлээн авалтын арга хэмжээ ямар байхыг тусгасан бөгөөд үүнд үйлчлүүлэгчийг спортын арга хэмжээнд урих, гаднын төрийн албан хаагчийн аялал, хоол унд болон үзвэр үйлчилгээний зардлыг даах зэрэг багтах аж.

Англи Жи 20-ийг тэргүүлэх хугацаандаа баримталж байсан “Хөгжлийн гол аюул занал” гэсэн зарчмын дор авлигыг бууруулахаар ил тод бөгөөд нээлттэй нийгмийг цогцлоох асуудлыг хөндсөн. Өөрөөр хэлбэл, Нээлттэй нийгэм байгуулах эв санааг дэмжсэн гэсэн үг. Үүнд,

эдийн засаг, улс төр нэн тэргүүнд багтаж байгаа. Бизнес болоод иргэний нийгмийн “шүдний өвчин” болоод буй авлига Английн төдийгүй дэлхийн эдийн засагт бараан толбо үлдээсээр буй.

Тогтвортой хөгжил. Дэлхийн нийтийн тэмүүлж буй хөгжлийн төсөөлөл энэ. Ирээдүйд буй болох хөгжил алдагдал хүлээх бус ашигтай ажиллах учиртай. Тиймээс Английн Засгийн газар Авлигын эсрэг хуулийн төслийг боловсруулахад онцгой үүрэгтэй оролцсон нь олон орны Засгийн газарт үлгэр дуурайлал болсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Нийгмийн баялаг нь өв тэгш, бүрэн бүтэн байх ёстой. Бүтээсэн баялаг хөгжлөө тэтгэх нь зүйн хэрэг. Лондонгийн Whitehall төв гудамжинд байрлах Английн Засгийн газар авлигын эсрэг хүчээ зузаатгасан гэж хэлж болно. Учир нь Засгийн газрын зүгээс авлигын эсрэг байгууллагаа дэмжин ажиллахын сацуу хуулийг чанд мөрдүүлэхээр ажиллаж байгаа нь тэдний давуу тал юм.

“Авлигагүй бүс”-эд тавтай морил. Английн хүсэл дэлхий нийтийн хүсэл юм. ■

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

АЛГАСАЖ ҮЛ БОЛОХ АНГЛИ

Б.МЭРГЭН

Хатан хаан, орд харш, нарийн зам, хоёр давхар улаан автобус, том цаг, шигүү ургасан модод, ногоон өнгө, өтөлсөн байшингууд, чулуун хана, бүүдгэр тэнгэр, нулимст үүлс. Энэ бол Английн имиж. Харин аялахаар ирсэн нэгэнд Англи улс үүнээс ч илүү үзүүлдэг. Учир нь тус улс соёлын нөөцөөр бусдаас илүүрхэж, дэлхийд гуравдугаарт бичигддэг.

Дэлхийн эдийн засгийн чуулганаас гаргадаг аялал жуулчлалын өрсөлдөх чадварын тайланд Их Британи улс энэ жил тавдугаарт цойлж яваа нь 2011 оны үзүүлэлттэй харьцуулахад хоёр байраар урагшилсан амжилт. Харин соёлын нөөцөөр тус жагсаалтад гурав дугаартайгаар манлайлагчдын эгнээг манасаар байна. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын судалгаагаар гаднаас хүлээж авч буй жуулчдынхаа тоогоор тус улс олон улсын нийт аялагчдын 2.8 хувийг “дааж” байна.

Аялал жуулчлал нь Их Британи, Умард Ирландын Вант улсын хувьд эдийн засгийн тулгуур салбаруудын нэг. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд аялал жуулчлалын салбарын дундаж өсөлт 3.5 хувь байсан бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүнийх нь 8.9 хувьтай тэнцэж байна. Хэдийгээр эдийн засгийн хүндхэн жилүүд тус улсыг дайрсан ч өнгөрсөн хоёр жилээс эхлэн аялал жуулчлалын салбар тасралтгүй өндийжээ. Түүнчлэн 12 ажлын байр тутмын нэг нь тус салбарт оногддог.

Их Британийн Үндэсний Статистикийн газраас гаргасан олон



Букингхэмийн ордон

Фотог Э.Зориг



Лондон хот, Оксфорд гудамж

улсын зорчигчдийн судалгааг үзэхэд өнгөрсөн онд тус улсад нийт 31 сая гаруй жуулчин зочилж, 18.6 тэрбум фунт стерлинг зарцуулсан байна.

Үүнээс 15.5 сая жуулчин Лондонг зорьжирж, 10 тэрбум фунт үрсэн нь тус улсын аялал жуулчлалын салбарыг онилсон нийт мөнгөний 54 хувийг ▶

▶ Лондон ганцаараа “халаасалдгийг” харуулж буй. Тус улсад аялах дундаж хугацаа өнгөрсөн оны байдлаар 7.4 өдөр байгаа бол дундаж зарлага 600 фунт. Ерөнхийд нь багцалбал аялал жуулчлал өнгөрсөн жилийн хувьд Английн эдийн засагт 96.7 тэрбум фунт нийлүүлж.

Аялал жуулчлалын сурталчилгаа, брендингийн хувьд Их Британи үндэстнээрээ брэнд болдог тул “An-holt GfK Nations Brand Index” гаргасан судалгаагаар Америк, Германы дараа гуравт жагсаж байна. Тус улс жуулчдыг тод суурьшмал соёл иргэншил, түүхэн дурсгалт эртний үзмэрүүдээрээ ихээхэн татдаг. Үндэстэн, үүх түүх, соёл заншлаараа

Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын тайлан 2013, Дэлхийн эдийн засгийн форум

Их Британи /V байрт/		
	Үнэлгээ (144 орноос)	Оноо (1-7)
Хууль эрх зүйн хүрээнд авч буй арга хэмжээ	17	5.44
Бодлогын дүрэм журам	8	5.34
Байгаль орчны тогтвортой байдал	7	5.63
Аюулгүй байдал	22	5.70
Эрүүл ахуй	48	5.67
Аялал жуулчлалд өгч буй ач холбогдол	40	4.87
Бизнес, дэд бүтцийн орчин	10	5.13
Агаарын тээврийн дэд бүтэц	5	5.61
Газрын тээврийн дэд бүтцийн	13	5.78
Аялал жуулчлалын дэд бүтэц	22	5.76
Мэдээлэл харилцааны технологийн дэд бүтэц	10	5.43
Аялал жуулчлалын салбарын үнийн өрсөлдөх чадвар	138	3.05
Аялал жуулчлалын салбарын хүн,соёл, байгалийн нөөц	3	5.57
Хүний нөөц	6	5.76
Аялал жуулчлалын салбарын ижил төстэй байдал	45	4.85
Байгалийн нөөц	15	5.24
Соёлын нөөц	3	6.44

брэнд болж чаддагийг дуулиан нь тасраагүй шинэ ханхүү харуулж буй. Их Британийн Жижиглэнгийн барааны судалгааны төвөөс Англид бяцхан ханхүү төрснөөр иргэдийн хэрэглээ өсч, Их Британийн эдийн засагт 240 сая фунт стерлинг буюу 398 сая ам.доллар оруулахаар байгааг тогтоожээ. Ханхүүг төрсөн даруй баярын ширээ чимэглэх хоол хүнсний эрэлт нэмэгдэж, холбогдох чихмэл тоглоом, бэлэг дурсгалын зүйлс, ном, сонин тэргүүтэй олон бүтээгдэхүүний эрэлт огцом нэмэгдэж байгааг гаднын хэвлэлүүд бичсэн билээ.

Тус улсад баялаг үзмэр бүхий дэлхийд алдартай музейнүүд нь үнэгүй байдаг нь олны талархлыг хүлээдэг. Тухайлбал, Англидаа номер нэг Их Британийн музейг л гэхэд өнгөрсөн жил 5.6 сая хүн үзсэн бол “Tate Modern” Лондонгийн урлагийн галлерейг 5.3 сая хүн сонирхжээ. Английг зорихдоо цаг, мөнгөө нэлээд сайн төлөвлөж, Лондонд ирээд буцсан гийчин “London eye” алсыг харачгийг алгасаж, “Madame Tussauds” лааны тосон музейг дайрахгүй өнгөрнө гэж үгүй.

Хэдий Англи улс аливаа үзвэр, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийхээ үнээр толгой өвтгөдөг ч чанараараа хэнийг ч дагуулахгүй өндөр. Европ стандарт гэдэг энд хууль. Үнэ дагаж чанар, нэр хүнд гэсэн брэндийн тогтолцоо үйлчилнэ. Гэхдээ хямд бараа бүтээгдэхүүнд ч Европ стандарт хамаарна. Тиймээс эндээс

чанаргүй “хог, хор” авна гэдэг бараг л боломжгүй. Лондон шиг гоёх дуртай хүмүүстэй хотоос загвар, хийц, үнэ, чанарыг худалдаж авч болно. Гаднынхан тэр дундаа азиуд цаашилбал монголчууд ч ойрын жилүүдэд Лондон хотын хээнцэр ур хийцээр чамгүй чамирхдаг болчихсныг тус хотын дэлгүүр хэсэгчдийн мөрөөдөл Оксфорд гудамж гэрчилнэ. Ялангуяа долоо, арванхоёрдугаар сард бараа бүтээгдэхүүний үнэ “навс” хямдардаг тул дэлгүүр хэсэх зорилгоор жуулчлагчдын тоо эрс ихэснэ. Сүүлийн үед Хятадын дундаж орлоготой иргэдийнхээ тоог нэмэгдүүлэх бодлого хэрэгжиж байгаагийн ачаар хятадуудын аялж зугаалах нь ихэсч, дэлгүүрийн лангууг “хоослох” болж. Тиймээс дэлгүүр болгон хятад худалдагчтай болсныг ажиглаж болно.

Дэлхийн олон улс, үндэстний аж амьдрал, түүх соёл, нутаг орноор аялж зугаалах хүсэлтэй нэгний хувьд Англи улс алгасаж үл болом Европын соёлын төв цэг. Гэвч Их Британи, Умард Ирландын Вант улс илүү ихийг хийж, илүү олон хүнийг татахаар ажиллаж байна. Тиймээс Английн бодлого тодорхойлогчид аялал жуулчлалын эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, тус салбараар дамжуулан ажил эрхлэлт, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор 2010-2020 оны хооронд хэрэгжих Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлж байна. ■



Англи жуулчдыг тод суурьшмал соёл иргэншил, түүхэн дурсгалт эртний үзмэрүүдээрээ ихээхэн татдаг.

Фотог Э.Зоригт

ШИНЭ БОДЛОГО

ИХ БРИТАНИЙН
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Британичууд тогтвортой хөгжлийн хүчирхэг суурийг тавих онцгой сэтгэлгээний шинэ эрин үеийг хөгжүүлсээр ирсэн

Т.НОМИН-ЭРДЭНЭ

Их Британи тогтвортой хөгжлийг үр дүнтэй хэрэгжүүлж буй тэргүүлэгч орнуудын нэг. Тогтвортой хөгжил нь байгаль орчныг хамгаалж, хүн амын амьдралын чанарыг сайжруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг дэмжих тухай ойлголт аж. Дэлхийн байгалийн нөөц хязгаарлагдмал тул дэлхийн хүн ам есөн тэрбумд хүрэх үед байгаль эх биднийг тэтгэх боломжгүй болох аюултай.

Их Британийн “Ecological Sequestration Trust” (EST) ашгийн бус байгууллагыг 2011 онд үндэслэгч Петр Хед дээрх асуудлыг шийдвэрлэхэд гар бие оролцож буй нэгэн. Тус байгууллага бизнес болон дэд бүтцийн тогтолцооноос эдийн засаг, байгаль орчин болоод нийгэмд

үзүүлж буй нөлөөллийг хүмүүст ойлгуулахад дэмжлэг болох үүднээс тооцооллын загварчлал бүтээхээр ажиллаж байна. Харин өдгөө дэлхий дахинд ашиглаж буй загварчлал нь байгалийн нөөц хязгааргүй бөгөөд хог, хаягдлыг хаа сайгүй хадгалж байна гэсэн ямар ч үндэслэлгүй, буруу таамгийг дэвшүүлээд байгаа юм. Шинэ загварчлалыг гаргаснаар одоогийн загварчлалаар шийдвэрлэж чадахгүй байгаа тулгамдсан асуудлыг бүрэн шийдвэрлэх зорилготой аж.

Загварчлалыг өөрчлөх нь

Петр Хед өдгөө хэрэглэгдэж буй шугаман загварчлалыг өөрчилж, дээрх буруу тооцооллыг давтахгүй байх, хог, хаягдлыг дахин ашиглах гэсэн илүү тохиромжтой хувилбарыг

санал болгох тойрог маягийн загварчлал гаргахаар ажиллаж байна. Тэрбээр тогтвортой хөгжлийн зарчмуудыг нутагшуулахын тулд төр, хувийн хэвшлийнхэнд зориулан кампанит ажил зохион байгуулж, энэхүү стратегиа хадгалсаар иржээ. Мөн стратегиа амжилттай хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийн өгөөжийг бүрдүүлэх боломжийг харуулах дэлхий дахинд гарч буй шинэ санаа, санаачилгыг хослуулах зорилго өмнөө тавьсан аж. Их Британи улс дэвшилтэт тогтолцоотой тул компаниудтай хамтран шинэлэг бөгөөд илүү үр дүнтэй загварчлал бий болгох бололцоотой юм.

Энэхүү хаягдал болон нөөц дахин боловсруулах санал, санаачилгын талаарх эргэх холбоотой (closed-loop) үзэл бодлын тусламжтайгаар эдийн засгийн үнэ цэнийг хүмүүст үнэн, бодитойгоор ойлгуулахын тулд тодорхой загварчлалуудыг боловсруулан гаргах боломжтой. Эдгээр хэрэгсэл нь үндэслэлтэй гэж үзсэн арга хэмжээг цаашид дэмжих хувилбаруудыг ашиглахад төлөвлөгөө боловсруулагчдад дэмжлэг үзүүлэх зорилготой. Тухайн нөөцийн үр ашиг болон боловсролын боломжийг хэрхэн сайтар судалж, хэрхэн туршлагажих вэ гэдэг үнэ цэнийг хүмүүс ойлгох шаардлагатай. Их Британи боловсролын хувьд өргөн нөөц, боломжтой тул британичууд тогтвортой хөгжлийн хүчирхэг суурийг тавих энэхүү онцгой сэтгэлгээний шинэ эрин үеийг хөгжүүлсээр ирсэн байна. ▶

▶ Петр Хед шугаман загварчлалын тооцоололд гардаг алдаа, дутагдал олон салбар болон хувь хүмүүсийн хувьд нэгэнт ойлгомжтой болсон асуудал гэж үздэг. Гэхдээ энэ асуудлыг шийдвэрлэхэд түлхэц болох гол хөдөлгөгч хүч дутагдсаар иржээ. Энэ орон зайг EST-ийн гүйцэтгэх үүрэг бөглөж байгаа юм. Тус байгууллагын гол зорилго нь дэлхийн экологийн чадавхыг сайжруулахын зэрэгцээ хотууд болон хөдөө аж ахуйн илүү сайн хувилбарыг бий болгох. Эдгээр нь сэтгэлгээний хэлбэрээ өөрчлөхөд зайлшгүй шаардлагатай зүйлс юм.

Тойрог хэлбэрийн загварчлалыг бий болгохын тулд эдийн засгийн гүйцэтгэлд хөрөнгө оруулалтыг илүү гүн гүнзгий холбож өгөх нь маш чухал аж. Олон хүн тогтвортой хөгжлийг өнгөн дээрээ сайхан санаа гэх боловч цаана нь нуугдаж буй эдийн засгийн асуудлыг олж хардаггүй. Харин дээрх байдлаар холбож өгснөөр шинэ загварчлалын тусламжтайгаар төлөвлөгөө боловсруулагчид төслүүдээ илүү хялбар удирдан, зохион байгуулах боломжтой.

Ирээдүйн төлөвлөгөө

Их Британийн Засгийн газраас тогтвортой хөгжлийн талаарх ойлголтыг цаашид улам сайжруулах үүднээс төлөвлөгөө гаргажээ. Дэлхийн эдийн засаг, тэр дундаа Их Британийн эдийн засаг улам хөгжиж буйтай холбоотойгоор энэ асуудал илүү чухлаар тавигдах болсон байна. Урт хугацааны ногоон, тогтвортой хөгжил рүү хийх шилжилт нь тус улсын туйлын ашиг сонирхол юм. Ингэснээр санхүүгийн тогтолцоогоо дахин бүрдүүлэхийн зэрэгцээ байгаль орчноо хамгаалах боломжтой болох аж. Үүнээс “Өөрчлөлтийг хэрхэн бий болгох вэ” гэдэг асуудал урган гарч байна.

Их Британи улс EST байгууллагын тусламжтайгаар одоо ашиглаж буй шугаман загварчлалыг өөрчлөх, улмаар инновацийг энэхүү онцгой талбарт хэрэгжүүлэх зорилтыг тавин ажиллаж буй. Төр, хувийн хэвшил, боловсролын салбараас төрөн гарч буй ур чадвар, мэдлэгийн

тусламжтайгаар алсын харааг бий болгох боломжтой. Их Британийг дотооддоо төдийгүй дэлхий дахинд тогтвортой байдлыг дэмждэг гол орнуудын нэг гэж ойлгож болно.

Тогтвортой хөгжлийн төлөвлөгөөг амжилттай эхлүүлэх нь ирээдүйд бизнесийн ямар загварчлал хаана, ямар түвшинд байх бол гэдгийг хамтдаа тодорхойлохоос шалтгаална. Шинэ загварчлал болон байгаль орчныг бий болгосноор олон бизнес эрхлэгчийн хувьд ахихад, мөн тогтвортой хөгжлийн өсөлтийг дэмжих шинэ стратегиудын хүрээг тэлэхэд дөхөм болох юм.

Сорилтууд

Цоо шинэ талбарт хөлтөвч байгаа нь шинэ загварчлалыг боловсруулахад

тулгарч буй гол сорилт. Шинэ арга барил хэрэгжүүлснээр олон асуулт хариултгүй хэвээр үлдэж, урагшлах үйл явцад олон хүндрэл үүсч болох ч харилцаа холбоог сайжруулснаар эдгээрийг давж гарах боломжтой. Судалгааны шинэ аргачлалыг гаргаснаар системчилсэн ахиц, дэвшил гарч ирэх болно.

Өдгөө ашиглагдаж буй загварчлалуудыг улам сайжруулах хэрэгтэй. Эдгээр нь эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх зориулалттай хийгдсэн тул үнэлгээний ач холбогдлыг нь сайтар авч үзэх шаардлагатай юм. EST энэ тал дээр тогтвортой стратеги руу хийх шилжилтэд ахиц гаргахын тулд өнөөгийн сэтгэлгээний хэлбэрийг өөрчлөх гэсэн маш тодорхой зорилт тавин ажиллаж байна. ■

ӨӨР СЭДЭВ

НОГООН ТАСАЛБАР



Ч.ЧУЛУУН

Хүн төрөлхтөн нэг хэсэг эдийн засаг, технологийн хөгжил гэж хошуурсан. Ямар ч хамаагүй аргаар эдийн засгаа хөгжүүлэх гэж хичээсэн. Гэтэл экологийн аюулгүй байдалд хүн төрөлхтний заналхийлэл нүүрлэж дэлхий “халуурч”, ус мөрөн “амь тавьж”, ан амьтад ховордож байна. Тиймээс өдгөө улс үндэстэн бүр байгаль орчны өөрчлөлтөд дасан зохицсон буюу амьдралын ногоон хэв маяг цаашлаад улс төр, эдийн засгийн ногоон бодлого хэрэгжүүлэхийг эрмэлзэж байна. Монголын Засгийн газар ч гэсэн ногоон хөгжлөөр замнах хүсэлтэй. ▶▶

► Монгол Улс дахь Их Британийн Элчин Сайдын Яамны хоёр талт хөтөлбөрийн сангаас өвөрмөц зорилт тавин ажиллаж байна. Тухайлбал, 2013-2014 оны тэргүүлэх чиглэл бол сайн засаглал, ардчилал, худалдааны эрүүл орчин, байгаль хамгааллыг дэмжиж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах талаар байгаа аж. Тэр ч утгаараа Монголын Засгийн газрын ногоон замналын эхний алхмыг Их Британийн Элчин Сайдын Яамны санхүүгийн болоод бусад төрлийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр тэй хамтран эхлүүлсэн байна. Тус дэмжлэгээр ногоон эдийн засгийн нарийвчилсан шинжилгээ, хор хөнөөлийг бууруулах боломжид зориулсан зардлын тооцоо, цаашлаад ногоон хөгжлийн стратегийн төслийг эцсийн байдлаар дуусгах. Ногоон хөгжлийн талаарх ойлголтыг олон нийтэд таниулан сурталчлах замаар тогтвортой хөгжлийг бий болгож ядуурлыг бууруулах арга замын талаар судалгаа, зөвлөгөө өгөх гээд олон ажлыг хийж гүйцэтгэжээ.

Үйл ажиллагаа	Зарцуулсан үнийн дүн ам.доллар
Зөвлөх үйлчилгээ	33240*
Зөвлөх сургалт, семинар	23910*
Ухуулга сурталчилгаа, холбоо харилцаа	17250*
Удирдлагыг дэмжих ерөнхий үйлчилгээ	5600
Нийт	80000

Анхдагч хэрэгцээ дутагдах шалтгаан

Хүний хэрэгцээг эрэмбэлэхэд таван үе бүхий гурвалжин байдгийн хамгийн доод талд нь амьд явахын тулд шаардагдах физиологийн анхдагч хэрэгцээ байдаг аж. Үүнд хооллох, мэдээлэл олж авах зэрэг багтана. Хэрвээ эдгээр анхдагч хэрэгцээний аль нэг дутагдаж эхэлбэл ядуурал үүсэх шалтгаан болдог аж.

Нэгдүгээрт, нүүрсхүчлийн хий, хүлэмжийн хийн ялгарлын улмаас дэлхийн уур амьсгалын өөрчлөлт буюу дэлхийн дулаарал нь хүнсний хомсдол бий болох хамгийн том



100 мянган нарны гэр хөтөлбөрийн хүрээнд нарны зай хураагуур ашиглаж байгаа Төө аймгийн Алтанбулаг сумын малчин өрх

шалтгаан болоод байна. Түүнчлэн цэвэр усны нөөц хомсдож байгаа нь экологийн хувьд сүйрэл дагуулж, тэр хэмжээгээр хүнсний хомсдолыг бий болгож байгаа талаар өнгөрсөн онд болсон “Rio+20” хурлын үеэр олонтаа дурдсан. “Oxfam” олон улсын байгууллагын гаргасан судалгаагаар хэрвээ хүн төрөлхтөн энэ маягаар байгаль экологид хортой үйл ажиллагаа явуулсаар байвал 2030 он гэхэд дэлхийн хүн амын талаас илүү хувь нь өлсгөлөн, ядууралд нэрвэгдэнэ гэсэн байна.

Хоёрдугаарт, эрчим хүчгүйгээр XXI зууны хүн мэдээлэл олж авах анхдагч хэрэгцээгээ хангаж чадахгүй. Гэтэл эрчим хүчний асуудал дэлхий нийтийн өмнө тулгамдаж байна. Олон улсын эрчим хүчний агентлагийн мэдээлж байгаагаас үзвэл өнгөрсөн 30 жилийн дотор дэлхийн нийт эрчим хүчний хэрэгцээ бараг хоёр дахин нэмэгджээ. 2030 он гэхэд хоёр дахин, 2050 онд гэхэд даруй гурав дахин нэмэгдэх төлөвтэй байна. Мөн эрчим хүч гаргаж авах гол эх үүсвэр болох нүүрсийг олборлохын тулд газрын хэвлийг “онгичиж” байгаа нь дэлхийн эрүүл мэндийг доройтуулж, тэр хэмжээгээрээ хүн төрөлхтний ирээдүйг заналхийлсээр. Товчхондоо, түрүүлж хөгжихөөд дараа нь цэвэрлэнэ гэдэг логиктой “хүрэн” эдийн засаг энэ зуунд “хол явахгүй” нь.

Гарах хаалга

Монголчуудын хувьд эрчим хүчний дутагдалд хэдийнэ орж, ард иргэдийнх нь гурван хүн тутмын нэг нь ядуу байна. Тэгвэл гарах гарц хаана байгаа бол. Ард олонд асуудал тулгарсан үед гарч ирдэг сайн талын хүлэг баатар бүх цаг үед байдаг. Харин энэ үеийн хүлэг баатраар “ногоон” үзэл баримтлал тодорч, улс бүр өөрийн гэсэн “ногоон баатар”-тай болжээ. Тухайлбал, Герман улс “Тогтвортой хөгжлийн стратеги”-тай бол япончууд “Инновацийн ногоон бодлого” баримталдаг. Харин монголчууд саяхнаас л ногоон хөгжлийн тухай ярьж эхлээд байна.

UNDP-тэй хамтран БОНХЯ “Ногоон хөгжлийн стратеги”-ийг боловсруулж байгаа бөгөөд тусажлыг эхлүүлэхэд ч Их Британийн Элчин сайдын яам санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Тус санхүүжилтээр хүлэмжийн хийн ялгаруулалт эдийн засгийн болоод бусад салбарт ямар хэмжээтэй байгаа. Хор хөнөөлийг бууруулах боломжийг нарийвчилсан судалгаагаар тогтоосон байна. Түүнчлэн дэд салбаруудаар хүлэмжийн хийн ялгаруулалтын 2030 он хүртлэх төсөөлөл, загварыг гаргажээ.

Байгаль экологид хамгийн халтай үйл ажиллагааны нэг нь уул ►

уурхай байдаг. Гэтэл Монголд уул уурхай эдийн засгийн тэргүүлэх салбарын хэмжээнд хүрч байгаа. Гэхдээ UNDP-ийн тусламжтайгаар БОНХЯ ногоон бодлогоо амжилттай хэрэгжүүлж чадвал тэр нь гадаадын уул уурхайн компаниудын тулгалт, тэдний ард байгаа геополитикийн зарим дарамтыг даван гарах бидний хүчирхэг зэвсэг, тэдний хувьд бол дургүй байсан ч хүлээн дагахаас өөр аргагүй, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн “найрсаг” хаалт болох талаар УИХ-ын гишүүн асан Д.Энхбат бичжээ.

“Ногоон хөгжлийн стратеги”-г зааснаар хүлэмжийн хийг бууруулах замаар ногоон ажлын байр бий болгож, байгальд ээлтэй салбарыг дэмжиж эдийн засгаа эрүүлжүүлж болох аж. БОНХ-ийн сайдын зөвлөх Т.Чулуун “Уг бодлогын баримт бичиг дээр гардаж ажилласан хүний хувьд монголчууд үндсэн хоёр үе шаттайгаар уг төслийг хэрэгжүүлнэ. Нэгдүгээрт, 2013-2020 он хүртэлх буюу шилжилтийн үе. Хоёрдугаарт, хэрэгжүүлэх буюу 2020-2030 он хүртэлх үе гэж хуваасан байгаа. Үүний тулд 2020 он гэхэд монголчууд эрчим хүчний хэрэглээний 20 хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах. Байгалийн гамшгийн жилийн хохирлыг 2030 он гэхэд 15 хувиар бууруулсан байх хэрэгтэй” гэсэн юм. Хэрвээ уг зорилгын дагуу эрчим хүчний хэрэгцээгээ сэргээгдэх эрчим хүчээр хангаж чадвал хүн бүр цэвэр эрчим хүчээр хангагдаж, хүний мэдээлэл олж авах анхдагч хэрэгцээ ногоон эрчим хүчнээс бүрдэх юм. Нөгөө талаар сэргээгдэх эрчим хүч зэрэг ногоон буюу байгальд ээлтэй шинэ салбарыг төрөөс дэмжих нь ажлын байр бий болгож ажилтай орлоготой монголчуудын тоо нэмэгдэнэ гэсэн үг. Ингэж чадвал ядуурал буурч дан ганц уул уурхайд түшиглэсэн Монголын эдийн засаг бага багаар олон суурьтай болж төрөлжин хөгжих учиртай.

Дэлхий нийт нэгэнт ногоон хөгжлийн зүг хүлгийн жолоо залсан энэ үед монголчууд ч гэсэн хөгжлийн галт тэрэгнээс хоцрох учиргүй. Харин ногоон гэх тодотголтой галт

тэргэнд суух эхний тасалбарын зардлыг Их Британийн Элчин сайдын яамнаас нэгэнт гаргасан.

Харин цаашаа явах тасалбараа монголчууд бид өөрсдөө олж авах нь чухал юм. ■

ИННОВАЦИ

ШИНЖЛЭХ УХААНЫ АРАЛ

Х.ХУЛАН

“Гулливерийн аялал” романы гол баатар Лемюэль Гулливер хөвөгч арал дээр орших Лагадо хотын Их академиар зочилдог. Тэрбээр тэндхийн эрдэмтэн мэргэдийн туршиж буй хачин жигтэй туршилтуудтай танилцсан тухай Та уншиж байсан уу? Өргөст хэмхнээс нарны туяа гаргаж авах, мөсийг хайлуулж бууны дарь хийх гэхчлэн уран зөгнөлт туршилтын тухай өгүүлсэн байдаг. Их Британийн техник, шинжлэх ухаанд гарч буй өнөө үеийн шинэчлэлүүд Гулливерийн үзсэнээс дутахааргүй сонирхолтой юм.

Ньютоноос Даян дэлхийн вэб

Их Британийн шинжлэх ухаан, технологийн салбар нь урт удаан түүхэн замналыг туулж ирсэн. Дэлхийд алдартай онолч эрдэмтэд болох Айсак Ньютон, Чарльз Дарвин нарыг орчин үеийн шинжлэх ухааны суурийг тавьсан гэж үздэг. Англи хэмээх арлын Вант улсын олон эрдэмтэн шинжлэх ухаанд жинтэй хувь нэмрээ оруулсан юм. Тухайлбал, химич Хенри Кавендиш устөрөгчийг, судлаач Александр Флеминг пенциллин, эрдэмтэн Фрэнсис Крикээр удирдуулсан баг ▶



Их Британийн биологи болон анагаахын салбарын 77 Нобелийн шагналтантай

▶ хүний ген дэх дезоксирибонуклейн хүчлийг нээсэн билээ.

Британичууд техникийн талбарт гаргасан ололт амжилтаараа мөн толгой цохидог. Ричард Тревитник, Эндрю Вивиан хоёр анхны уурын галт тэрэг, Франк Уиттл агаарын тийрэлтэт хөдөлгүүрийг бүтээж, Тим Бернерс-Ли олон улсын цахим сүлжээг хөгжүүлсэн аж. Эдүгээ тус улсын эрдэмтэд анагаах, байгалийн болон биологийн шинжлэх ухааны судалгаа шинжилгээг тасралтгүй явуулж байна. Нэгэн жишээ дурдахад, Их Британи улс шинжлэх ухааны судалгаагаар тэргүүлдэг найман орны нэг бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ нэг тэрбум фунт стерлинг тутмын 45 судалгааны ажилд зориулдаг бол АНУ-д 25, Японд 15 судалгааны материал тус тус оногддог байна.

Сүүлийн үед цэцэглэн хөгжиж буй “Life science” буюу биологийг нийгэмтэй холбож судалдаг ухаанд эрүүл мэнд, хөдөө аж ахуй, анагаах ухаан эм зүй, хүнсний салбар багтдаг аж. Англид энэхүү чиглэлийн 4500 компани нийт 167.500 ажиллагсадтай бөгөөд жилдээ 50 гаруй тэрбум фунт стерлингийн орлоготой ажиллаж байна. “Life science” дахь шинэчлэлийг аж үйлдвэр, судалгаа шинжилгээний байгууллага, Их Британийн Үндэсний эрүүл мэндийн төв болон Засгийн газар хамтарч хэрэгжүүлдгээрээ онцлогтой.

Их Британийн Биологийн шинжлэх ухааны хөрөнгө оруулалтын газрын мэдээллээр, тус улс биологи болон анагаахын салбарын 77 Нобелийн шагналтантай аж. Тийм ч учраас улсын эм зүй, биотехнологийн компаниуд олон улсын түвшинд судалгаа шинжилгээгээр тэргүүлдэг. Тухайлбал, дэлхийн шилдэг 50 эм зүйн компанийн 37 нь Лондон хотод оффисоо нээжээ.

Англи улс генийн гаралтай өвчин, эсийн түвшний эмчилгээний арвин туршлагатай. Эдгээр эмчилгээний тусламжтайгаар Паркинсоны өвчин, чихрийн шижин, цус харвалт, зүрхний өвчнийг анагаах боломж нээгдсэн юм. Жишээ нь, Паркинсоны өвчнийг эдгээхэд зориулсан ПроСавин нэртэй цоо шинэ аргыг боловсруулсан байна. Үүний туршилтыг Парис



Эдинбургийн их сургуулийн Рослины институт дээр клончлон хувилсан Долли хонь

хотын Хенри Мондорын нэрэмжит эмнэлэгт амжилттай хийжээ. Мөн Английн Анагаах ухааны судалгааны зөвлөлөөс дөрвөн жилийн хугацаанд эсийн эмчилгээнд 130 сая фунт стерлингийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна. Бас нэг сонирхолтой жишээ дурдахад, Уорвикийн их сургуулийн дэргэдэх Дижитал эмчилгээний төв дээр амь насанд аюултай болон архаг өвчтэй хүнийг дижитал технологи ашиглан эмчилдэг болжээ. Түүнчлэн анхны “хуруу шил”-ний хүүхэд Англид 1978 онд төрсөн. Хэдэн жилийн дараа буюу 1985 онд харин анхны “тээгч эх”-ийн хүүхэд мэндэлсэн түүхтэй.

Их Британийн Засгийн газраас технологи, инновацийн элит сүлжээ байгуулсан нь хамгийн сүүлийн үеийн дэвшлийн нэг болж байна. “Катапульт” нэртэй эдгээр зургаан төв нь шинэчлэл, шинэ санааг хэрэгжүүлэгч судалгаа шинжилгээний гол байгууллага аж. Британийн эрдэмтэд хүний биеийн эсийг өөрчлөлтөд оруулж, олон төрлийн өвчнийг анагаах шинэ боломжийг бүрдүүлж байна. Тухайлбал, Лондонд нээгдсэн “Эсийн шинжилгээний катапульт” төвд эсийн шинжлэх ухаан, технологийн туршилтуудыг хийж эхэлжээ. Тус төв нь эдгэрэхгүй өвчнийг анагаах арга олж боловсруулах зорилготой. Их Британийн Технологийн стратегийн зөвлөлөөс таван жилийн хугацаанд нийт 50 сая фунт стерлингийг зарцуулахаар тусгасан байна.

Инноваци

Английн биологийн ухааны амжилтын гол нууц нь инноваци буюу шинэчлэлд оршино. Энэ нь тэргүүлэх судалгааны байгууллага, төр болон бизнесүүд хоорондоо нягт хамтарч ажилладагтай холбоотой. Өөрөөр хэлбэл, судалгааны байгууллагын шинэ нээлт, ололтыг аж үйлдвэр болон үйлдвэрлэлд төрийн зөвшөөрөлтэй хэрэгжүүлдэг гэсэн үг. Үүний нэг тод жишээ бол дэлхийд хамгийн олон Нобелийн шагналтан төрүүлсэн Кембрижийн их сургууль юм. Судалгаа шинжилгээний эцсийн үр дүн нь гадаад болон дотоодын зах зээл дээр давтагдашгүй бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлбэр болдог аж.

Английн хөдөө аж ахуй нь дэлхийд хамгийн их механикжсанд тооцогддог. Газар тариалан эрхлэх талбай нийт нутаг дэвсгэрийнх нь 76 хувийг эзэлдэг бөгөөд дотоодын хүнсний хэрэгцээний 60 хувийг үйлдвэрлэдэг.

Хөдөө аж ахуйд дэлгэрч буй сүүлийн үеийн “моод” бол органик хүнс үйлдвэрлэл. Органик аргаар гаргаж авсан хүнсний бүтээгдэхүүнд хүний бие болон байгаль орчинд харшлах аливаа химийн хольц хэрэглэдэггүй. Засгийн газраас 160 сая фунт стерлинг байгаль орчинд ээлтэй технологи боловсруулахад зарцуулжээ. Энэхүү хөтөлбөрийн үр дүнд гаргаж авсан шинэчлэл бүтээгдэхүүний нэг нь хавдрын эсрэг ▶▶

► үйлчилгээтэй цэцэгт байцаа юм.

Английн хүнс, хөдөө аж ахуйн салбарт 3.8 сая хүн ажиллаж байна. Тус улс цэвэр фермингийн туршлагыг амжилттай хэрэгжүүлж буй. Хөдөө аж ахуйн хаягдлыг бордоонд ашигладаг. Тариаланчид уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний үнэ өсөж буй үнэ тарифын эсрэг нэгэн шинэ арга олсон нь био-түлшний ашиглалт юм.

Газар тариалангийн өөр нэг ололтыг авч үзье. Өнгөрсөн оны зургадугаар сарын байдлаар Их Британи 32 сая толгой хоньтой гэсэн статистик гарчээ. Энд дэлхийд алдартай “Долли” үүлдрийн хонины тухай өгүүлбэр. Долли хонинд зориулж Будапештэд бүхэл бүтэн шинжлэх ухааны музей хүртэл байгуулсан гэнэ.

Анх 1996 оны долоодугаар сарын 5-нд төрсөн Долли хонь гурван эхтэй. Нэг нь өндгөн эсээс, нөгөө нь генийн, гурав дахь нь клоны аргаар зохиомол хээлтүүлэг хийж гаргаж авсан юм. Алдарт Долли нь атомын шилжүүлгийн аргаар эсээс гаргаж авсан клоны хувилбарын анхны хөхтөн амьтан билээ.

Түүнийг Эдинбургийн их сургуулийн Рослины институт дээр клончлон хувилсан аж. Долли хониноос өмнө үнээ, хулганыг клоны аргаар төрүүлсэн туршлага бий. Хонийг клоны аргаар хувилсан нь насанд хүрсэн эсийн генийг ашиглан шинэ организм төрүүлэх бүрэн боломжтойг харуулсан шинжлэх ухааны ололт аж. Долли нь Уэльсийн эр хоньтой ижилсэж, нийт зургаан хурга гаргасан. Харамсалтай нь

Долли хонь 2003 оны хоёрдугаар сард устсан байна. Клоны технологийг ашиглах нь өвчнөөс урьдчилан сэргийлэх болон анагаах, түүнчлэн малын үүлдрийг сайжруулах зэрэгт чухал хувь нэмэр оруулдаг аж.

Их Британийн техник

Аж үйлдвэржилтийн хувьсгал анх Англи улсаас эхэлсэн. Өнөөдөр Их Британийн техникийн салбар улам өргөжижээ. Энэ нь сансрын хөлөг үйлдвэрлэлээс эхлээд материалын шинжлэх ухаан, цаашилбал дэлхийн зэрэглэлийн үйлдвэрлэлийн технологийг багтааж буй.

Хөгжлийн гараан дээрээ ирсэн Монгол Улсын барилга, уул уурхайн салбарт байгаль орчинд ээлтэй технологи ашиглах зайлшгүй шаардлага тулгарч буй. Ийм үед Английн олон жилийн түүхтэй газрын үе судлал, нефтийн салбараас суралцах зүйл цөөнгүй. Британийн компаниуд 1901 оноос эхэлж газрын тос олборлож байна. Тэд өдөрт 2.5 сая баррель газрын тос олборлодог бөгөөд үүгээрээ Европын холбооны гүрнүүдийн дунд байгалийн хий, шатахуунаар тэргүүлэгчийн байр суурийг эзэлдэг. Англичууд Ойрхи Дорнодын цөлөөс Хойд мөсөн туйл дээр ажиллах чадвартай технологийг боловсруулсан ард түмэн.

Технологийн дэвшлийн ачаар Их Британийн компаниуд 2008 оноос газрын тос, байгалийн

хийн 43 хувийг задгай тэнгисээс гаргаж авах болсон. Ингэхдээ тэд нүүрстөрөгч багатай, байгаль орчинд ээлтэй технологи хэрэглэх тал дээр ихээхэн анхаардаг. Тус салбар нь эдийн засагт 183 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж байна. “Carbon Trust” нийгэмлэгийн тооцоолсноор, Английн компаниуд байгальд ээлтэй технологийг арилжаалж, 100 тэрбум ам.долларын ашиг олох боломжтой гэнэ.

Их Британийн уул уурхайн салбар баялаг түүхтэй. Тус улсын ихэнх баялгийг ашиглаад дуусч байгаа ч дэлхийн уул уурхай, эрдэс судлалд шилдэг технологийг нэвтрүүлснээрээ онцлог юм. Кэмборны уул уурхайн их сургууль салбарынхаа тэргүүлэх судалгаа шинжилгээг хийдэг. Түүнчлэн Английн инженерүүд уул уурхайн аюулгүй байдалд ихээхэн хувь нэмэр оруулсан. Сүүлийн үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийг хортой бодис илрүүлэх, гүний уурхайн дотоод орчныг гэрэлтүүлэхэд тусгайлан зориулж үйлдвэрлэжээ.

Их Британийн инноваци нь биологи, байгаль орчны хамгаалал, техникийн салбарт эрс тэс өөрчлөлтийг авчирсан. Энэ бүх салбар Монгол Улсын эдийн засгийн хөгжилд шууд хамааралтай юм. Хөгжлийн туршлагаар баялаг Их Британийн шинжлэх ухааны туршлагыг нэвтрүүлж, хамтарч ажиллах, найдвартай түнш болох бүх боломж нээлттэй. ■



ХОТЫН ЗАХИРАГЧ

ЛОНДОН ХОТТОЙ ТҮНШИЛСНЭЭР МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ХУРДАЦТАЙ НЭМЭГДЭНЭ



Лондон хотын захирагч Лорд Рожер Гиффорд

Нэгэн цагт Чингис хаан хөрш Ханлигуудаа нэгтгэж, дэлхийн хамгийн том хаант гүрнийг байгуулж, алдарт Торгоны замыг сэргээж байсан үеэс хойш 800 гаруй жилийн дараа Монгол Улс өдгөө дэлхийн худалдааны зөрлөг дээр дахин айсуй.

Олон улсын хөрөнгө оруулалт болон санхүүгийн үйлчилгээгээрээ Лондон хот дэлхийд тэргүүлдэг бөгөөд олон улсын санхүүгийн ертөнцийн гол төв юм. Энэ оны эхээр Монголын хөрөнгө оруулалтын дээд хэмжээний уулзалт Лондон хотноо зохиогдож, Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд тулгуурлан гаднын хөрөнгө оруулагчид өөрсдөө туршлага хуримтуулах боломжийг санал болгосон. Энэ уулзалтаар дэлхий дахины хөрөнгө оруулагчид зөвхөн уул уурхай бус харин барилга, бичил санхүү, дэд бүтэц, үнэт цаасны зах зээл, үл хөдлөх хөрөнгө зэрэг бусад салбарт хөрөнгө оруулах ▶

▶ чухал боломж буйг онцлон тэмдэглэсэн. Энэ нь хоёр орны хувьд ажлын байр бий болгох, эдийн засгийн өсөлтөө дэмжихийн тулд дээрх хөрөнгө оруулалтыг Их Британи Монголтой хамтран хөгжүүлэх, удирдан зохион байгуулахад өөрийн туршлагаа хэрхэн хуваалцах боломжтойг тодорхойлж, харилцан ашигтай байх болно.

Их Британи дэлхийн хэмжээний түнш учраас Монгол Улстай улам дотно харилцаатай, ялангуяа худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт харилцаа сайжирч байна. Өнгөрсөн зургаадугаар сард Ерөнхийлөгчийн сонгуульд улиран сонгогдсон Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн хувьд гаднын хөрөнгө оруулалтыг дэмжих нь түүний тэргүүлэх чиглэлүүдийн нэг байв. Монгол-Лондонгийн бизнес форум, Их Британи-Монголын дугуй ширээний 10 дугаар уулзалт зэрэгт хурлын хүрээнд Их Британийн Засгийн газар Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж болон бусад албаны хүмүүсийг дээд хэмжээнд хүлээн авч, хоёр улсын найрамдалт харилцааг цаашид бэхжүүлэх чиглэлээр уулзалт зохион байгуулсан.

Уул уурхайд суурилсан ДНБ-ий өсөлт дангаараа бусад салбарын өсөлт, ажлын байр ихээр нэмэгдүүлэхэд шууд нөлөөлөхгүй гэсэн Монголын Засгийн газрын үзэл бодлын талаар бид Их Британид ярилцдаг. Монгол Улсын хувьд байгалийн баялгаас хэт хамааралтай байдлаа шийдвэрлэж, эдийн засгаа төрөлжүүлэхийн тулд янз бүрийн салбарыг хамарсан төслүүд хэрэгжүүлэхэд нь хувийн хэвшлийнхэнд дэмжлэг үзүүлэх шаардлагатай юм. Монгол Улс хоёр хөрш улсаа холбосон 5700 км шинэ төмөр зам барих, өнөөгийн замын сүлжээгээ өргөтгөх, орон сууцны хангамжаа сайжруулах, эрүүл мэндийн салбарын бүтцийг өөрчлөх зэрэг өргөн цар хүрээтэй ажлуудыг төлөвлөөд буй. Дэд бүтэц бол Лондон хотын хувьд хувийн хэвшлийн санхүүжилтийн санаачилга (PFI) төр, хувийн хэвшлийн түншлэл (PPP)-ийн хүрээнд хэрэгжүүлдэг төслүүдийн экспертиз болон хөрөнгийн хаа ч байхгүй олон улсын бааз бөгөөд Монгол Улс үүнийг ашиглах боломжтой.

Монгол Улс эдийн засгийн тогтвортой өсөлтөө цаашид хадгалахын тулд хууль тогтоомж гаргах, хяналт тавих, нягтлан бодох бүртгэл болон аудитын шатанд хийгдэх

ажлуудыг бэхжүүлэх арга замаар бизнесийн орчин болон компанийн засаглалыг сайжруулах хэрэгтэй гэдгийг ойлгох нь чухал юм. Хууль тогтоомж гаргах, даатгалд хамруулах, маргаан шийдвэрлэх, хуулийн үйлчилгээ үзүүлэх тал дээр Их Британийн экспертиз тун чадварлаг бөгөөд Монгол Улсад хууль, эрх зүйн хүчирхэг орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой.

Хоёр улсын хоорондох эдийн засгийн хамтын ажиллагааны өөр жишээ дурдвал Лондонгийн хөрөнгийн бирж (ЛХБ) Монголын хөрөнгийн бирж (МХБ)-ийг хөгжүүлэхэд бодит тусламж үзүүлэх чиглэлээр ажилласаар ирсэн. 2011 оны байдлаар ЛХБ дэлхийн хоёрдогч том биржээр шалгарч, арилжааны хэмжээ 2010 оноос 32.6 хувиар өссөн үзүүлэлттэй байв. Мөн онд МХБ-ийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, дэлхийн хэмжээний хувьцаат компаниудыг татах, Монголд хөрвөх өндөр чадвар бүхий зах зээлийг бий болгох зорилгоор МХБ-тэй хийсэн 14 сая ам.долларын өртөг бүхий гурван жилийн түншлэлээ амжилттай дуусгажээ. ЛХБ болон дэлхийн бусад хөрөнгийн биржэд өдгөө ашиглаж буй хамгийн хурдан арилжаа хийдэг MillenniumIT загвар руу МХБ өнгөрсөн онд амжилттай шилжин орсон.

Өнгөрсөн тавдугаар сард Монгол Улс Үнэт цаасны тухай шинэ хуулиа баталснаас хойш МХБ-ийг орчин үеийн болгох, шинэчлэх ажлаа үргэлжлүүлэн хийж буй. Ирэх жилүүдэд компаниудын үнэт цаасны зах зээл дээрх хөрөнгийн хувь хэмжээ, хөрвөх чадвар болон хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн хэмжээ хурдацтай өсөх боломжийг бүрдүүлэх хосгүй түншлэл байх болно.

Энэ онд Их Британи Монгол Улстай дипломат харилцаа тогтоосны 50 жил тохиож буй. Лондон хотын төлөөлөгчдийн Монгол Улсад хийх айлчлал нь Их Британийн зүгээс Монгол Улсыг дээд түвшинд сонирхож буйг дахин харуулж буй хэрэг бөгөөд бидний цаашдын амжилтад чухал ач холбогдол бүхий харилцан ашигтай санхүүгийн харилцааг улам бэхжүүлнэ гэдэгт найдаж байна. ■

Лондон хотын захирагч Лорд Рожер Гиффорд

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ

ЭЕРЭГ ХӨГЖИЛ

Б.СОНДОР

Олимп. Эл үгний утга энгийн хийгээд агуу. Эртний Грекээс эхтэй Олимпийн наадам үндэс угсаа, шашин шүтлэг, арьс өнгөөр үл ялгаварлан спортын тэнгэр дор олон түмнийг нэгтгэдэг онцлог үйл явдал. Бээжингийн хэмээх тодотголтой 2008 оны зуны Олимпийн наадмаас монгол түмэн алтан медаль хүртэж байсан түүхэн агшин одоо ч бидний сэтгэлд тод.

Энхтайван, эв нэгдлийн бэлгэ тэмдэг болох спортын энэ наадамд дэлхийн тамирчдын авхаалж самбаа, хурд, хүчийг сорихын зэрэгцээ зохион байгуулж буй орны нэр төрийн нэгээхэн хэсэг болсон гэлтэй. Үүгээр

ч зогсохгүй тухайн орны төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг илтгэх хэлбэр ч гэх. Учир нь илүү сүрлэг, илүү гайхамшигт Олимпийн наадмыг зохион байгуулах эрхийн төлөө дэлхийн топууд өрсөлдөхийн тулд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын буухиа эхлүүлдэг.

Өнгөрсөн онд Лондон хотноо болсон Олимпийн наадамд Лондон хотын захиргаа л гэхэд 925 сая фунт стерлингийн хөрөнгө оруулжээ. Түүнчлэн бүтээн байгуулалтын нийт төсөв гурав орчим тэрбум фунт стерлинг болсон тухай 2012 оны Лондонгийн Олимпийн Ерөнхий хорооны дарга ноён Жон Армитт өгүүлсэн. Хувийн хэвшлийн олон

байгууллагаас гадна Их Британи улсын Соёл, хэвлэл мэдээлэл, спортын яам болон Лондонгийн Олимпийн Ерөнхий хороо зэрэг төрийн төлөөлөл тус наадмыг зохион байгуулах ажилд хүчээ үзсэн билээ. Энэ удаагийн Олимпийн наадам дутуугаа нөхөж, дундуураа дүүргэх замаар хамтран ажиллах нь төр болоод хувийн хэвшлийнхэнд өгөөжөө өгч болдгийн сонгодог жишээг дэлхий нийтэд харуулсан гэдэгтэй олон нийт санал нэг.

Тамирчид болоод Лондон хотноо саатах гийчдийг хүлээн авахад зориулсан бүтээн байгуулалтыг Олимпийн наадмын дараа ч олны мэлмийг баясгахуйц байхаар зохион байгуулж чадсан нь тун сонирхолтой. Түүнчлэн хотын хөгжлийн үлгэр жишээ шийдлүүдийг эдийн засгийн үр ашигтайгаар төлөвлөсөн нь Олимпийн наадмыг зохион байгуулах халааг сэлгэх орнуудад үнэтэй зөвлөмж болсон биз ээ. Тухайлбал, London Legacy 2020 хөтөлбөрийн хүрээнд Олимпийн наадмын үеэр ашиглах спорт цогцолборууд болон Олимпийн хотхоныг ногоон байгууламж, урлаг соёлын хүрээлэнгүүдээр “чимсэн” нь Лондон хотын орхигдсон хэмээгдэж байсан зүүн бүсийг “амьлуулсанд” лондончууд сэтгэл хангалуун явдаг аж. Хотыг дахин төлөвлөх ажлын хүрээнд тус хэсэгт байрлах Олимпик парсад 45 га газрыг хамарсан ногоон байгууламжийг бүтээсэн төдийгүй гол, горхиуд болоод тэдгээрийн эргүүдийг сэргээж засварласан юм. Түүнчлэн тус хэсгийн эрчим хүчний 20 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс авна хэмээн төлөвлөж байжээ. Хэдий уг зорилтыг бүрэн биелүүлээгүй ч Олимпик парк болоод ▶



Лондонгийн Олимпик парк, 2012 он



▶ хотхоны эрчим хүчний хэрэглээний есөн хувийг сэргээгдэхээр хангаж чадсан билээ. Эзэнгүй арал мэт хоосон байсан Лондонгийн зүүн бүсийг “баянбүрд” болгох ажилд ердөө долоон жил зарцуулжээ. 2012 оны Лондонгийн Олимпын наадмын зохион байгуулагчдын үзэж буйгаар бүтээн байгуулалтын дээрх ажлууд хот төлөвлөлтийг шинэ түвшинд

хүргэсэн шийдлүүд аж. Тухайлбал, Олимпын хотхоныг наадмын дараагаар хувийн болон түрээсийн орон сууц хэлбэрээр ашиглахаар зохицлоосон төдийгүй түүнийг хүрээлэн боловсролын болоод эрүүл мэндийн үйлчилгээний төвүүд байрлах нь хүний хэрэгцээг илүү ойртуулсан хэрэг болжээ.

Лондон хотыг тэгнэн урсах “Thames” голын эрэг дагуу салхин сэнс, жижиг оврын усан цахилгаан үүсгэвэр суурилуулах асуудал дахин төлөвлөтөд багтаж байсан ч аюулгүй байдлын үүднээс уг шийдлийг хэрэгжүүлэх боломжгүй болсон гэдэг. Энэ мэтээр “Ногоон Олимп” цолыг зүй ёсоор хүртэх 2012 оны наадам хүсэл хийгээд зорилго байхад хот тохижилт, төлөвлөлтийг байгальд ээлтэй замаар шийдвэрлэж болдгийг харуулсан тод жишээ болсон билээ. ■

ӨНГӨ

ОЛИМПИЙН ХОТХОНД ХӨГЖИЛ ҮРГЭЛЖИЛСЭЭР

Б.ЭНХ

Жон Александр Армитт 2007 оны есдүгээр сард Их Британийн Олимпын хорооны тэргүүнээр сонгогдон өдгөө хүртэл ажиллаж байгаа бөгөөд “City and Guilds of London” хүрээлэнгийн захирал, “National Express Group” тээврийн компанийн захирал, “Berkeley Group” компанийн орлогч захирал, Лондон хотын тээврийн газрын орлогч захирлын албан тушаалыг тус тус хашиж байжээ. Тэрбээр Инженер, физикийн шинжлэх ухааны судалгааны зөвлөлийн тэргүүн байсан бөгөөд Хатан хааны инженерийн академи,

Иргэний инженерийн хүрээлэнгийн гишүүн юм.

Тэрбээр өнгөрсөн оны Лондонгийн Олимпыг олон олон хүний сэтгэлд хоногштол зохион байгуулж, ялангуяа шинэ хөгжлийн бодлогыг танилцуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан хүн юм. “Mongolian Economy” сэтгүүлийн тусгай баг Лондонд түүнтэй ийн ярилцсан юм.

-Лондонгийн Олимп бусдаас юугаараа илүү байсан гэж Та бодож байна вэ?

-Олимпын тоглолт хаана болохоос үл хамааран нийтлэг тулгарах асуудал ▶



► нь зохион байгуулагч орны Засгийн газар, орон нутгийн болон бүс нутгийн захиргаа байдаг. Ихэнх тохиолдолд энэ гурван нэгж хамтран үр дүнтэй ажилладаггүй нь харилцан адилгүй зорилготой байдгаас үүдэлтэй. Олимп зохион байгуулах бидний ажилд дэмжлэг үзүүлэх үүднээс манай орны улс төрийн хоёр том нам хоорондоо ер бусын нэгдмэл байж чадсан. Манай Олимпын хороо хөгжлийн төлөөх байгууллага учраас Засгийн газар төлөвлөлт хийх эрх мэдлийг бидэнд өгсөн. Тиймээс бидний хувьд орон нутгийн засаг захиргаатай зөрчилдөхөд хүргэх энгийн нэг төлөвлөгөө боловсруулах утгагүй байв. Харин эрх мэдлийнхээ хүрээнд орон нутгийн засаг захиргаатай уулзаж, зөвшилцсөн. Бид тэднийг сайн сонсож, улмаар юу хийх гэж байгаагаа ойлгуулж чадсан. Үүнд л гол ялгаа нь оршиж байгаа.

Олимпын тоглолтыг зохион байгуулахад хамгийн чухал нь цаг хугацаа. Бусад ямар ч төсөл, хөгжлийн хөтөлбөрт цаг алдах, хоцрох асуудал байж болдог. Харин Олимпын хувьд хором ч хоцрох эрхгүй. Дэлхий нийт юу хийж байгааг чинь алхам тутам ажиг байгаа шүү дээ.

Энэ ажлыг эхэлснээс хойш хамгийн чухал нь цаг гэдгийг бид өөрсдөдөө ч хэлж байсан. Тиймээс бүгдийг нарийн төлөвлөсөн тул тоглолт эхлэхээс нэг жилийн өмнө барилгын ажлаа дуусгаж чадсан. Бүтэн жилийн хугацаанд бэлтгэл ажил хэвийн явж байгаа эсэхийг шалгаж, туршсан. Олимпын наадмыг зохион байгуулж байсан зарим оронд долоо хоногийн өмнө ч бэлтгэл ажил нь дуусаагүй сандралдаж байсан удаатай. Бид тэр эрсдэлийг бууруулахыг зорьсон.

-Нууц биш бол нийт хэдий хэмжээний төсөвтэй байсан бэ?

-Төсвийн хувьд үндсэн зардал дээр гарч болзошгүй зардлыг 30 хувиар нэмж тооцсон. Бидний төсөв нийт зургаан тэрбум фунт стерлинг (9.2 тэрбум ам.доллар)байснаас талыг нь зарцуулсан.

Гарч болзошгүй зардлыг тооцох нь төлөвлөлт хийх үед маш чухал бүрэлдэхүүн хэсэг. Учир нь төлөвлөсөн зардлаа яг таг зарцуулаад ажлаа дуусгана гэж урьдчилан хэлэх боломжгүй. Энэ нь зардлаа оновчтой гаргахыг оролдож буй хэрэг. Төсвийг мэдрэмжтэй гаргаж чадвал тухайн



Их Британийн Олимпын хорооны тэргүүн Жон Александр Армитт

Фотог Э.Зоригт

төслийг амжилттай хэрэгжүүлэхэд илүү дөхөмтэй. Зардлыг хэт бага тооцвол тэр хэмжээгээр олон бэрхшээл үүсч, асуудлаас гарахын тулд бүр ч их мөнгө зардаг.

-Томоохон төслүүдийн хувьд анх төлөвлөснөөрөө дуусгаж чадалгүй цагаасаа хоцрох, төсвөө хэтрүүлэх нь нийтлэг үзэгдэл гэж зарим хүн хэлдэг. Та үүнтэй санал нэгддэг үү?

-Би үүнтэй огт санал нэгддэггүй. Аливаа төслийг хөрөнгө оруулалтын шатанд сайтар бодож, төлөвлөн, хүмүүс эрсдэлийг үнэлэхэд ихэнх тохиолдолд хангалттай цаг хугацаа зарцуулдаггүй. Тухайн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөлтөд зөв зүйтэй, сайтар бодож тунгаах завдал өгөлгүйгээр

барьж босгох ажлыг аль болох хурдан эхлүүлэх дарамт шахалт улстөрчдийн зүгээс ирэх нь элбэг. Тиймээс төсөл хэрэгжүүлэх гэж байгаа бол илүү төсөв, илүү цаг зарцуулахад бэлтгэлтэй байх шаардлагатай.

Өөр нэг зүйл нь төслийн хүрээнд санаа бодол байнга өөрчлөгдөх гээд байдаг тал бий. Өөрийн төлөвлөгөөнд тодорхой байх хэм хэмжээг барьснаар таны эргэлзээ багасах талтай. Үүнд цаг их орох нь бий. Төсөл хэрэгжих эхний жилд бодсоноос ч илүү их мөнгө үрэгддэг. Бидний хувьд долоон жилийн хугацаа байсан. Эхний хоёр жилийн хугацааг бодож боловсруулах буюу төлөвлөхөд зарцуулсан бол барилгын ажлыг дараах дөрвөн жилд гүйцэтгэж, ►

Улсын комисс хүлээн авснаар дууссан. Харин Олимпийн наадмын бэлтгэл ажилд сүүлийн нэг жилийг зарцуулсан.

Хүмүүс барилгын ажлыг аль болох хурдан эхлүүлэхийг хүсдэг. Гэвч энэ асуудлын учиг биш. Бидний хувьд төлөвлөгөөгөө өргөн хүрээнд боловсруулсан учраас тэр болгон өөрчлөөд байх шаардлага гараагүй.

-Олимпийн цогцолборыг байгуулах төсөлдөө ногоон хөгжлийн арга барилыг хэр тусгасан бэ?

-Зорилгоо сайн тодорхойлох хэрэгтэй гэж бодож байна. Зорилтуудаа тодорхой болгох нь Засгийн газрын зохицуулалтад ч хамаатай. Бидний баримталсан арга барил загвар зохион бүтээгчид, ханган нийлүүлэгчиддээ өөрсдийн зорилгын талаар бүгдийг тодорхой хэлсэн.

Бид нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг 50 хувиар багасгах, бараа материал нийлүүлэх тээврийн хэрэгсэл зорчих замын тоог хамгийн доод түвшинд барих, цогцолборыг барихад шаардах цэвэр усны ашиглалтыг багасгах, бүх байгууламжид хэрэглэх эрчим хүчний 20 хувийг сэргээгдэх эрчим хүчнээс гарган авах, барилгын ажлын явцад гарсан хаягдал материалын 95 хувийг дахин ашиглах зэрэг зорилт тавьсан. Эдгээр ажлын гүйцэтгэлийг хэмжихийн тулд маш тодорхой төлөвлөгөө гарган ажилласан байгаа.

Энэ утгаараа зорилгодоо хүрэхийн тулд хүмүүсийг бидэнтэй уулзаж, хамтран ажиллахыг уриалсан бөгөөд дээрх зорилтуудад хүрч чадсан. Бидний хувьд нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах талаар өөрийн Засгийн газар төдийгүй дэлхий нийтийн хүчийг сорьсон хэрэг болсон гэж үзэж байна. Цогцолборын зураг, төслийг гаргасан хүмүүс Засгийн газар өөрсдийнх нь хийж буй зүйлийг үнэхээр хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, дэмжсэн тууштай бөгөөд тогтвортой арга хэмжээ авахыг хүсч байв. Энэ тохиолдолд хүн бүр оролцох эрх тэгш нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай. Тэд өрсөлдөөн дунд байсан учраас инноваци үүсгэн санаачлах хэрэгтэй байв. Өрсөлдөх чадвараа хадгалахын зэрэгцээ стандартад нийцүүлж чадсан.

-Хаягдал, бохирдлын асуудлыг шийдвэрлэх нь ногоон хөгжлийн санал, санаачилгын нэг хэсэг байсан

уу?

-Хорин жилийн өмнө химийн бодисоор бохирдсон хөрсний асуудлыг шийдвэрлэх хялбархан шийдэлтэй байв. Хаа нэгтээ том нүх ухаад, хог хаягдлаа аваачаад булах. Хогийн цэг гэж нэрлэдэг шүү дээ.

Дээрх зүйлд нөлөөлөх хоёр хүчин зүйл бий. **Нэгдүгээрт**, Засгийн газар хогийн цэгт ногдуулах татварыг тогтоодог бөгөөд компаниуд хог, хаягдлаасаа салахын тулд мөнгө төлөх шаардлагатай. Тухайн хог хаягдлын хэр хор, хөнөөлтэй байна тэр хэмжээгээр мөнгө төлөх хэрэгтэй бөгөөд мөн тэр хэмжээгээр хүндрэл учирдаг. **Хоёрдугаарт**, замын бөглөрөл, бохирдол үүсгэдэг ачааны автомашины тоог бууруулахыг зорьсон. Бөглөрөл, бохирдол тухайн бүс нутгийн оршин суугчдад ихээхэн хүндрэл учруулдаг. Хэрэв зардлыг бууруулж, тухайн орон нутгийн ард иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг сааруулах шаардлагатай гэж үзэж байгаа бол цорын ганц асуулт гарч ирнэ. Хөрсийг хэрхэн цэвэрлэх вэ?

Бид бохирдсон нийт хөрсний 95 хувийг цэвэрлэж, нөхөн сэргээлт хийсэн. Хаягдал бохирыг үлдсэн таван хувийн хэсэгт цуглуулсны дараа холбогдох төлбөрийг төлж, хогийн цэг дээр хаясан. Хамгийн чухал нь бид ашигласан талбайн 95 хувийг бүрэн цэвэрлэж чадсан. Үүнд мэдээж хөрөнгө зардал их орсон л доо. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах бидний эрмэлзэлтэй холбоотой.

-Олимпоос та бүхэн юу суралцсан бэ?

-Бид хамтарч ажилласан бүх компанийнхаа талаар судалгаа хийсэн. Үүнд хамгийн сайхан санагдсан зүйл нь хамтын ажиллагаа.

Барилгын ажлыг анх эхлүүлж байсан үеийг эргэн санахад улстөрчид энгийн үед байдгаасаа хамаагүй идэвхтэй хамтран ажилласан. Тэд байнга л маргалдаж байдаг шүү дээ. Харин энэ ажлын хүрээнд улстөрчид бүх түвшинд гэрээ, хэлцлийг хийж байв. Ард иргэд ч бидэнтэй хамтран ажиллаж, бие биенээ дэмжиж байлаа. Тэд хамтдаа амжилтад хүрнэ, эсвэл хамтдаа унана гэдгээ сайтар ухамсарлаж байсан. Энэ төсөл дээр ард иргэдийн оролцоо үнэхээр сайн байсан гэдгийг онцлох ёстой.

-Өмнөх төслүүдтэй харьцуулахад энэ төсөлд ямар үнэлгээ өгөх вэ?

-Гарсан үр дүнгээрээ энэ төсөл хамгийн шилдэг нь байх. Миний ажигласнаар энэ төсөл хэрэгжих явцад олон зүйл хэвийн хэм хэмжээнээс илүү хурдацтай хийгдэж байв. Хүмүүс шинэ сорилт, бэрхшээлтэй тулгарахад бэлэн байсан. Төсөл хэрэгжүүлэх нь үйл ажиллагаа нь ид өрнөж буй бизнесийг удирдахаас илүү хялбархан гэж би үздэг. Төсөлд тодорхой алсын хараа, зорилтыг шинээр тавих боломжтой бөгөөд бизнесийг бодвол харьцангуй богино хугацаанд хэрэгждэг. Харин бизнест илүү урт хугацаа шаардагдах бөгөөд холбогдох зах зээлд юу болоод байгааг олж мэдэх зайлшгүй шаардлагатай тулгардаг. Хүмүүс гол төлөв илүү тогтвортой орчинд амьдрах сонирхолтой. Тэд аливаа өөрчлөлтөнд дуртай биш байдаг. Тэдний сэтгэлийн хөдлөлийн мэдэрэмжийг төрүүлнэ гэдэг тун хэцүү. Харин төсөл санаачилж, хэрэгжүүлснээр хүмүүсийн сэтгэл хөдлөлийн утсыг хөндөхөд илүү хялбар байдаг.

Миний эрхэлдэг ажлуудаас хамгийн бэрхшээлтэй нь төмөр замын байгууллагын гүйцэтгэх захирал. Энэ бол Олимпийн цогцолборыг барьж байгуулахаас илүү хүнд хүчир ажил. Гэхдээ ажилдаа сэтгэл дүүрэн явдаг.

-Дараагийн том алхам юу вэ?

-Энэ тал дээр бидэнд тулгарч буй сорилт бол Олимпид хийсэн хөрөнгө оруулалтын үр ашгийг хүмүүст харуулах. Учир нь, энэ хөрөнгө оруулалт 10-20 жилдээ үр өгөөжөө өгсөөр байх боломжтой. Олимпийн тоглолтыг зохион байгуулсан орнуудын хувьд сайхан, муухай дурсамж, түүхийн аль аль нь үлдэж хоцорсон байдаг.

Олимпийн цогцолборыг цаашид хэдэн жил хэрхэн ашиглах тал дээр Олимпийн наадам эхлэхээс гурван жилийн өмнө цогцолборыг хариуцан ажиллуулах компанийг байгуулах шийдвэрийг бид гаргасан. Өнөөдөр Лондонгийн Олимпийн хотхонд хөгжил, дэд бүтцийн ажил үргэлжилсээр байгаа бөгөөд бид 7000 орон сууц нэмж барихаар төлөвлөөд байна. Тэнд хоосон, хүнгүй барилга байгууламж байхгүй болно. Тоглолт болсон бүс нутгийг хөгжүүлсээр байх болно. Олимпийн тоглолтыг зохион байгуулах нь сайн үр дүнд хүргэсэн гэдгийг хүмүүс 2013 онд биш, харин 2025 онд илүүтэй ярилцаад сууж байх болно. ■

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ


ҮНЭТ ЗҮЙЛИЙН ҮНЭТЭЙ ЗҮТГЭЛ

Б.ЖАРГАЛ

Мазаалай, хавтгай гээд ховордсон олон төрлийн амьтдын “гэр” нь болдог манай улс үзэсгэлэнт байгалийнхаа үнэт баялгийг хамгаалах асуудал тэргүүний болж буйг олон улсын эрдэмтэд анхааруулж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт бэлчих зэрлэг ан амьтдыг хамгаалахад Их Британийн эрдэмтэн, судлаачид болон байгаль хамгааллын байгууллагууд чухал үүрэг гүйцэтгээр ирсэн. Тэдний нэг нь Английн Амьтан судлалын нийгэмлэг юм. Сингапур улс оршин тогтноход тэргүүлэх хувь нэмрээ оруулсан гэх Стамфорд Раффлс тус нийгэмлэгийг 1826 онд байгуулсан түүтэй. Өдгөө уг нийгэмлэг зэрлэг ан амьтад, тэдний амьдрах орчныг хамгаалах үйлсэд хичээнгүйлэн зүтгэж байна. Чарльз Дарвин тэргүүтэй шинжлэх ухааны нөлөө бүхий төлөөллүүд тус нийгэмлэгт гишүүн байсан зэргээс үзвэл Английн Амьтан судлалын нийгэмлэг нь энэ чиглэлдээ дэлхийд нэр хүнд бүхий байгууллага аж.

Уул уурхайн орон нэрээр олон улсад танигдсан манай улсын хувьд эдийн засгийн хурдацтай өсөлтөө дагаад эко системийн уналт ойр байгааг судалгааны тайлангууд харуулах. Иймд Лондонгийн Амьтан судлалын нийгэмлэг 2003 онд Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам (өдгөө Байгаль орчин, ногоон хөгжлийн яам) болон МУИС-



Ховордсон зэрлэг ан амьтдын тоонд орж буй хулан, хавтгай

тай хамтран ажиллах болсон. Уг хамтын ажиллагааны хүрээнд тус нийгэмлэг МУИС-ийн хамтаар “Steppe Forward” хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ амьтан хамгааллын бусад төслийг ч санаачлан амжилттай удирдаж явна.

Цөл, ус, намаг, мод, тал хээр, уул хад гээд манай орны байгалийн тогтоц янз бүр. Үүнийгээ дагаад нутаглах амьтдын төрөл ч олон. Гэвч уул уурхайн үйл ажиллагаа, үйлдвэржилт зэрлэг ан амьтдын амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлж тэднийг нүүдэллэх, цаашлаад бүрмөсөн дайжихад хүргэдэг байна. Түүнчлэн цэвэр усны хангамж, хүн амын сууршил, дэд бүтцийн хөгжил зэрэг нь байгалийн бүтцийг өөрчилж

буй нь тэдгээр амьтдыг нүүдэллэх горим, чиглэлийг алдаглуулах аюулыг дагуулж буй. Улмаар хулан, хар сүүлт зээр, бөхөн гөрөөс гэх мэт ховор амьтад хэл дамнан нутагшихаас өөр сонголтгүй болж байгаа аж. Нүүдэллэх горим ийнхүү алдагдах нь тухайн зэрлэг амьтан хоол хүнсний хомсдолд орохоос эхлээд тоо толгой цөөрөх, устаж үгүй болох эрсдлийг дагуулдаг байна.

Экосистемийн хэмнэл энэ мэтээр доголдсоор байвал ирээдүй хойч маань онгон дагшин байгалийг зурагнаас л олж харах аж. Тиймээс байгаль орчны асуудлыг эртнээс анхаарч, энэ чиглэлд дорвитой алхмуудыг хийх шаардлагатай байгаа юм. Ингээгүй тохиолдолд ▶▶

► биологийн хэмд өөрчлөлт орж, экологийн тэнцвэрт байдал алдагдан ан амьтдын тоо толгойг хэрэгцээт орчноор хангаж чадахгүйд хүрнэ. Энэ үед зэрлэг амьтад шаардлагатай бүхнийг хиймлээр бүтээх асуудал тулгарах бөгөөд үүнд жилд 50 хүртэлх их наяд ам.доллар зарцуулах болно хэмээн Дэлхийн банк тооцоолжээ.

Байгаль эхдээ заналхийлж буй хүчин зүйлсийн нэг нь хүн төрөлхтөн өөрсдөө. Хөгжлийг зөвхөн зоосны нүхээр харж буй нь хөгжлийн мөн чанар болох байгалийн тэнцвэрт байдлыг “гишгэлж” байгаа хэрэг гэдгийг хүн бүр ухамсарлах учиртай. Лондонгийн Амьтан судлалын Монгол Улсад хэрэгжүүлж буй “Steppe Forward” төслийн зохицуулагч, биологич Натан Конабойн тэмдэглэснээр монголчууд ч гэсэн энэ зарчмыг дээдлэн хүндэлж, уул уурхайд суурилсан эдийн засгийн огцом өсөлтийн үр шимийг байгаль орчноо хамгаалан сайжруулах, улмаар аялж зугаалахад таатай, хөгжингүй орон болоход зориулах ёстой аж.

Дээрх төслийн хүрээнд ховордсон зэрлэг ан амьтдыг хамгаалах ажлыг бүхий л салбарын төлөөллүүдтэй хамтран зохион байгуулах санаачилгууд хэрэгжиж хээрийн гарын авлага, зэрлэг ан амьтдын тухай ном гээд нийт 14 хэвлэмэл гарсан байна. Мөн төслийн багийнхан хамгийн сүүлийн үеийн технологи болох автомат мэдрэгчтэй алсын зайны 100 камерийг тусгай хамгаалалтын бүсүүдэд байршуулан зэрлэг ан амьтдын зураг, дүрс бичлэгийг буулгаж чаджээ. Тэдгээрийн тусламжтайгаар “Wild-life Picture Index” буюу зэрлэг амьтдын зурган индекс гаргаж тусгай хамгаалалтгүй бүс нутгуудад нутаглах амьтдын тоо толгойтой харьцуулсан судалгаа хийжээ. Энэхүү ажил нь Монгол Улсын тусгай хамгаалалттай бүсүүдийг хүрээг тэлж, нэмэгдүүлэхэд чухал аж холбогдолтой болсон юм. Түүнчлэн тус нийгэмлэг хэрэгжүүлж буй бусад төслийнхээ хүрээнд Говь-Алтай, Өмнөговь зэрэг аймгийн байгаль хамгаалагч, багш нарт сургалт зохион байгуулж байна. Мөн Монгол, гадаадын сургуулиудын дунд оюутан солилцооны хөтөлбөр

явуулж байгаа нь тэднийг нэгнээсээ суралцаж туршлага солилцох, хээрийн сургалтад хамрагдах гэх мэт өргөн хүрээтэй боломжуудаар хангах, хөхиүлэн дэмжих зорилготой аж. Үүгээр ч зогсохгүй амьтан судлалын салбарт ач холбогдол бүхий мэдээллийг дамжуулах, залуу биологичдыг салбартаа амжилт гаргахад нь дэмжих, урамшуулах

болон байгаль хамгааллын хүчтэй дуу хоолой болох хүсэл агуулан ажиллаж байна.

Английн Амьтан судлалын нийгэмлэг болон түүний үйл ажиллагаа, “Steppe Forward” хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Nathan.conaboy@zsl.org хаягаар имейл илгээх эсвэл www.zsl.org/mongolia цахим хуудсаар зочлоорой. ■

ТЕХНОЛОГИ

ХУВЬСЛААС ХУВЬСГАЛ РУУ

Э.ТАМИР

Хар сургамж

1952 он. Лондон хот. Чимээгүй, алуурчин “smog” буюу утаат манан ганцхан сарын дотор 10 мянга гаруй хүний амийг авч одсон хар жил. Тухайн үед “Сант Бартоломю” эмнэлэгт ажиллаж байсан Доктор Роберт Воллер “Маш олон хүний амь нас сүйдсэнээр авсны хүрэлцээ муудаж, цэцгийн худалдаа эрс нэмэгдсэн” гэсэн байна. Үхлийн аюултай утаат манангийн гол үүсгэгч нь нүүрсээр ажилладаг цахилгаан станц байсныг судалгаагаар тогтоожээ. Лондон хотын уг эмгэнэлт түүх байгаль орчны бохирдлыг дэлхий нийт өөр өнцгөөс харахад хүргэсэн билээ.

Тэгвэл Улаанбаатар хотод Лондонгийн гашуун түүх давтагдаж, “алуурчин манан” айлчлахгүй гэсэн баталгаа алга. Цаг уур орчны шинжилгээний газраас гаргасан судалгаагаар зарим үед Богд уулын ар бэлийг даган гэр хорооллын зүг рүү чиглэх агаарын урсгалаас 50 метрийн



өндөрт -40 орчим хэмийн хүйтэн агаарын давхарга бий болох үе байдаг. Ийм тохиолдолд газрын давхаргаас 50 метрийн өндөрт бохирдсон агаар бөөгнөрөх бөгөөд энэ үед агаарын бохирдлын хор хөнөөл улам ихэсч манан бий болдог талаар дурджээ. Ийм нөхцөл байдал гурав ба түүнээс дээш хоног үргэлжилбэл Лондонд тохиолдсон хар өдрүүд ирэхийн дохио гэнэ. ►►

► Монголын Засгийн газрын түвшинд гэр хорооллыг утаагүй зуухаар хангаж, Улаанбаатарыг “Утаанбаатар” нэрнээс нь ангижруулах ажлыг идэвхтэй хийж байгаа. Гэхдээ энэ нь тийм ч үр дүнтэй арга биш гэж маргах хүн олон. Учир нь, Монголын цаг агаар, газар зүйн байрлалын онцлогоос болж цахилгаан станцад өдөр бүр шатаах 14 мянган тн (гэр хороололд шатаадаг нүүрснээс 8-10 дахин их) нүүрсний утаа хүйтэн агаарын улмаас гэр хорооллын дээгүүр бөөгнөрдөг. Энэ нь утаат манан үүсэх эхлэл ажээ.

60 гаруй жилийн өмнө утаа нь гамшгийн хэмжээнд хүрч байсан Лондон хот өдгөө ногоон өнгөөр солонгорно. Хоёр жил тутамд Йелийн их сургуулиас гаргадаг байгаль орчны үнэлгээнд Их Британи улс 2010 онд 14-р байрт зогсож байсан бол 2012 онд есдүгээр байр руу урагшилжээ. Тиймээс дэлхийн тавцанд агаарын бохирдлоороо “нэрээ дуурсгаж” байгаа улаанбаатарчуудад лондончуудаас суралцах зүйл их. Хэрвээ амжилттай суралцаж чадвал Улаанбаатар “Утаанбаатар” нэрнээсээ салах боломжтой гэсэн үг.

Утаанаас болж ард иргэдээ алдаж байсан Их Британи улсын эрчим хүчний салбар үйлдвэрлэлийн хүчин чадлаараа дэлхийн эрчим хүчний хөгжилд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг бөгөөд 2030 он гэхэд 34 мянган цаг/терраватт эрчим хүч үйлдвэрлэх тооцоотой байна. Үүний тулд сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, атомын болон дулааны цахилгаан станцуудыг шинээр байгуулж, мөн засвар үйлчилгээг үргэлжлүүлэн хийх талаар тус улсын эрчим хүчний салбарын судалгаанд дурджээ. Их Британийн эрчим хүчний салбарын хөрөнгө санхүүгийн жилийн эргэлт 50 тэрбум ам.доллар бөгөөд үүний зургаан тэрбум ам.долларын эрчим хүчийг 100 гаруй орон руу экспортолдог байна. Өөрийн орны эрчим хүчний хэрэглээг хангаад зогсохгүй дэлхийн олон улсад эрчим хүч экспортлохын тулд Их Британийн компаниуд нэг зууны туршид чухам юу хийсэн бол.

Сэргээгдэх эрчим хүч

Их Британи нь Европ даяараа

хамгийн салхитай газруудын нэгд тооцогдох бөгөөд далайн эргийн хэсгүүдэд далайн түрлэг, давалгаа ихтэй байдаг учраас сэргээгдэх эрчим хүчийг тонн тонноор үйлдвэрлэдэг гэхэд хилсдэхгүй. Ганцхан жишээ дурдахад тус улс 2050 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний салбарт 175 мянган ажлын байр шинээр бий болгож, жилд 40 тэрбум ам.долларын орлого олох төлөвлөгөөтэй байгаа аж. Мөн британичууд салхины эрчим хүчээ нэг гВт хүчин чадалд хүргэж чадсан анхны том зах зээлтэй орон болж чаджээ. Одоогоор салхин эрчим хүч үйлдвэрлэлд тус улсын компаниуд дэлхийд тэргүүлэх эгнээнд явж байна. Тиймээс цэвэр эрчим хүчний салбарт технологийн инновацийн судалгаа, хөгжил, ашиглалтаараа манлайлах байр суурьтай байдаг ажээ. Нарны эрчим хүчний зах зээл өнөөгийн ханшаар жилийн 1.6 тэрбум ам.доллартай дүйж байгаа бөгөөд тус улсын компаниуд болон их сургуулиуд нарны гэрлийг эрчим хүч болгон хувиргах судалгаагаар дэлхийд тэргүүлэх байр суурьтай байна.

Тиймээс сэргээгдэх эрчим хүчний



Салхитын салхин парк

▶ салбарт хүч сорихоор шийдсэн монголчууд Английн туршлагаас суралцах, хамтран ажиллах нь илүү үр дүнтэй юм. Хамтран ажиллаад ч эхэлжээ. Монголын эрчим хүчний салбарт тохиосон түүхт явдлын нэг болох “Ньюком” группын 50 мВт-ын салхин станцыг барьж байгуулахад Английн “Sgurr Energy” компани техникийн зөвлөхөөр ажилласан. “Clear energy” компанийн үйл ажиллагаа хариуцсан захирал Ц.Сүхбаатар “Монгол Улсын түүхэнд анх удаа сэргээгдэх эрчим хүчний салхин станцыг барьж байгуулахад олон хүний хүч хөдөлмөр шингэлээ. Тэр дундаа Английн “Sgurr Energy” компанийн хамт олонтой төслийг эхлэх тэр үеэс техникийн зөвлөхөөр хамтарч ажилласан нь нүдээ олсон хэрэг байлаа” гэсэн юм.



Тус компани нь Салхитын салхин парк төслийн ТЭЗҮ-г хийх, анхан шатны зураг төсөл, гэрээ хэлэлцээр хийх, техникийн тодорхойлолт зэргийг нэгтгэсэн байдлаар хийх талаар зөвлөгөө авах хүсэлтийн дагуу төсөлд оролцжээ. Мөн төслийн багт туслалцаа үзүүлж, зөвлөлийн багийг бүрдүүлсэн байна. “Sgurr Energy” компанийн ерөнхий инженер Энди Баркер “Монгол Улсын хувьд тулгарч буй томоохон сорилтын нэг бол эрчим хүчний сайн холболт хийх. Монгол орон Азийн супер цахилгааны сүлжээ (Asian super grid)-г бий болгохын тулд иймэрхүү холболтыг сайн хийж өгөх нь эрчим хүчний салбарт гарч буй сайхан боломж байх болно. Сэргээгдэх эрчим хүч бол ирээдүйдээ оруулж буй цэвэр хөрөнгө оруулалт юм. Дэлхий дахинд тулгараад буй хамгийн том гурван сорилт бол технологийн, нийгмийн болон санхүүгийн хүчин зүйлүүд байна. Тиймээс эдгээр асуудлыг шийдэхийн тулд сайн компанитай хамтарч ажиллах хэрэгтэй” гэв.

Харин 2020 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нийт эрчим хүчний хэрэглээний 20 хувьд хүргэх зорилготой монголчуудын хувьд Англи улс хамгийн сайн хамтран зүтгэгчдийн нэг гэдгийг эндээс харж болно.

Тэд шилдэг нь

Их Британи улс цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнд хангамжийн менежментийг оновчтой болгож,

нэгтгэж чадах ухаалаг төвлөрсөн шугам сүлжээний талаар судалгаа, шинжилгээг хийж байна. Тухайлбал, эрчим хүчний компаниуд нь 2020 он гэхэд 26 сая хэрэглэгчийг шинээр бий болгох зорилт тавин ажиллаж байна. Уг зорилгын хүрээнд хийж байгаа нэг ажил нь ухаалаг цахилгааны тоолуур суулгаснаар хэрэглэгчдийн цахилгаан хэрэглээг оновчтой болгож, эрчим хүч ашиглалтын үр ашгийг хамгийн дээд хэмжээнд сайжруулах, зардал болон нүүрсхүчлийн хийг бууруулах талаарх судалгаа аж. Энэ технологи Монголд ч гэсэн нэвтрээд байгаа.

“Clear energy” компани одоогийн байдлаар Дарханы цахилгааны төвийн шугамд 200 ширхэг “ухаалаг” тоолуур суурилуулсан байна. Энэ нь цахилгаан эрчим хүчний бүх төрлийн мэдээлэл дамжуулах жижигхэн цахилгааны шугамтай болж байна гэсэн үг ажээ. Хэрэглэгч талд мэдээлэл илгээж, дараа нь буцааж авах байдлаар мэдээлэл цуглуулах арга гэнэ. “Clear energy” компанийн захирал Дэвид Лейн “Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжиж байгаа энэ үед салхин сэнс, алсын зайн эрчим хүч үйлдвэрлэл, нарны панел зэрэг өөр төрлийн эрчим хүчний эх үүсвэр сүлжээнд ороод ирэхээр цахилгааны сүлжээг өмнө байгаагүй байдлаар ажиллуулах шинэ сорилт тулгарна. Харин “ухаалаг” тоолуур нь эдгээр асуудлыг шийдвэрлэхэд туслах юм. Энэ нь цахилгаан шугам сүлжээний ажиллагааг бүхэлд нь шинээр бодож

сэтгэж байгаа хэрэг” хэмээн ярьсан.

Их Британид дулааны цахилгаан үйлдвэрлэлийн салбар “төрсөн газар” гэж хэлж болно. Английн дулааны үйлдвэрлэлийн салбар дэлхийн зах зээл дээр өрсөлдөгчгүй хэмээн хүлээн зөвшөөрөгддөг. Өдгөө хамгийн чанартай тоног төхөөрөмж, инженерийн шилдэг үйлчилгээг дулааны цахилгаан хангамжийн бүхэл бүтэн сүлжээгээр дамжуулан үзүүлж байна. Монголын Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогт “Монгол Улсын эрчим хүчний салбар дутагдалд орж, станцууд нь хуучирсан. Эрчим хүчний дутагдлаас гарахын тулд нэн түрүүнд цахилгаан станцуудад нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг, илүү үр ашигтай дэвшилтэт технологийг нэвтрүүлэх хэрэгтэй байна” гэсэн юм. Харин Англид төвтэй нийтийн аж ахуй болон хангамжийн сүлжээ байгууллагуудын консорциум нь шаталтын өмнө болон дараа нүүрсхүчлийн хийг гаргахгүй байх, хадгалах тэргүүлэх технологийг хөгжүүлж байна. 125 жилийн дулааны цахилгаан үүсгүүрийн түүхтэй Их Британи улс эрчим хүч үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг шинэчлэх, дахин инженерчлэх, үйлчилгээ үзүүлэх, засвар үйлчилгээ хийх зэрэгт мэргэшсэн хангамжийн сүлжээг өндөр түвшинд хөгжүүлсээр байгаа аж. Товчхондоо Англи улс агаарын бохирдлоо бууруулж манант Лондонг ногоон хот болгон хувиргаж чадсан бол өдгөө эрчим хүчний салбарт хөгжлийн хувьсгал хийж байна. ■

БИЗНЕС ТҮНШЛЭЛ

САЙН ТҮНШЛЭЛ ЯМАР Ч ӨӨРЧЛӨЛТИЙГ ДАВЖ ГАРДАГ

Х.СОЛОНГО

Жон Тимоти Гроган нь Их Британи Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын тэргүүн. Тэрбээр Английн Баруун Йоркшайрын Халифакс хотод төрсөн бөгөөд Оксфордын их сургуулийг орчин үеийн түүх, эдийн засгийн чиглэлээр дүүргэжээ. Мөн Английн Хөдөлмөрийн намын гишүүн тэрбээр 1997-2010 онд (Хойд Йоркшайрын Селби тосгоны сонгуулийн тойргоос сонгогдон) Их Британийн Парламентийн гишүүнээр ажиллаж байжээ.

Жон Тимоти Гроган өнгөрсөн зургаадугаар сард Улаанбаатар хотноо болсон Дэлхийн байгаль орчны өдөрлөгт ирсэн билээ.

-Их Британи Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын талаар товч танилцуулна уу?

-Британи Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим 2010 онд байгуулагдсан. Түүнээс өмнө миний бие Английн Парламентийн гишүүн, Их Британи, Монголын хоорондох найрсаг харилцааг бэхжүүлэх ажлын хэсгийг ахалж байсан. Тэтгэвэрт гарсныхаа дараа тухайн үед Монгол Улсаас Лондонд суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар ажиллаж байсан Алтангэрэлтэй уулзах завшаан тохиож билээ. Тэрбээр хоёр улсын хооронд худалдаа, аж үйлдвэрийн танхим байгуулахаар ажиллаж буйгаа дурдаад, туслалцаа үзүүлэх боломжтой эсэхийг асуусан юм. Миний хувьд энэхүү



Фотог Э.Зоригт

Их Британи, Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын тэргүүн Жон Тимоти Гроган

чухал ажилд гар бие оролцох нь сайхан санагдсан. Тэр үеэс Монголын талаар сонирхож эхэлсэн дээ.

-Үйл ажиллагааныхаа гол чиглэлээс сонирхуулахгүй юу?

-Манай байгууллагын хийж гүйцэтгэдэг ажлын хувьд **нэгдүгээрт**, Монголыг сонирхсон аливаа бизнесийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Лондонд төрөл бүрийн арга хэмжээ, семинар, Монгол-Лондонгийн бизнес форум зохион байгуулдаг. Өнгөрсөн онд Монгол Улсын Ерөнхийлөгч

Ц.Элбэгдорж Лондонгийн Олимпийн наадмын үеэр манай улсад айлчилсан. Үүнтэй холбоотойгоор бид Лондонгийн хөрөнгийн биржид Хөрөнгө оруулалтын өдөр гэсэн томоохон арга хэмжээ зохион байгуулсан. **Хоёрдугаарт**, Их Британийн компаниудын төлөөлөл, худалдааны төлөөлөгчдийг Монголд ирүүлэх. **Гуравдугаарт**, манай улсад Монголоос ирсэн зочин, гийчдэд шаардлагатай үед туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Монголын янз бүрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудад бид тусламж ▶

► үзүүлсээр ирсэн.

-Их Британи, Монголын компаниуд одоогийн байдлаар аль чиглэлд түлхүү ажиллаж байгаа вэ?

“Рио Тинто” бол Монголд хийсэн Англи-Австралийн хамгийн том хөрөнгө оруулалт яах аргагүй мөн. Мөн Лондонгийн хөрөнгийн бирж Монголын хөрөнгийн биржтэй сайн түншлэлийн харилцаатай болсон. Түүнчлэн Кэмбриж болон Глазгоу их сургууль Монгол Улсын боловсролын салбарт тэргүүлж байна. Аливаа орны хувьд Засгийн газрын түвшинд өөрчлөлт гарах үед, мөн төр, засгийн эрх мэдэлтнүүд солигдох үед ч хэвээр байхыг түншлэлийг сайн түншлэл гэж болох бөгөөд ийм төрлийн өөрчлөлт бүхий л ардчилсан нийгэмд тохиолддог зүйл. Сайн түншлэлийг бий болгохын тулд Лондонгийн хөрөнгийн бирж болон Кэмбрижийн их сургууль анхаарал тавьж буй нь сайшаалтай. Янз бүрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Их Британийн компаниуд ч Улаанбаатар хотод өөрсдийн байр сууриа олжээ. Тухайлбал, “Pricewaterhouse” компани “Pricewaterhouse Mongolia” салбар компани Улаанбаатарт байгуулсан. “Clyde and Co”, “Hogan Lovells” зэрэг Англи-Америкийн компанийг дурдаж болно.

Үүний зэрэгцээ бараа, бүтээгдэхүүн болон үйлчилгээ нийлүүлдэг хувь хүмүүс бий болсон байна. Их Британийн “Pandrol” төмөр замын компани Монголын зах зээлийг сонирхож байгаа бөгөөд төмөр замын засвар, дэр тавих үйлчилгээ үзүүлэх тал дээр мэргэшсэн компани. Их Британийн “Sgurr” болон “Mott MacDonald” компаниуд сүүлийн үед баригдсан салхин паркийн төсөлд зөвлөхөөр ажилласан байх жишээтэй. Бидний хийж гүйцэтгэдэг ажлуудын нэг бол аж үйлдвэрийн хувьсгалын өлгий нутаг болох Их Британи улс их зүйлийг хийж, бүтээсэн хэвээр гэдгийг харуулах зорилготой.

Олон хүн Германыг хийж бүтээдэг, Английг санхүүжүүлдэг гэдэг талаас нь харах хандлагатай байдаг. Гэхдээ энэ нь туйлын үнэн биш юм. Манай байгууллагын ажлын нэг хэсэг бол үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээ Монголын зах зээлд нийлүүлэх боломжоор Их Британийн ард иргэдийг хангахад оршино. Бизнес эрхлэгчдийн хувьд “Land Rover”

автомашинаас авахуулаад уул уурхайн тоног төхөөрөмж нийлүүлэгчид, виски үйлдвэрлэгчдэд хүртэлх зах зээлийн боломж асар их байгаа юм. Манай хоёр орны хооронд худалдааг хэр сайжруулж чадах вэ гэдгээр бидний амжилт хэмжигдэнэ.

-Их Британиас гадна Монголын компаниуд танай байгууллагын гишүүн болох боломжтой юу?

-Хоёр улсын аль ч компани гишүүн болох боломжтой. Томоохон компаниудын хувьд гишүүнчлэлийн жилийн хураамж 500 орчим фунт стерлинг бол хувь хүмүүс 100 гаруй фунт стерлинг төлнө. Одоогийн байдлаар манай гишүүн компанийн тоо 50 хүрээд байна.

Манай байгууллагын зорилго хоёр улсын хоорондох худалдаа, хөрөнгө оруулалтын хөгжлийг дэмжихэд оршдог. Зорилгоо биелүүлэхийн тулд Монголын бизнесийн зөвлөл, Худалдаа аж үйлдвэрийн танхим, холбогдох Элчин сайдын яамд, Засгийн газартай ойр дотно хамтран ажилладаг.

-Их Британийн компаниуд ямар давуу талтай вэ?

-Гадаад харилцааны алсын хараа болов уу. Учир нь Монгол, Их Британид байдаг нийтлэг зүйл бол эзэнт гүрний түүх. Манай улс Европын зарим өрсөлдөгч орныг бодвол худалдаа, хөрөнгө оруулалтад төрийн зүгээс үзүүлэх дэмжлэг төдийлэн их биш. Гэхдээ энэхүү дутагдалтай талыг Их Британийн бизнес хийх ур чадвар болон хувийн хэвшил нөхдөг гэж бодож байна.

-Хоёр орны бизнес эрхлэгчид юуг харилцан суралцах боломжтой вэ?

-Салбараасаа хамаараад суралцах зүйл харилцан адилгүй байдаг. Монголд эсвэл Англид бизнес хийх сонирхолтой аливаа компани тухайн орон нутагтаа итгэлт түнш олох нь маш чухал. Мэдээллийн эрин зууны хөгжил хүчтэй байгаагаас үл хамааран алсын зайнаас бизнес хийнэ гэдэг ихэд хүндрэлтэй юм.

-Улстөрчөөр олон жил ажилласан хүний хувьд Монголын бизнесийн орчны талаар юу хэлэх вэ?

-Ерөнхийдөө Монголын бизнесийн орчин маш сайн гэж хэлж болно. Мэдээж зарим асуудал гардаг боловч хөрш орнуудаа бодвол бизнес хийхэд

илүү тохиромжтой. Тухайлбал, Их Британийн компанийн төлөөлөгчид “Монголд жилийн дараа гэхэд ямар дүрэм, журам гарч ирэхийг бид тодорхойлж чадахгүй шүү дээ. Монголд ардчилал хөгжиж байгаа учраас холбогдох дүрэм, журам цаашид өөрчлөгдөх магадлалтай биш үү?” гэж асуудаг. Харин би хариуд нь “Казахстаныг хар л даа. Богино хугацаанд тодорхой байгаа боловч тэнд бизнес хийхийн тулд хэн удирдаж байгааг нь мэдэх шаардлагатай болно биз дээ” гэдэг. Эрт, орой хэзээ нэгэн цагт аливаа зүйл гарцаагүй өөрчлөгддөг болохоор тухайн өөрчлөлт ирэх үед юу болох бол?

Монголын хувьд Ерөнхийлөгч ч юм уу, Ерөнхий сайд ч юм уу бизнес хийдэг эсэхийг мэдэх шаардлагагүй. Зарим тохиолдолд тэд хүлээн авалтад явж байдаг. Тэдэнтэй зөвшөөрөл авалгүйгээр танилцах боломжтой байдаг.

Хууль, эрх зүйн тогтолцоо сайжирч байгаа боловч хараат бус байлгах тал дээр анхаарах нь зүйтэй. Гэхдээ монголчууд хэт бардаж, биеэ тоож болохгүй. Гаднын хөрөнгө оруулалтын тал дээр боловсруулж, сайжруулах асуудал нэлээд байна. Мөн Оюутолгойн талаар хэлэлцэж, ярилцах шатны асуудал бараг шувтарсан гэж бодож байгаа. Монголын баялаг авчрах зэс, алтны олборлолтыг цаг алдалгүй хийх нь тэднээс л шалтгаалж буй. Монгол Улсын хувьд хөгжлийн янз бүрийн загвараас сонголт хийх боломжтой. Гэхдээ сонголт хийхдээ ардчилсан зөв хэлбэрээр авч үзэх, тухайн сонгосон загвар гаднын түншүүдийн итгэл, найдварыг хадгалах эсэх нь маш чухал. Танай улсын эдийн засаг ирэх арван жилд дэлхийн хамгийн өндөр өсөлттэй орнуудын тоонд орж, эцэст нь хүчирхэгжинэ гэдэгт итгэл төгс байна. Өнгөрсөн онд болсон таагүй, тодорхойгүй байдлаас үл хамааран Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын компаниудын өнөөгийн байдал жигдэрсэн байна.

-Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны цөм нь юу вэ?

-Итгэлцэл, нэгдмэл байдал, хүндэтгэл, хариуцлагын тодорхой хуваарилалт, ашгийг хэрхэн хуваарилах талаарх сайн ойлголт гэж хэлэх байна. ■

МОНГОЛ ДАХЬ АНГЛИЧУУД

БИЗНЕС ГҮҮР

Б.ТУЯА

Английн алдарт “Beatles” хамтлагийн дуунууд Улаанбаатар хотноо эгшиглэсэн нь хагас зууны тэртээх түүх болон үлджээ. Монгол түмэнд барууны аж үйлдвэржсэн ертөнцийн сонин, содноос анх хуваалцсан хүмүүс Их Британийн дипломатчид байв. Агуу зүйлийн эхлэл үргэлж амаргүй байдаг. Үүний адилаар тус улсын төлөөлөгчдөд дипломат харилцааны дэвшилт санааг түгээн дэлгэрүүлэх амаргүй байсан биз ээ.

Транс-Атлантикийн орнууд моодонд байсан цаг улирч алсын гэгдэх орнууд олны анхаарлын төвд тодорч буйг олон улсын судлаачид онцлох болов. Тухайлбал, Хятад, Энэтхэг тэргүүтэй орнууд дэлхийн эдийн засагт “хөгжиж буй” хэмээх тодотголтой томоохон тоглогчид болж байна. Монгол Улсын хувьд уул уурхайн хөгжил нь огцом өсөлтийг даллаж гадаадын хөрөнгө оруулагчдын дунд том “од” болж гялалзав.

Энхийг сахиулагч

Их Британи, Монгол хоорондын харилцаа бэхжихийн хэрээр манай улсыг зорих Английн бизнесмэнүүдийн тоо нэмэгдэж буй. Хоёр өөр соёлын хүсэл, эрмэлзлэлийг уялдуулан нэг зүгт тэмүүлэх тийм ч хялбар ажил биш юм. Гадаадын аль ч оронд бизнес эрхлэх хүсэлтэй хөрөнгө оруулагчид хуулийн хүрээнд шийдвэрлэх асуудлууд мундахгүй гарч ирдэг.

Хөгжлийн эхэн шатанд хөлөө олох гэж буй Монгол Улсад олон улсын жишигт нийцсэн хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлдэг хэдэн байгууллага байдгийн нэг нь Англи, Америкийн

хамтарсан “Хоган Ловеллс” хуулийн фирм юм. Хууль зүйн салбарт зуун жилийн туршлагаа нэр хүндтэйгээр бататгаж яваа “Хоган Ловеллс” хууль, эрх зүйн үйлчилгээнээс гадна арбитрын маргаан шийдвэрлэх, компаниудын хөрөнгийн зах зээлд гарах болон хөрөнгө босгох асуудлуудад зөвлөгөө өгдөг билээ. Манай улсад хэдийнэ байр сууриа олсон тус байгууллагын зорилго нь Монголын хууль зүйн салбарт олон улсын стандартад нийцэх боловсон хүчнийг сургах, тэдний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх болоод туршлага солилцоход орших аж.

“Хоган Ловеллс” хуулийн фирмийн захирал Майкл Олдрич “Хоган Ловеллс нь Их Британийн хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлдэг. Энэ утгаараа хуульч, өмгөөлөгчид маань Европын хууль зүйн чиглэлээр мэргэшсэн байдаг. Ийм ч учраас манай байгууллагыг Английн хуулийн фирм гэдгээр нь олон нийт түлхүү мэддэг болов уу. Гэсэн ч бид ажиллаж, амьдарч буй орныхоо хууль тогтоомж, ёс заншил болоод соёлыг дээдлэн хүндэлдэг” гэсэн юм. Тэрбээр “Их Британийн хуулийн системийг Монголд нутагшуулж, үйлчлүүлэгчдийнхээ хооронд эв нэгдлийг бий болгохын сацуу тэднийг үл ойлголцлоос ангид байлгах нь бидний ажлын томоохон зорилгуудын нэг хэсэг. Өөрөөр хэлбэл, хуулийн хүрээнд бид энхийг сахиулах үүрэг хүлээсэн” хэмээн онцолсон.

Майкл Олдрич хамтран ажилладаг монгол өмгөөлөгчдөөрөө бахархан ярьж байсан нь Монголын хууль зүйн салбарт хувь нэмрээ оруулах хүсэлтэй залуус шургуй хөдөлмөрлөж, олон улсын тавцанд мэдлэг, чадвараараа хэнээс ч дутахгүй цээж тэнэгэр явах чин хүсэлтэй байгааг илтгэх.

Эрчим хүчний дэвшил

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж эх орноо сэргээгдэх эрчим хүчний диваажин хэмээсэн удаатай. Ийм ч учраас Монголын сэргээгдэхээс “хүртэх” хүсэлтэй гадаадын хөрөнгө оруулагчдын буухиа эхэлсэн. Тэдгээрийн нэг нь “Clear Energy” компани. Тус компани “ухаалаг тоолуур” хэмээх цахилгаан хэмжигч төхөөрөмжийг Дархан хотноо суурилуулах төсөл дээр ажиллаж байна. Уг төхөөрөмж нь эрчим хүчний хэрэглээ болон тооцооны нарийн дүнг гаргадаг онцлогтой аж. “Clear Energy” компанийн захирал Давид Лайн “Салхин сэнс, алсын зайны цахилгаан үүсгэвэр, нарны панел зэрэг хэрэглээнд нэвтэрснээр цахилгаан сүлжээний аргачлалд багагүй өөрчлөлт гарсан. Эдгээрээс үүдэн эрчим хүчний хэрэглээний бодит тооцооллыг гаргахад бэрхшээлүүд тулгарч эхэлсэн. Харин ухаалаг тоолуурыг нэвтрүүлсэн нь дээрхийг шийдвэрлэж, улмаар цахилгаан сүлжээг технологийн шинэ түвшинд хүргэсэн” гэлээ. Мөн тэрбээр “Цэвэр технологи хөрөнгө оруулалттайгаа уялдуулж чадвал дэвшилт технологийн шимийг хүртэх нь цаг хугацааны асуудал болно” хэмээн онцолсон юм.

Байгальд ээлтэй технологийг нутагшуулах, эрчим хүчний хомсдлыг туулж биш тойрч гарах хүсэл дэлхий



► нийтийнх. Их Британийн Засгийн газраас дотооддоо 30 сая ухаалаг тоолуур суурилуулах төслийг хэрэгжүүлж эхэлсэн нь 2020 онд дуусах ажээ. Энэ мэтээр өссөөр буй эрчим хүчний хэрэгцээгээ хангах ажилд чамгүй хөрөнгө төсөвлөж байна.

Монгол Улс эрчим хүчний хэрэгцээгээ дааж чадахгүйд хүрээд буй. Давид Лайн “Их Британид цахилгаан сүлжээг шинэчлэх, эрчим хүч хэмнэх ажилд ихээхэн хөрөнгө зарцуулах болсон. Ийм сонголтын өмнө Монгол хэдийнэ ирээд буйг онцолмоор байна. Гэтэл үеэ илээсэн тоног төхөөрөмж хэрэглэсээр байна” хэмээсэн юм.

Эрчим хүчний дэд бүтэц урт хугацааны хөрөнгө оруулалт шаарддаг. Харин хөрөнгө оруулагчдын итгэлийг шат шатаар ахиулах хэрэгтэй учир мастер төлөвлөгөө боловсруулах нь зүйтэй. “Clear Energy” компанийн захирал Давид Лайны хэлж буйгаар тухайн орны Засгийн газар нөхцөл байдлыг бодитоор дүгнэж, сэргээгдэх технологийн боломжит хувилбаруудад нээлттэй хандах нь чухал аж. Түүнчлэн иргэдэд цэвэр технологийн ач холбогдол, үр нөлөөг сайтар ойлгуулах хэрэгтэй юм.

Инженерийн ид шидийг Монголд

Их Британид төвтэй “Tony Gee and Partners” компани нь 1974 онд байгуулагдсан бөгөөд Азид 30 жил үйл ажиллагаагаа явуулж буй туршлагатай. Тус байгууллага дэлхийд ганц гэгдэх сүрлэг цогцолборыг Монгол Улсад барихаар барилгын инженерийн ажлыг гүйцэтгээд байна.

Нийт 2400 ам метр талбайг хамрах Их Майдар төсөл нь Буддын шашны уламжлалыг орчин цагийн урлаг, шийдэлтэй хослуулах өвөрмөц бүтээл болох юм. Төслийн хүрээнд 108 метр өндөр суварга босгох бөгөөд түүний урд Майдар бурханы 54 метр өндөр хүрэл хөшөөг сүндэрлүүлэх ажээ. Их Майдар сангийн захиалгаар бүтэж буй эл цогцолбор нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт буюу Улаанбаатар хотоос 50 км зайд байрлана. Майдар бурханыг урлаж буй дизайнер, инженерүүдийн хэлснээр хүрэл хөшөө нь АНУ-ын Эрх чөлөөний хөшөөнөөс найман

метрээр өндөр байх агаад манай улсын барилгын инженерийн салбарт урьд хожид байгаагүй хосгүй бүтээл болох гэнэ.

“Tony Gee and Partners” компанийн захирал Стив Харридж “Их Майдар бурханыг бүтээх эл төсөл бидний хувьд шинэ туршлага байлаа. Хүч, хөдөлмөрөө харамгүй шингээсэн эл төсөл олон түмний сэтгэлийн баясгах цогцолбор болж чадна гэдэгт итгэж байна” хэмээн манай улсад айлчлах үеэрээ онцлон тэмдэглэсэн билээ.

Сэтгэхүйн алслал

Дэлхийд нэртэй дээрх гурван байгууллага Монгол Улсад үйл

ажиллагаа эрхэлж буй Их Британийн компаниудын төлөөлөл. Хэдий ийм ч манай улсыг зорих Английн бизнес эрхлэгчдийн тоо АНУ, Япон, Хятадын хөрөнгө оруулагчидтай харьцуулахад чамлахуйц байсаар. Үүний шалтгааныг сэтгэхүйн алслал хэмээн олон улсын судлаачид тайлбарладаг. Алслагдсан, танил бус санагдах Монгол гэх нэрийг тэдний оюун ухаанд ойртуулах цаг ирсэн төдийгүй Засгийн газруудын зүгээс дэмжлэг хэрэгтэй байгааг Английн бизнесмэнүүд хэлж байна. Ингэж чадваас Монголын чөлөөт зах зээл, нээлттэй нийгэм Их Британийн бизнесийн гол цэгүүдийн нэг болох нь цаг хугацааны асуудал аж. ■

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ХОСГҮЙ БҮТЭЭЛ ИХ МАЙДАР

Б.ҮҮРИЙНТУЯА

Монгол Улсад бүтээн байгуулалт өрнөж байна. Тэнгэр баганадах өндөр барилгуудаас гадна дэлхийд ганц хэмээх хүндэт цол хүртэх бүтээн байгуулалтын ажлууд ч ундарч байгааг харах бахархуштай. Үүний нэг тод жишээ бол Их Майдар төсөл юм. Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт сүндэрлэх эл төслийн хүрээнд Майдарыг бүтээх ажлын гүйцэтгэгч компани болох “Tony Gee and Partners”-ын захирал Стив Харриджтэй ярилцлаа. Тэрбээр өнгөрсөн долдугаар сард манай улсад айлчилсан билээ. ►►





Их Майдар төслийн зураглал

► **-Их Майдар төслийг анх хэзээ санаачилсан бэ?**

-Уг бүтээлийг урлах санаачилга гараад багагүй хугацааг үджээ. Бурханы зураг, загварыг Хятадын компани гүйцэтгэх төлөвлөгөөтэй байсан ч тодорхой шалтгааны улмаас хамтын ажиллагааг зогсоосон тухай сонсож байсан. Улмаар есөн сарын өмнөөс энэ үүрэг даалгаврыг хүлээн авч загварыг шинэчлэн гаргах ажилд ханцуй шамлан орсон. Өдгөө эцсийн загвар гарснаар зогсохгүй баримлыг урлах явц мөн шуударч байна. Түүнчлэн механик загварчлалын ажил дуусах шатанд орсон.

Майдар бурхны загварыг бүтээх явцад өөрчлөлтүүд орж байлаа. Гэсэн ч захиалагчийн хүсэлд нийцэх загварыг гаргаж чадсан. Захиалагч тал хамтран ажиллах эерэг уур амьсгал бүрдүүлж байсанд талархаж байна. Тэд бүтээн байгуулалтын газарт ажиллаад эхэлсэн. Барилгын улирал дуусахаас урьтаад баримлын суурийг цутгах ажлыг дуусгах төлөвлөгөөтэй байгаа. Үндсэн баримлыг ирэх жилээс босгож эхэлнэ. Их Майдар сан төслийг хэрэгжүүлэх газрыг сонгож манай компани инженерийн ажлыг гүйцэтгэсэн. Энэ бол асар том бүтээн байгуулалт. Улаанбаатар хотоос 50 км зайд барихаар тогтсон

нь иргэдэд ойр байх үүднээс болов уу. Түүнчлэн Далай лам тус газрыг адисласан тухай сонссон.

-Монгол Улс эрс тэс уур амьсгалтай. Өвлийн тэсгэм хүйтэн та бүхний ажилд багагүй хүндрэл учруулсан тухай сонсож байлаа. Үүнээс гадна болзошгүй хүндрэлүүд бий юу?

-Бодит байдал бидний төсөөлж байснаас сайн байгаа. "Tony Gee and Partners" компани дэлхийн өнцөг булан бүрт үйл ажиллагаа эрхэлдэг томоохон байгууллага. Бидний бүтээн байгуулалт Монголоос гадна Хонконг, Малайз, Сингапур, Австрали зэрэг Ази, Номхон далайн орныг хамарч байна.

Зарим оронд барилгын ажлыг тогтсон зарчмын дагуу явуулах хүсэлтэй байдаг. Монголд ч энэ зарчмын дагуу байх болов уу гэсэн хүлээлттэй байлаа. Харин монгол захиалагчтай ажиллах нь биднийг ихэд гайхшруулсан шүү. Учир нь тэд мэдлэг өндөртэйгөөс гадна бусдын санал, бодлыг сонсож чаддаг нь таатай санагдсан. Бид үндсэн дизайныг гаргаж, Хятадын компани гүйцэтгэгчээр ажиллахаар байгаа. Хэдий тийм ч бүтээн байгуулалтын бүх ажил Европ стандартын дагуу явна. Аливаа төслийг хүлээж авахдаа

бид тухайн орны ёс заншил, ашиглах түүхий эд зэрэгт нийцүүлэхийг эрмэлздэг. Монголд хийж буй эл төслийг Европ стандартын жишгээр загварчилсан. Энэ нь Монголд ч ашигтай байх болно.

Бүтээн байгуулалтад тулгарах хамгийн том бэрхшээл бол Монголын хүйтэн өвөл. Иймд загварыг түргэн барих тал дээр анхаарах нь чухал. Бүтээмжийг нэмэгдүүлж, өвлийн улиралд дотоод ажлыг үргэлжлүүлэх боломжтойгоор төслийн зургийг гаргах нь үр дүнтэй. Монголд бүтээн байгуулалтын салбар төдийлэн сайн хөгжөөгүй байна. Асар их дэмжлэг, тусламж хэрэгтэй байна. Сингапур, Хонконгтой харьцуулах аргагүй ч ямар ч нөхцөлд эдийн засгийн үр ашигтай шийдэл гаргаж чаддаг нь монголчуудын давуу тал.

-Их Майдарын бүтээн байгуулатыг 2014 онд ашиглалтад орно гэсэн хүлээлт бий. Албан ёсны нээлтийг хэзээ хийх вэ?

-2014 онд нээлтээ хийнэ гэж бат итгэлтэй хэлэх боломжгүй. Гүйцэтгэгч компани цаг алдахгүй ажиллах нь нээлтийн хугацааг урагшлуулж болох юм.

Их Майдар бурхны үндсэн загварыг монгол хүн урласан. Түүний авьяасыг бишрээд баршгүй. ►

► Бид барилгын инженерийн ажлыг гүйцэтгэдэг учир дэд бүтэц талаас нь түлхүү оролцсон. Архитектурын ажилд оролцоод байдаггүй.

-Уг төсөлд хэр хөрөнгө оруулалт хийсэн бэ?

Их Майдар төсөлтэй адилтгах төслийг урьд өмнө дэлхийн хаана ч бүтээж байгаагүй. Энэ утгаараа нийт хөрөнгө оруулалтын хэмжээг дүгнэн хэлэхэд бэрх. Захиалагчийн сэтгэлд нийцсэн бүтээлийг хямд өртгөөр

чанарын өндөр түвшинд хийх нь бидний үүрэг. Бүтээн байгуулалтыг богино хугацаанд хийхээр тооцоолох нь урсгал зардлыг танадаг. Төслийн захиалагч өдийг хүртэл бидний хийсэн ажилд сэтгэл хангалуун байгааг харах таатай байна.

-Бусад оронд хийж байсан ажлуудтайгаа харьцуулахад уг төсөлд хялбар зүйл хэр их байсан бол?

-Бүтээн байгуулалтыг асар хүйтэн

нөхцөлд нийцүүлэн барих нь төслийн том шалгуур байсан. Үүний дагуу толгойгоо илүү ажиллуулах хэрэгтэй болсон. Тухайлбал, уг төслийг Шри Ланкад хэрэгжүүлсэн бол шалыг модоор хийхэд л хангалттай. Гэтэл Монголд маш хүйтэн тул шалнаасаа халдаг системийг ашиглах хэрэгтэй болж байгаа юм. Бидний энэ их зүтгэл Их Майдар бурхны цогцолборыг зорих иргэдэд таалагдана гэж найдаж байна. ■

ЛОНДОНГИЙН МОНГОЛЧУУД

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

Э.ЗОРИГТ

Бүрхэг тэнгэр, бороон дуслар төсөөлдөг Их Британи Улсын агаарын хэм +30 ба түүнээс дээш. Тэнгэрт үүл үгүй. Наран хурцаар ээж, өвсний толгой хэдийнэ шаралжээ. Монголын нар, намар хоёр “Mongolian Economy” сэтгүүлийн сурвалжлах багийг дагаад ирээ юу гэлтэй.

Манай сэтгүүлийн тусгай баг сурвалжлага хийхээр буурал Европыг зорьсон юм. Зорилгын маань нэгээхэн хэсэг нь Англид амьдарч байгаа элэг холдсон монгол ахан дүүстэйгээ танилцах, тэдний ахуй амьдралын талаар сурвалжлах байлаа.

“Хөдөөний хүн”

Даруухан, цэмцгэр өөрийн гэсэн донжтой өвгөн Европ, өтөл настай Английн нийслэл Лондонгийн гудамжаар газар газрын хүмүүс хөлхөлдөнө. Тэр олон хүмүүсийн урсгал дунд бид Англи дахь монголчуудын сурвалжлагын гол баатруудын нэг болох Ж.Өнөрмаа, Д.Цэрэнбат нартай уулзахаар явсан юм. “Baker street” буюу талхчдын гэх тодотголтой гудамжинд очиход 40 гаруй насны өндөр нуруутай туранхай эрэгтэй хүн “Амар мэнд үү. Би хөдөөний хүн. Ноосоо тушаахаар төвд ирлээ. Та бүхэнтэй уулзсандаа баяртай байна” хэмээн мэнд мэдэлцэв. Хэдийгээр эх нутгаасаа гараад 20 орчим жил болсон ч уламжлалын дагуу мэнд мэдсэн нь чихэнд содон дуулдана. Түүнийг Д.Цэрэнбат гэх бөгөөд Английн хөдөө буюу Surrey мужийн Send гэх тосгонд эхнэр хоёр хүүхдийн ►



Фотог Э.Зоригт

► хамт амьдардаг. Түүний хажууд зогсож буй 40 эргэм насны өндөр бор хүүхэн бол Ж.Өнөрмаа. Энэ эмэгтэй “Lingua Global” орчуулга, бизнесийн зөвлөгөө өгдөг компанийн захирлаар ажилладаг нэгэн. Тус компани нь дэлхий даяар үл хөдлөх хөрөнгө, аялал жуулчлал, бизнесийн гээд 200 орчим хэлээр орчуулга хийж, зөвлөгөө өгдөг ажээ. Нийтдээ 1500 гаруй ажилтантай бөгөөд түүнээс 20 гаруй нь монгол хүн байдаг гэсэн.



Д.Цэрэнбат

Гаднын оронд амьдарч байгаа монголчуудаа элгэн садан, анд нөхөд, цаашлаад Засгийн газар нь “Хүний нутагт зовж байхаар эх орондоо хүрээд ир” хэмээн дуудсаар байгаа. Харин Англи дахь монголчуудын заримынх нь хувьд гэр бүл, эрхэлсэн ажил, амьдрах таатай орчин тэнд байна. Д.Цэрэнбат “Англи улсад миний амьдрал байна шүү дээ. Монголд очоод амьдрах баталгаа байна уу. Монголын хөгжил хар капитализмаар хөгжөөд байх шиг. Хэн мөнгөтэй нь л дуртай зүйлээ хийдэг. Адаглаад хууль эрх зүйн тогтолцоо муу. Хувийн бизнес хийх гэхээр бөөн бичиг цаас, хүнд суртал болно. Төрийн албанд нь ороод ажиллах гэхээр засаг солигдохоор л албан тушаалтнаа халчихна. Бидэнд дөрвөн жилийн настай ажил биш нэгэн насны баталгаат амьдрал хэрэгтэй биз дээ” хэмээн ярих. Магадгүй зарим нэг нь тэднийг эх орноо хөгжүүлэхээс зайлсхийж, муу хэлэхээ урьтал болголоо хэмээн шүүмжилж магадгүй.

Гэхдээ энэ шүүмжлэл учир дутагдалтай. Тухайлбал, Д.Цэрэнбат Их Британи дахь Монголчуудын холбооны тэргүүн бөгөөд жил бүр “Монгол Улсын хөгжилд” сэдэвт хурлыг Лондон хотноо зохион байгуулдаг. Тус зөвлөлгөөнөөр Англи улсын хөгжлөөс монголчууд хэрхэн суралцаж болох талаар зөвлөлддөг ажээ. Тухайлбал, “Мэдлэг ба хувийн санаа”, “Эрүүл

мэнд - үндэсний аюулгүй байдал”, “Хөгжлийн хэмжүүр”, “Амьдралын чанар”, “Инноваци”, “Өндөр технологи” гээд Монгол орны хөгжлийн чиг хандлага, ахиц дэвшил гээд олон асуудлаар илтгэл тавьж, мэтгэлцээн өрнүүлдэг байна. Чуулганаас гарсан санал санаачилгыг монголчууддаа уламжилдаг ажээ.

Мөн интернэт хэрэглээ үүсч байх 1990 оны сүүлээр Tsahimurtuu.mn вэб сайтыг үүсгэн байгуулж Англи, Монгол хоёр орны иргэдийн анхны онлайн харилцааг бий болгосон ачтан. Олон улсад тархсан уг цахим сүлжээ нь монголчуудын мэдээлэл солилцох гол талбар болсон бөгөөд ууган сүлжээний нэг юм. Д.Цэрэнбат “Монголчууд гадаад дотоод руу тийм ч их явдаггүй байх үед би Англид ирсэн. Намайг ирснээс хойш олон зүйл энд шинэчлэгдлээ. Интернэт бий боллоо. Хүн ардынх нь үзэл бодол, улс төрийнх нь барих бодлого гээд бүгд л бага багаар өөрчлөгдөж байна. Товчхондоо өөрийн гэсэн хөгжлийн замыг туулаад л явж байгаа орон. Харин би монгол хүнийхээ хувьд тухайн улсын хөгжлийн явцад ямар алдаа оноо гарч байгааг нь монголчууддаа байнга мэдээлэхийг зорьдог. Улмаар монголчууд маань тэдний алдаанаас суралцаж илүү хурдан, илүү амжилттай хөгжөөсэй гэж хүсдэг” гэв.

Тэрбээр Англи, Монгол хоёр улсын хэмжээнд бизнесийн болон эдийн засгийн цаг үеийн мэдээлэл солилцох ажил хийдэг. Түүнчлэн Англи дахь монголчуудынхаа хооронд Цагаан сар, Наадам гэх тэмдэглэлт баяруудыг зохион байгуулж, арын албанд зүтгэнэ. Лондонгийн монголчууд Д.Цэрэнбатад ам сайтай байх агаад “Хүний нутагт аавын оронд аав, ээжийн оронд ээж болсон түшигтэй сайхан ах, найз. Жаргал, зовлонгийн алинд ч тэр л хүн бидний дэргэд торойгоод байж байдаг” хэмээн ярих.

Англи шалгуур өндөр

Харин Ж.Өнөрмаа хэлний мэргэжилтэй нэгэн бөгөөд анх 1998 онд магистрийн зэрэг хамгаалахаар Англи улсыг зорьсон байна. Лондонд очсон цагаасаа л орчуулгын томоохон товчоонд ажиллаж эхэлжээ. Мөн



Ж.Өнөрмаа

монголчууддаа хуулийн болон бизнесийн зөвлөгөө өгөх тал дээр ч ажиллаж байсан гэсэн. Өдгөө Англиас Монголд хөрөнгө оруулалт татах тал дээр ажиллаж байна. Тэрбээр сүүлд нэг сая ам.долларын хөрөнгө оруулалттай утаагүй түлшний төслийг Монголд хэрэгжүүлэх ажилд гар бие зүтгэсэн байна. Ж.Өнөрмаа “Монгол хүнийхээ хувьд баталгаатай, их мөнгөтэй хөрөнгө оруулагчдыг эх орондоо татахыг хүсдэг. Гэхдээ англичууд аль нэг улс оронд хөрөнгө оруулахын тулд 2-3 жил судалгаа хийдэг. Английн бизнесийн шалгуур өндөр. Тиймээс энэ урт хугацаанд судалгаа нь дуусч Монголд гаднын хөрөнгө оруулалт татах асуудал шувтарч байтал сонгууль болж улс төрийн тогтворгүй байдал монголчуудын нэр хүндийг хугалдаг” хэмээн ярьсан.

Ажлын болоод хувийн хэргээр жилдээ нэг бус удаа Монголдоо ирчихдэг тэрбээр хоёр орны эдийн засгийн болоод бусад салбарын өмнө тулгамдаж байгаа асуудлын талаар сайн мэднэ. “Монголын эдийн засаг нэг үеэ бодвол сэргэж дэлхий нийтийн анхаарлын төвд ороод байна. Нэг хэсэг монголчууд хувийн асуудлаар орчуулга, зөвлөгөө авахыг хүсдэг байсан бол өнөөдөр бизнесийн зөвлөгөө, орчуулга хийлгэх санал голдуу ирж байна. Олон улсын хэмжээнд ч гэрээ хэлэлцээр их хийдэг болж. Гэхдээ асуудал бий. Тухайлбал, Монголын аль нэг албан байгууллагатай гэрээ хийх гэхээр дээд тал нь 30 орчим хороо, дарга цэргийн өрөөгөөр дамждаг. Гэтэл Английн аль ч компанид Монгол шиг тийм олон шат дамжлага байхгүй” гэв. Гэхдээ Шинэчлэлийн тодотголтой Засгийн газар гарын үсгийн тоог цөөлөх, гаднын оронд өөрийн орны нүүр царайг зөвөөр таниулахын тулд хийж байгаа зарим ажилд нь сэтгэл хангалуун байгаагаа нуугаагүй юм. Эх орноо гэсэн ийм хүмүүсийг харь нутагт ►

амьдарч байна хэмээн буруутгах нь утгагүй мэт. Магадгүй Монголд байгаа хэн нэгнээс илүү баялгийг гадаадад байгаа монголчууд бүтээж байна гэхэд хилсдэхгүй.

Банкир эмэгтэй



Л.Дулмаазул

Монголчуудынхаа төлөө харь оронд зүтгэж яваа жишээ олон. Есөн наснаасаа эх орноосоо гарсан Л.Дулмаазул бүсгүй “SMBC” банкны Лондон дахь салбарт банкираар ажилладаг бөгөөд Европ, Ойрхи Дорнод, Африкийн орнуудын уул уурхайн болон бусад салбарын томоохон төслүүдэд урт хугацааны санхүүжилт олгох ажлыг хариуцдаг нэгэн. Л.Дулмаазул “Санхүүжилт гэхээр 10-12 жилийн хугацаатай зээл гэж ойлгож болно. Монголтой адилхан хөгжиж байгаа орны томоохон төсөлд банкууд итгэж зээл өгдөггүй. Харин миний хийдэг ажил эдгээр зээл өгөхөд хэцүү орнуудад Дэлхийн банк, MIGA зэрэг томоохон агентлагийн болон хувийн даатгалын компаниудын баталгааг гаргуулж, аль болох эрсдэлийг багасган зээл авах, харилцан ашигтай санхүүгийн гэрээ хийх юм” хэмээн ажлаа тайлбарласан.

Тэрбээр “Siberian Coal Energy” компани болон Citibank-тай хамтаран 800 сая ам.долларын зээл, ADNOC компанид гурван тэрбум ам.долларын зээл гаргуулан, газрын тос боловсруулах үйлдвэрт хөрөнгө оруулалтын баталгаа гаргуулж, Шереметьевогийн онгоцны буудлын шинэ терминалийн санхүүжилтийг нь шийдэж өгсөн туршлагатай ажилтан ажээ.

Харин сүүлийн хоёр жил банкны салбараа Монголд нээж, эх орныхоо томоохон төслүүд дээр ажиллахад ихэд анхаарал тавьж буй гэсэн.

“Эх орондоо хөрөнгө оруулалт хийх тал дээр ажиллаж байгаа. Монголын томоохон төслүүд урагшаа хөдлөхгүй

байна. Тиймээс хүлээлтийн байдалд байна” гэж Л.Дулмаазул ярьсан. Энэ их ажлын хажуугаар тэрбээр Лондон хот дахь эмэгтэйчүүдийн байгуулсан “Англи-Монголын худалдааны зөвлөл” төрийн бус байгууллагын тэргүүний ажлыг хашдаг бөгөөд өнгөрсөн зургадугаар сард “Mining Mongolia Masterclass” форумыг зохион байгуулжээ. Уг форумын гол зорилго нь Монголыг сонирхсон Английн болоод бусад гаднын томоохон хөрөнгө оруулагчдад эх орноо сурталчлах, харилцан туршлага солилцсон байна. Тухайлбал, EBRD болон SMBC гэсэн томоохон банкуудын төлөөлөл форумын үеэр уул уурхай болон дэд бүтцийг хэрхэн зөв хөгжүүлэх талаар сонирхолтой илтгэл тавьсан байх жишээтэй.

Л.Дулмаазул нь жижигхэн биенээс гарамгүй их хүч сэтгэлийг гарган эх орноо хөгжүүлэх үйлсэд ийн зүтгэж явна.

Монгол брэнд



Д.Сэмжидмаа

10 гаруй жилийн өмнөөс Англид өөрийн гэсэн ноолууран бүтээгдэхүүний брэндийг бий болгосон “Semon cashmere” компанийн үүсгэн байгуулагч, загвар зохион бүтээгч Д.Сэмжидмаа “Би Лондонд аз жаргалтай байна. Учир нь миний гэр бүл эрүүл аюулгүй орчинд амьдарч, эрхэлж байгаа ажил минь амжилттай байна шүү дээ. Бид үр хүүхдээ эх орондоо сайхан амьдраасай гэж хүсдэг. Монголын маань нэр хүнд өндөрт байгаасай гэж залбирдаг. Өөрийнхөө хийж байгаа бүтээгдэхүүнээр ч болов эх орноо сурталчлахыг хүсдэг” хэмээн ярих. Түүний урласан бүтээгдэхүүнийг Лондон хотын мөнгөтэй бүсгүйчүүд захиалан өмсдөг бөгөөд жилдээ хоёр ч удаа өөрийн үзэсгэлэнгээ гаргачихдаг

гэсэн. Ирээдүйд Франц, Америк, Оросын зах зээлд бүтээгдэхүүнээ гаргах мөрөөдөлтэй тэрбээр Монголын Дорнодын тал нутгаас ноолуураа авдаг бөгөөд Улаанбаатарт байдаг жижигхэн оёдлын үйлдвэртээ хувцсаа уралдаг ажээ. Энэ жилийн Монголын эдийн засгийн чуулганы гол сэдэв болсон Үндэсний брэндийг хэрхэн бий болгох вэ гэх асуултын хариултыг олчихсон гэмээр энэ бүсгүй “Монголчууд гаднын зах зээлд гарна. Брэнд бий болгоно гэж их л ярих юм. Гэтэл зах зээлээ мэдэхгүй өөрийн биеэр тухайн улсдаа ажиллаж амьдрахгүйгээр гаднын зах зээлд гарна гэж байхгүй. Би бизнесээ эхлүүлэхдээ төрөөс нэг ч төгрөгийн зээл тусламж, зөвлөгөө аваагүй. Харин санхүүгийн чиглэлээр Лондонд сурч байхдаа зах зээлийн болон бусад төрлийн судалгааг сайн хийсэн. Түүнийхээ хүчинд өдий зэрэгтэй яваа. Манай бүтээгдэхүүн тухайн зах зээлд үнэлэгдсэн учир би бараа бүтээгдэхүүнийхээ шошгонд монгол ноолуур гэх тодотголыг заавал оруулдаг. Ер нь бизнес ашигтай байх тэр дундаа гаднын оронд ашигтай ажиллах гол зарчим бол тухайн бизнесийн орчноо биеэрээ мэдэрч үзэх. Мянга сонсохоор нэг үз гэдэг дээ” гэсэн юм.

Монголын цэцэн үгэнд “Жаргалтай газар хүн тогтохгүй, жавартай газар мал тогтохгүй” гэдэг. Гэтэл үнэндээ монгол хүн бүр амьдрах таатай орчин, аз жаргалтай амьдралын төлөө гаднын орныг зорьж байгаа. Адаглаад орон сууц, унах унаатай болох гэсэн мөрөөдөлтэй олон монгол тив алгасан “тэнэсэн” нь цөөнгүй. Гэхдээ тэд эх орноо голоогүй. Харин ч бусдаас илүү эх орныхоо төлөө зүрх нь цохилдог гэдгийг дээрх жишээнүүд батална. Хэдийгээр монголчууд хүний нутагт баялаг бүтээж байгаа нь үнэн боловч сүүлийн үеийн макро түвшний мэдээллээс харахад гадаадаас Монгол руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 2004 онд 22.4 сая ам.доллар байсан бол 2011 онд 247.9 сая ам.долларт хүрсэн байна. Нийт шилжүүлгийн 80.1 хувийг гадаадад ажиллаж байгаа монголчууд хийжээ.

...Харийн нутаг давчдаад байна

Харсан зүгтээ гүймээр л байна хэмээн нүдэндээ нулимстай дуулах Лондон дахь монголчуудын төлөөллөөс товчхон өгүүлэхэд ийм байна. ■

ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ

ИРЭЭДҮЙН ЗАХИАЛГА

Ч.ЛУТАА

Их Британийн Элчин сайдын яам Монголын ирээдүй болсон хүүхдүүдэд оюуны болоод хүмүүжлийн хөрөнгө оруулалт хийхийг эрмэлзэж байна. Тухайлбал, Их Британийн Элчин сайдын яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Хүүхдийг ивээх сан” олон улсын байгууллага хамтран хүүхдүүдийн засаглалд оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Сайн засаглалд хүүхдийн оролцоо амин чухал 2012-2013” төслийн эхний үе шатыг амжилттай хэрэгжүүлжээ.

Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин

сайд Кристофер Чарльз Стюарт “Хүүхдийг сайн засаглалын үйл явцад эхнээс нь оролцуулна гэдэг тун ач холбогдолтой. Хүүхэд ч гэсэн шийдвэр гаргах, шинэ санаа бүтээх үйл явцад оролцохыг хүсдэг. Энэ нь миний бодлоор маш үр өгөөжтэй эргэх холбоог бий болгодог. Хүүхдүүдэд нийгэмд хувь нэмэр оруулах хүсэл сонирхол, оролцоог бий болгож байна. Энэ нь хүний эрх, ардчиллын үндэс суурийг дэмжин бататгаж байгаа хэрэг” гэсэн юм.

Таван хүүхэд тутмын нэг нь л гэр бүлийн түвшинд өөрийн санал бодлоо илэрхийлж чаддаг гэх судалгааг “Сайн засаглалд хүүхдийн оролцоо амин чухал 2012-2013” төслийн хүрээнд гаргажээ. Судалгаанаас нэг сонирхолтой зүйл

ажиглагдсан нь хараа хяналтгүй хүүхэд гэр бүлийн түвшинд илүү оролцоотой байдаг гэжээ. Гэхдээ тэдний ихэнх нь бие даан орлого олж, ар гэрийнхэндээ зарцуулдаг бөгөөд асран хамгаалагчийн үүргийг давхар биелүүлдэг аж. Тиймээс үүнийг гэр бүлийн түвшинд хүүхдийн оролцоо сайн байна гэхээс илүү бие даан амь зуухаас аргагүй нөхцөл байдлын тулгалт гэж хэлж болох юм. Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны иргэн Т.Сайнбилэг хүү “Ээж, аав нь хүүхдээ тоохгүй болохоор тэд компьютер тоглоомонд донтож, архи, тамхи хэрэглэдэг” хэмээн өнөөгийн нийгмийн хар барааныг илэн далангүй хэлэв.

Төслийн хүрээнд нийслэлийн 400 мянган хүүхдэд шууд болон шууд бусаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх, томчуудад өөрсдийгөө ойлгуулах тал дээр ахиц гаргасан байна. Хүүхдийн оролцооны бүлгийн чиглүүлэгч багш Т.Амарзаяа “Хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүд томчуудтай ярилцах хэрэгтэй юм байна гэдэг ойлголттой болсон. Харин эцэг, эхчүүд маань хэдийгээр тухайн хүүхэд хаалттай байсан ч өөрсдөө хүүхэдтэйгээ нээлттэй харилцаж, ямар нэг шийдвэр гаргахдаа хамт ярилцдаг байх тал дээр анхаарч эхэлсэн” гэв.

Хүүхэд шуугисан эх өргөөнд ч хүүхдийн эрх зөрчигдөж, тэдний дуу хоолойг бараг сонсдоггүй аж. “Хүүхдийг ивээх сан”-гийн Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглалын ажилтан, төслийн зохицуулагч З.Уянга “Судалгаанд хамрагдсан нийт сургуулийн төлөвлөгөөнд тусгагдсан ▶



“Сайн засаглалд хүүхдийн оролцоо амин чухал” төсөлд хамрагдсан хүүхдүүд

▶ ажлыг харахад 45.3 хувь нь хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлдөг. Гэтэл ихэнх шийдвэр гаргалтад нөлөөлөх сурагчдын оролцоо муу. Хүүхдүүд зөвхөн сонсогчийн үүднээс оролцдог нь ажиглагдсан. Тэр дундаа 8-11 насны сурагчдын оролцоо муу байсан” гэв. Сургууль гэх ойлголт түүхэн хөгжлийнхээ явцад хүүхдийг чиглэл зорилготой сургах хүмүүжүүлэх үйлчилгээний байгууллага болж хувирсан. Өнөө үед сургуулийн үүрэг, зорилго, агуулга, бүтэц, зохион байгуулалт зэрэг нь ардчилал, хүний эрх, тэр дотроо хүүхдийн эрх, зах зээл гэсэн үзэгдлүүдтэй холбогдон эрчимтэй өөрчлөгдөж байна. Гэтэл манай ерөнхий боловсролын сургуулиудын олонхид нь хүүхдийн эрхийг зөрчиж байгаа жишээ олон. Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны иргэн Э.Гантулга хүү “Багш биднийг гэрийн даалгавар хийгээгүй эсвэл анги танхимд шуугилдахаар шийтгэдэг болохоор манай ангийнхан багшаасаа айдаг” гэв.

Насанд хүрэгчдийн гаргасан шийдвэр хүүхдүүдийн амьдралд янз бүрээр нөлөөлж байдаг ч хүүхдүүд тухайн шийдвэрт нөлөөлөх, дуу хоолойгоо хүргэх боломжгүй байдаг. Хүн хүүхэд байхаасаа эрхээ эдэлж, бага балчираасаа ардчилсан байдлаар шийдвэр гаргах үйл явцад оролцож байж хариуцлагатай иргэн болох чадвар сууж, ардчилсан үзэл, хандлага төлөвшдөг гэдэг. Хүүхдийг ивээх сангийн Монгол дахь захирал Мицуаки Тоёода “Нийгэмд тулгамдсан асуудал хүүхдүүдэд илүү хүнд тусдаг. Тэд бодит байдлыг үнэн зөвөөр харж ойлгох нарийн мэдрэмжтэй бөгөөд хүн бүрийн төлөө сэтгэл зовниж, шийдлийг эрэлхийлж байдаг. Ийм учраас хүүхдийн утга төгөлдөр оролцоо нийгмийн хөгжилд шууд нөлөөлдөг” гэсэн юм. Хүүхэд бүр гэр бүл, сургууль цаашлаад нийгмийн бүхий л түвшинд өөрийн эрх ашигт хамаатай асуудалд дуу хоолойгоо хүргэх нь эрхээ эдлэхээс гадна иргэний хувиар үүрэг хариуцлага хүлээх чадвар суудаг болохыг Рожер Хартын шатлалаар баталсан байдаг. Хүүхэд шийдвэр гаргах үйл явцад оролцож чадаж байна гэдэг нь жинхэнэ ардчиллын шинж тэмдэг

бөгөөд ардчиллыг бүтээн байгуулах, хадгалахад шууд нөлөөлдөг гэх нь ч бий.

Тухайлбал,

-Тэд биднийг аливаа асуудлыг ойлгохгүй гэж боддог. Үнэндээ тэд биднийг ойлгодоггүй.

/Ц.Цэлмэг, 12 настай/

-Хүмүүс ээ, хог битгий хая л даа. Бид өөрсдөө л хог хаяхгүй бол орчин тойрон маань цэвэрхэн байна шүү дээ.

/Б.Маралмаа, 10 настай/

-Ерөнхийлөгч өө, ард иргэддээ санаа тавих цаг нь боллоо шүү дээ. Ядуу иргэддээ туслаачээ.

/Г.Жаехлантөгс, 8 настай/

-Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байхгүй. Харин хотын төвд байдаг. Биднээс хэн ч хүүхдийн тоглоомын талбайтай болмоор байна уугэжасуужбайгаагүй. Гэр хорооллын дэлгүүрийн худалдагч нар насанд хүрээгүй хүүхдэд архи, тамхи зарж л байдаг. Гэхдээ хэн ч тэднийг хууль зөрчлөө гэдэггүй.

/Б.Хулан, 12 настай/

Ийнхүү хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлж байна. Өмнө нь аав, ээж, ах, эгч юу гэх бол гэж хүлээдэг байсан бол “Сайн засаглалд хүүхдийн оролцоо амин чухал” төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр хүүхдүүд тодорхой хэмжээнд дуу хоолойгоо нийгэмд хүргэж эхэлжээ. ■



ХАМТЫН АЖИЛЛАГАА

Р.АМАРЖАРГАЛ: МОНГОЛ УЛСТАЙ ХАРИЛЦАА ТОГТООСОН АНХНЫ БАРУУНЫ ОРОН БОЛ ИХ БРИТАНИ

Б.ТОГТОХ

Монгол Улсын 21 дэх Ерөнхий сайд, УИХ-ын гишүүн, Монгол, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант хоёр улсын Парламентийн бүлгэмийн дарга Р.Амаржаргалаас хоёр орны хамтын ажиллагааны талаар товч ярилцлаа.

-Өнгөрсөн хугацаанд хоёр орны

Парламентийн бүлгэм хэрхэн ажилласан талаар мэдээлэл өгнө үү. Хамтын ажиллагаанд ахиц дэвшил гарсан уу?

-Дипломат харилцаа тогтоосон нь Монголын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын хувьд чухал үйл явдал болсон гэж би хувьдаа үздэг. Тухайн үед барууны орнууд дотроос манай улстай дипломат харилцаа тогтоохыг хүлээн зөвшөөрч, харилцаа тогтоогоод зогсохгүй БНМАУ-ын ▶

► нийслэл Улаанбаатар хотноо Элчин сайдын яамаа байгуулж бүрэн хэмжээгээр ажиллуулж ирсэн анхны барууны орон бол Нэгдсэн вант улс Их Британи. Тэр утгаараа их чухал арга хэмжээ юм. Үнэхээр тэр үед Монголтой хамгийн түрүүнд харьцаж эхэлсэн нь Их Британи юм шүү гэдгийг монголчууд одоо болтол сайн санаж явдаг юмаа гэдгийг нэгдүгээрт онцлон тэмдэглэмээр байна.

Хоёрдугаарт, хамтын ажиллагаа өргөн цар хүрээг хамрах гэж оролдож байсан. Гэхдээ түүхэн тодорхой нөхцөлөөс үүдэн хамтын ажиллагаа хүссэн хэмжээгээр өргөн далайцтай явуулж чадаагүй. Голдуу хүмүүнлэгийн салбарт давамгайлсан байдалтай, тухайлбал, боловсролын салбарт. Ялангуяа, социализмын үед боловсролын салбар дахь хамтын ажиллагаанд нэлээд дэвшил гарсан. Одоо ч дээрх чиглэлээр хамтын үйл ажиллагаа явагдаж байна. Сүүлийн үед эдийн засгийн хамтын ажиллагаанд багагүй ахиц гарлаа. Тэр тусмаа уул уурхайн салбарын хүрээ өргөжиж байна. Энэ нь “Рио Тинто” группээр дамжиж илэрч байгаа юм. Тус хамтын ажиллагаа урт хугацаандаа тогтвортой үргэлжилнэ гэсэн ойлголт бидэнд бий. Хүсэн хүлээж буй зүйл технологийн салбар дахь хамтын ажиллагааг далайцтай өргөжүүлэх нь зүйтэй болов уу гэсэн бодол байдаг. Монгол Улсын Засгийн газар энэ чиглэлд нэлээн анхаарах байх.

-Парламентийн бүлгэмүүдийн үйл ажиллагаа болоод цаашид хийхээр зорьж буй ажлынхаа талаар ярина уу?

-Миний бие УИХ дахь Монгол, Их Британийн Парламентийн бүлгэмийг тэргүүлдэг. Энэ бүлгэмийн даргаар үндсэндээ сүүлийн дөрвөн Их хуралд ажиллаж байна. Парламентийн бүлгэм нь УИХ-ын гишүүдээс бүрддэг бөгөөд бүлгэмд энэ чиглэлээр голдуу сонирхдог хүмүүс байгаа. Олон хүнтэй биш ээ. Сонгууль, сонгуулиас хамаараад тоо нь өөрчлөгддөг. Ерөнхийдөө 10 хүн багтаад явдаг Парламентийн бүлгэм. 1996 онд Парламентад орж ирээд дээрх бүлгэмийг тэргүүлж эхэлсэн. Тухайн

үедээ Их Британид сургууль төгссөн, англи хэлтэй гишүүн байлаа.

Парламентийн бүлгэмийн үйл ажиллагаа маш тодорхой, тухайлбал Парламентийн гишүүдээр дамжуулж хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой. Тус зорилтын хүрээнд Их Британийн Парламентийн төлөөлөгчдийг бид хоёр ч удаа Монголд хүлээж авсан. Бүрэлдэхүүний хувьд бараг 10 гаруй хүнтэй, томоохон групп ирсэн. Мөн манай УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад Английн Парламентад очиж ажиллах, суралцах боломж тохиосон. Британийн Парламентийн гишүүдийн тусалцаатайгаар төрөл бүрийн Британийн сангуудаас санхүүгийн дэмжлэг авч, мэргэжил, дадлага дээшлүүлэх курст суралцах боломж нэмэгдсэн.

Харин албан бусаар бол Английн Парламентийн гишүүдтэй хэлхээ холбоотой байх, тэдгээр гишүүдээр дамжуулаад Английн Парламентад Монгол Улсын талаар асуулга тавиулах, үг хэлүүлэх, тодорхой ажил хийдэг. Гол үйл ажиллагаа нь улс төрийн хүрээн дотор Парламентаар дамжуулаад Парламентийн институци, гишүүдээр нь дамжуулаад хоёр орны харилцааг дэмжиж туслахад чиглэсэн

үйл ажиллагааг явуулж ирсэн.

-Та Их Британийн аль сургуульд ямар чиглэлээр суралцсан бэ. Английн боловсролын тогтолцооны шилдэг чанар нь юунд оршдог бол?

-1993-1994 онд Баруун Йоркшир мужийн Бредфорд хотод Шинжлэх ухааны магистрийн зэрэг хамгаалсан. Тэр үед Британийн консул гэж байсан. Миний хувьд Их Британийн шугамаар явж байсан анхны монгол оюутнуудын нэг. Британид нэг жил, хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн хөгжлийн асуудал гэдэг чиглэлээр суралцсан. Суралцах хугацаандаа Монголын эдийн засгийн шилжилтийн политэкономид сэдвээр эрдмийн зэрэг бичиж, Шинжлэх ухааны магистрийн цол хамгаалсан.

Английн боловсролын тогтолцоо дэлхийд толгой цохьдог. Дэлхийд толгой цохьдог тогтолцоог өөрийн биеэр үзэж харах сонирхол надад байсан. Учир нь тухайн үед би одоогийн СЭЗДС буюу хуучнаар Эдийн засгийн коллежийн захирлын албыг хашиж байсан. Зөвлөлтийн боловсролын тогтолцоог мэднэ. Тэгвэл барууны боловсролын тогтолцооны дунд нь ороод үзэхээр ямар юм байдаг гэдгийг судлах, давхар зорилготой байв. Энэ хүрээнд явж суралцсан. ■

БОЛОВСРОЛЫН СИСТЕМ

АНГЛИЙН АМЖИЛТЫН ОНЬС

Д.ЖАРГАЛСАЙХАН (Эдийн засагч)

Хатагтай, ноёдын үйлдвэрлэл I

Британи хүн байхын нэг нууц бол боловсролын системтэй нь холбоотой аж. Английн боловсрол

нь цаг үеийнхээ эрэлт хэрэгцээг урьдчилан харж хөгжихийн зэрэгцээ түүхэн уламжлалаа хадгалан түүндээ зохицож өөрийгөө боловсронгуй болгодог систем тул орон бүрийн залуусын мөрөөдлийн нэгэн оргил болжээ.

Их Британид хүүхэд бүр 16 нас ▶



Боловсролын бүх түвшиндээ хүний зан төлөвийг бүрдүүлдэг боловч бага сургууль нь сайн хүн болох эх үндсийг тавьж өгдөг

► хүртлээ боловсрол эзэмших хуультай. Нийтийн сургуульд 5-16 насны хүүхэд үнэ төлбөргүй суралцана. 5-11 насны хүүхдийн сургуулийг бага (primary), 12-18 насныхыг дунд (secondary) сургууль гэдэг. Бага ангид элсэхээс өмнө дөрвөн настайд нь бэлтгэл ангид элсүүлж, тоглуулах, ярилцахын завсарт унших, бичих, тоолж сурах үндсийг нь тавьдаг аж. Бага сургуулийн багш нар нийгэмд маш хүндтэй байр суурь эзэлдэг. Мэдлэг олгохоос өмнө нь сайн хүн болгоход анхаарна. Өөрийгөө болон бусдыг хүндэлдэг, харьцааны соёлтой, өөртөө итгэлтэй, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг болгоход нь тэд эн тэргүүнд анхаардаг байна.

Хүүхдийн боловсрол бол багш, эх, эцгийн хамтын ажиллагааны үр дүн. Сургуульд болсон, мөн болох гэж буй үйл явдлын тухай захиаг хүүхдээр гэрт нь хүргүүлэх, эцэг, эхийн цахим шуудангийн нэгдсэн сүлжээ үүсгэн мэдээлэх, эсвэл сургуулийн цахим хуудсандаа мэдээлэх зэргээр харилцдаг.

Долоо хоногийн тогтсон нэг өдөрт ямар хичээлийн ямар сэдвийг ямар аргаар зааж буй тухай таниулах хичээлийг эцэг, эхчүүдэд үзүүлнэ. Ингэснээр эцэг, эхчүүд яг багшийнх нь зааж буй аргаар хүүхдэдээ туслан, сурах үйл явцад

хэрэгтэй олон янзын аргын дунд будилуулж, самууруулахгүйн тулд ийн ханддаг аж. Багш нар сурагч бүрийн сурлага хүмүүжлийн тухай сар тутам хэлэлцэн, юунаас хоцорч байгаа, хэрхэн сайжруулах вэ гэдгийг төлөвлөдөг. Хичээлийн жилийн эхэнд хүүхэд бүрийн түвшинг тогтоосноор уг хүүхдийн өнөөгийн болон хүрч чадах боломжит дээд түвшинг хичээл бүрээр үнэлэн, улсын дундажтай харьцуулсан хүснэгт гаргана. Ингээд улирал бүрийн эцэст эцэг, эхэд нь хүүхдийн мэдлэгийн өсөлт дэвшлийг тайлбарлан дараагийн улиралд ямар сэдвийг илүү анхаарах, түүнд нь хэрхэн туслах тухай ярилцана. Ирээдүйн хатагтай, ноёдын суурь нь тавигддаг тул бага сургуульд британичууд онцгой ач холбогдол өгдөг. Баасан гаригийн өглөө сургуулийн сурагчдын өмнө багш нь анги бүрийн “Долоо хоногийн од” хэн болсныг зарлаж, юугаараа тодорсныг нь онцлон тэмдэг зүүж өгдөг. Тэмдгээ бас гэрийнхээ хөргөгчин дээр наадаг учир амжилтыг нь сануулж зоригжуулдаг байна. Долоо хоногоор шалгаруулах нь бүтэн жил, улирал хүлээснээс илүү нөлөө үзүүлэхээс гадна бага ангийнханд онц сурах эрмэлзлийг нь төрүүлдэг.

Олон соёлын огтолцол дунд оршдогийн хувьд англичууд

сургалтандаа газар газрын соёлоос танилцуулахыг эрхэмлэдэг. Энэтхэгийн долоо хоног, Хятадын шинэ жил, Монголтой танилцах өдөр зэрэг арга хэмжээг зохиож, тэр сэдвээр бэлтгэж ирсэн сурагчид өөрсдийн үзүүлбэрээ (зурагт хуудас, хоолны дээж гэх мэт) бусдадаа танилцуулдаг байна. Ингэснээр сурагчид нь багаасаа бусдын амьдрал, соёлыг ойлгож, дэлхийн хүн болж төлөвших суурь нь тавигддаг байна.

Английн амжилтын оньс нь боловсрол юм. Боловсролын бүх түвшиндээ хүний зан төлөвийг бүрдүүлдэг боловч бага сургууль нь сайн хүн болох эх үндсийг тавьж өгдөг гэдэг утгаараа Британийн хатагтай, ноёдын “үйлдвэрлэл”-ийн анхны цех нь гэлтэй.

Хатагтай, ноёдын үйлдвэрлэл II

Дунд сургууль

Британийн хатагтай, ноёдын үйлдвэрлэлийн удаах цех нь дунд болон “А” түвшний сургууль юм.

Эцэг, эх нь хүүхдээ 12 настайд нь дүүргийнхээ нийтийн төлбөргүй дунд сургуульд, эсвэл хувийн төлбөртэй сургуульд оруулдаг. ►

► Их, дээд сургууль хүртэлх боловсролын хөтөлбөр нь дотроо зургаан үе шаттай. Бага сургуульд эхний хоёр, дунд сургуульд 3-4 үе шатыг хамарна. Англи хэл, тоо, шинжлэх ухаан гэсэн гурван хичээлийг дунд сургуулийн сурагчдын насанд нь тохирсон хөтөлбөрийн дагуу ордог. Түүнээс гадна урлаг ба дизайн, иргэншил, дизайн ба технологи, газар зүй ба түүх, мэдээлэл ба холбооны технологи, гадаад хэл, хөгжим, биеийн тамир зэрэг суурь хичээлийг багцлан заадаг.

Мөн хуулиар зохицуулаагүй ч бүх шатныханд шашны боловсрол, хоёрдугаар шатнаас нь бэлгийн харилцааны боловсрол, 3-4 дүгээр шатныханд мэргэжлээ сонгох болон хөдөлмөртэй холбоотой сургалт явуулдаг. Гэхдээ эцэг, эхийн хүсэлтээр шашны болон бэлгийн харилцааны боловсролын хичээлээс хэсэгчлэн юм уу, бүхлээр нь чөлөөлөх боломжтой. Шашны боловсролын хичээл нь шашинд дүгнэлт өгөх биш, амьдралын тодорхой асуудлаар, тухайлбал, үр хөндөлтийг шашин тус бүр юу гэж үздэгийг мэдэх, хүүхдүүд өөрсдөө юу гэж боддог тухайгаа ярилцдаг жишигтэй. Ийм аргаар орон орны үндэстэн зэрэгцэн оршиж буй

Их Британи шиг улсад шашны гарал үүсэл, мөн чанарыг ойлгуулахын зэрэгцээ шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахаас сэргийлж, хүүхдийн бие даасан өөрийн үзэл бодол, бусдыг ойлгох чадварыг хөгжүүлдэг.

Түүхийн хичээл дээр тодорхой үйл явдлыг сурах бичиг, бусад эх сурвалжаас олж мэдсэний дараа сурагч бүр өөрийн дүгнэлт, үзэл бодлоо илэрхийлсэн эсээ (essay) бичнэ. Жишээ нь, “Дэлхийн II дайн дэгдэхгүй байж болох байсан уу. Хүйтэн дайнаас хэн хохирсон бэ” гэсэн сэдвээр үзэл бодлоо илэрхийлэн, үүнийг батлах тоо баримт, эх сурвалжийг дурдах, эсвэл өөрийн байж болох хувилбарыг дэвшүүлдэг. Энэ хичээлийн явцад сурагч цэгцтэй бодох, санаа бодлоо бичгээр болон яриагаар тод илэрхийлэх дадал эзэмшинэ.

Хөдөлмөрийн хичээлийг 15 наснаас нь үйлдвэрлэл дээр ажиллуулахын хажуугаар заадаг. Сурагч бүр аравдугаар ангийн хавартаа сургуулийнхаа гэрээтэй үйлдвэрт, эсвэл эх, эцэг нь санал болгосон орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээний компанид хоёр долоо хоног дадлага хийнэ. Английн

хуулиар 14 нас хүрсэн бол долоо хоногт нэг өдрөөс хэтрэхгүй ажиллах боломжтой. Гэхдээ цалин нь насанд хүрэгчдээс 30 хувь доогуур (цагт дөрвөн фунт орчим) байдаг. Мөн арвандүгээр ангид элссэний намар хоёр дахь дадлагаа хийдэг. Харин 16 нас хүрсэн бол долоо хоногт хоёр өдөр ажиллахыг зөвшөөрнө. Цалин нь насанд хүрэгчидтэй адил (6.5 фунт) хэмжээний байна. Дээрх хоёр дадлага нь хүүхдийг хөдөлмөрийн үнэ цэнийг өөрийн биеэр мэдрэн ойлгож, бусдын хөдөлмөрийг хүндэтгэхэд сургадаг.

Дунд сургуулийн удирдах дээд байгууллага нь Сургуулийн удирдах зөвлөл (School's Governing Body) байна. Тус зөвлөлийн бүрэлдэхүүнд эцэг, эхийн, сургуулийн ажиллагсдын, орон нутгийн (хэн байхыг бусад гишүүн хамтран томилдог), дүүргийн төлөөлөл болон хандивлагч нарын төлөөлөл, сургуулийн захирал багтана. Удирдах зөвлөл нь сургуулийн төсвийг баталж, томоохон шийдвэр, түүний дотор хүүхэд, багш нарын орон тоог тогтооно. Мөн захирлыг томилох, халах, тайланг сонсох төдийгүй ажлын гүйцэтгэлийг дүгнэн, урамшууллыг нь батална. Захирлын цалин компаниудын ►►



Дунд сургуулиа төгсөөд дийлэнх сурагчид их, дээд сургуулийн бэлтгэл ангид (A level) дэвшин 17-18 насандаа хоёр жил суралцдаг

✦ захирлын түвшинд буюу 70 мянга орчим фунт байдаг. Дунд сургуулийн зөвлөлийн гишүүн болсон эх, эцгийг хурлын өдрүүдэд ажлаас нь чөлөөлнө. Зөвлөлийн гишүүн хуралд суусан цагаараа хөлс авдаг. Мөн эцэг, эх болон сургууль хоорондын харилцааг бэхжүүлэх зорилготой Эцэг, эх, багш нарын холбоо (PTA Parent Teachers Association) гэдэг байгууллага сургууль бүрт бий.

А түвшний сургууль

Дунд сургуулиа төгсөөд дийлэнх сурагчид их, дээд сургуулийн бэлтгэл ангид (A level) дэвшин 17-18 насандаа хоёр жил суралцдаг. А1 ангид 3-4 хичээл сонгон суралцаж хавар нь шалгалт өгнө. Энэ шалгалтын дүн их, дээд сургуульд элсэхэд голлох үүрэгтэй. Элсэх хүсэлтэй сургуульдаа шалгалтын дүн, сонгосон шалтгаан, хэн болж, юу хийх тухайгаа товч, тодорхой захидлын хамт хүргүүлнэ.

Хувийн мэдэгдэл (personal statement) гэдэг энэ захианд их, дээд сургуулиуд шалгалтын дүнтэй ижил өндөр ач холбогдол өгдөг. Хувийн мэдэгдэл нь тухайн хүүхдийн бүтээлч сэтгэхүй, сурах эрмэлзэл, сонирхол, оюун ухааны онцлог, хувийн зан араншин, төлөвшилийг нь илэрхийлдэг. Энэ мэдэгдлээ яаж бичих, өөрийгөө хэрхэн илэрхийлэх тухай багш нар нь зааж сургадаг.

Нэр алдартай их сургуулиуд сурлагын дүн болон хувийн мэдэгдлийг нь судалсны дараа тухайн сурагчийг элсэлтийн ярилцлагад урьдаг. Авна гэвэл А2 түвшний буюу төгсөлтийн шалгалтаа сайн өгөх сүүлчийн болзол тавьдаг. Ийм аргаар их, дээд сургуулиуд хамгийн чадвартай, авьяаслаг сурагчийг сонгодог. Ингэснээр оюун ухаан нь сайн хөгжсөн, тодорхой зорилго, хүсэл эрмэлзэлтэй, хувийн сахилга баттай хүн их, дээд сургуульд элсэн ордог.

Ийнхүү сургуулиа төгсөхөөсөө өмнө их сургуульд элсчихсэн байдаг тул ирээдүйн мэргэжил, ажил, амьдралынхаа тухай сайтар бодон төлөвлөхөд нь тус болдог. Хүүхдүүд их сургуульд элсээд эх, эцгийнхээ гэрээс явж оюутны байр, эсвэл орон сууц түрээслэн амьдарна.

Эдийн засагч Д.Жаргалсайханы хоёр орны дипломат харилцааны 50 жилийн ойд зориулж бичсэн “Хатагтай ноёдын үйлдвэрлэл I, II” гэсэн цуврал нийтлэл болон энэ сэдвээр хийсэн түүний баримтат киноноос товчлон хүргэлээ. Д.Жаргалсайхан хэлэхдээ “Мэдээж 63 сая хүнтэй оронд бүх зүйл төгс биш ч дээрх хоёр нийтлэл болоод баримтат кино маань Монголын боловсролын тогтолцоог дэлхийн шилдгүүдээс суралцан боловсронгуй болгоход хувь нэмэр өгнө гэж найдаж байна” хэмээсэн юм. ■

АНГЛИД ТӨГСӨГЧДИЙН СЭТГЭГДЭЛ

Кембрижийн анхны монгол оюутан болсноороо бахархдаг



С.Оюун
/БОНХ-ийн сайд/

-Дэвид Ланделл багш маань намайг Англи руу хөтөлсөн гэхэд болох юм. Ер нь бол заавал түгжигдмэл орчинд өсч торнисон миний үеийхэнд Англи гэлтгүй Өрнөдийн нийгмийн амьдралтай танилцах сонирхол байсан нь мэдээж. 1991 онд МУИС-ийн Англи хэлний оройн курст суралцаж байхдаа айлын хүүхэд харах ажилд ч хамаагүй явж, далимаар нь орчинд нь орж хэлний курст сурах хүсэлтэйгээ Дэвид багшдаа хэллээ.

Тэгсэн багш маань өөдөөс бараг загнасан юм. Түүнийхээр бол би хэтэрхий жижиг зорилготой байсан юм уу даа. Удалгүй багш маань нутагтаа амраад ирэхдээ надад хоёр сургуулийн анкет авчирч өгсөн. Нэг нь Кембрижийн их сургуулийнх. Тэгээд зөвхөн доктрантурт суралцах эрх. Кембрижийг сонгоод төлбөрийн асуудлаа шийдлээ. Эхний жил их хэцүү байсан. Дараа жилээс нь орчноо таньж мэдээд, хэл маань ч жигдрээд ирэхэд харин ч сайхан болж билээ. Хичээл

нь хүндхэн байсан боловч оюутны амьдралыг дагалдах спортын, урлагийн амьдрал их таалагддаг байлаа. Хоёр жил дараалаад Английн их, дээд сургуулиудын аварга каратэчин болсон.

Дөрвөн жил өнгөрч изотопын геохимээр байгалийн ухааны доктор болов. Олон зуун жилийн уламжлалтай Их сургуульд салбартаа тэргүүлдэг эрдэмтдээр ном заалгаж явсан минь амьдралын маань бахархалтай он жилүүд юм. Кембрижийн анхны монгол оюутан болсноороо бахархдаг. Сургуулийнхаа изотоп лабораторийг би их биширдэг байлаа. Өндөр технологи гэдэгтэй тэнд л анх учирсан юм.

Кембриж төгсөх үед “Рио Тинто” компани Улаанбаатарт оффисоо нээж таарсан юм. 1996 онд би Лондонд байх судалгааны төвд нь ажилд орж хоёр жил боллоо. Ёстой л цомхон бөгөөд чадварлаг баг гэдгийг тэнд үзэж билээ. 30 орчим хүн ажилладаг. Маш өндөр мэргэшсэн судлаачид байлаа. ▶

▶ Тэдэнтэй ажиллахад урамтай, их зүйлд суралцаж билээ.

Англичууд амралтаа маш сонирхолтой, сайхан зохион байгуулж чаддаг. Тэдний хамт үүргэвчтэй, дугуйтай аялалд явна. Англи бол аялаад л баймаар газар. Байгаль нь

сайхан, түүх дурсгалын газар ихтэй.

Англи, Кембриж бол залуу насанд нүдийг минь нээж өгсөн газар. Англичууд намайг дэмжиж мэргэжлээрээ ахиж дэвших боломж олгосон. Би Англи орон, англичуудад ямагт талархаж явдаг.

Белфастын Хатан Хааны их сургуульд ажиллаж байна



Г.Рагчаасүрэн
/ИБУИНВУ-ын Белфастын Хатан хааны их сургуулийн багш, дэд профессор/

-Их Британийн Манчестерийн их сургуульд эдийн засгийн магистрт суралцахаар 1999 онд очсон. Тэр цагаас хойш миний ажил, амьдрал Их Британи улстай бүх талаараа холбогдсон. Нэг жилийн магистераа дуусгаад, докторт суралцах тэтгэлэг хүлээн авч, 2004 онд хамгаалсан. 2003 онд Их Британийн Эссэксийн их сургуульд багшаар орж 2006 он хүртэл ажилласан. 2006 оноос эхлэн өнөөг хүртэл Белфастын Хатан Хааны их сургуульд ажиллаж байна. Анх Манчестерийн их сургуульд явсан түүхээ дурдвал Соросын сан, Их Британийн Элчин сайдын яам, Манчестерийн их сургууль хамтраад дундаасаа Манчестерийн их сургуульд эдийн засгийн магистрийн зэрэг хамгаалах тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлсэнд нь би хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу 10 гаруй жилийн туршид манай улсаас нийт 40

гаруй оюутан эдийн засгийн магистрт суралцсан. Тус хөтөлбөр манай улсад орчин үеийн эдийн засгийн мэдлэгтэй боловсон хүчин бүрэлдэхэд маш чухал үүрэг гүйцэтгэсэн гэж боддог. Тэрхүү 40 гаруй төгсөгчөөс дөрөв нь тус сургуульдаа цаашид суралцаж докторын зэрэг хамгаалсан байдаг. Энэ дөрвөн оюутнаас хоёр нь академик судалгааны чиглэлийг сонгож, Их Британийн их сургуулиудад ажилласны нэг нь би юм.

Манай улс урт хугацааны эдийн засгийн хөгжилд хүрэхийн тулд үйлдвэрлэлийн болоод боловсрол, шинжлэх ухааны салбарт хийх хөрөнгө оруулалтын хэмжээ болон түүний үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Үүнтэй дотоодын магистрийн болон докторын сургалтын чанарын асуудал их холбоотой. Энэ тал дээр бид хамтраад хийж бүтээж чадах зүйлс ойрхон мэт санагддаг.

Британид суралцсан нь нэр хүндийн хэрэг



Л.Баян-Алтай
/“Макс Групп”-ын үйл ажиллагаа хариуцсан захирал/

-Миний бие 1997-1998 онд Их Британийн Лийдс их сургуулийн харьяа Бизнесийн сургуульд суралцаж, Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. Их Британид мэргэжлийн чиглэлээр суралцсан анхны оюутнуудын нэг байсандаа өөрийгөө азтайд тооцдог.

Лийдс их сургуульд Монгол судлалын томоохонд тооцогдох факультет байдаг нь дахин давтагдашгүй бөгөөд монгол хэл

дээр олон мянган ном, материал хадгалагдаж байдаг.

Уг сургууль 1990 оноос ч өмнө Монгол Улстай дотно харилцаа холбоотой байсан бөгөөд хэл судлалын оюутнуудыг суралцуулж, солилцооны тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлсээр ирсэн. Их Британид суралцсан нь миний хувь нэр хүндийн хэрэг бөгөөд тус улсын ард иргэд, соёл, түүхийг гүнээ хүндэтгэдэг билээ. ▶

► Дэлхийн хамгийн шилдэг сургуулийг төгссөндөө баяртай байдаг



А.Баярмаа, / Ньюком Группын “Клинерджи” компани Нүүрстөрөгчийн санхүүжилтийн мэргэжилтэн, :/

-МУИС-ын Олон улсын харилцааны сургуулийг 2008 онд төгсөж бакалаврын зэргээ авсны дараагаар Оксфордын их сургуульд магистрийн зэрэг хамгаалах боломж надад олдсон юм. Байгаль орчны салбарт их сонирхолтой болсон байсан тул Байгаль орчин, нийгэм ба хүрээлэн буй орчны бодлого чиглэлээр зэрэг хамгаалсан.

Оксфордын их сургуулийн тухай хүмүүс тодорхой хэмжээгээр мэдэх байх. Англи хэлтэй орнуудын хамгийн анхны Их сургууль тул XII зуунаас эх түүх нь эхэлдэг. Манай Чингис хааныг улс орноо нэгтгэж байх үед Оксфордын их сургууль үүсэн байгуулагдаж боловсрол олгох ажлаа эхэлсэн байдаг. Оксфордын их сургуулийн гол онцлог нь боловсролын чанартаа оршдог болов уу. Дэлхийн хамгийн шилдэг сургуулийн нэгд жил бүр жагсдаг сургуулийг төгссөндөө их баяртай байдаг. Англид өнгөрүүлсэн нэг жил миний хувьд амьдралын маань хамгийн том бас

үнэтэй туршлага болон үлдсэн. Богино хугацаанд их зүйл сурсан гэж боддог. Сурсан туршлага, мэдлэг ажил, амьдралд минь онцгой хувь нэмэр оруулж байгаа.

Өөр нэгэн онцлох зүйл гэвэл олон найз нөхөдтэй болж, олон гайхамшигтай хүмүүстэй танилцсан. Сургууль дээр хичээлээс гадна төрөл бүрийн сонирхолтой лекц, семинар болдог бөгөөд тэр бүгдээс байнга шинэ мэдээлэл, урам зориг авдаг байсан.

Энэхүү завшаанаар дамжуулан Оксфордын их сургуульд суралцах Чевнингийн бүрэн тэтгэлэгт хөтөлбөрт хамруулж, итгэл найдвар хүлээлгэсэн бүх хүнд талархлаа илэрхийлмээр байна. Өнөөдөр би эзэмшсэн мэдлэг, туршлагаа хуваалцаж илүү олон залуусыг тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан Англид мэргэжил дээшлүүлэхэд нь туслах зорилгоор Монгол дахь Их Британид төгсөгчдийн холбоог үүсгэн байгуулан идэвхтэй ажиллаж байгаа.

Лондонгийн Худалдааны сургуулийг сонгон суралцах олон шалтгаан бий



Н.Ууганбаяр, /SGS Mongolia-ийн Бизнесийн хөгжлийн ажилтан/

-Би 2012 онд Бизнесийн удирдлагын магистрийн (MBA) зэргийг Кардиф Метрополитан их сургуулийн хөтөлбөрийн дагуу Лондонгийн Худалдааны сургуулийг дүүргэсэн.

MBA-ийн зэрэг горилох хөтөлбөрийн туршид их зүйлийг сурсан гэж би боддог. Ерөнхийдөө энэхүү хөтөлбөр нь суралцагчдад бизнесийн төрөл бүрийн мэдлэг олгох зорилготой. Тухайлбал нягтлан бодох бүртгэл, санхүү, маркетинг, хүний нөөцийн удирдлага, стратегийн удирдлага гээд олон хичээл заадаг. Үнэндээ MBA-ийн зэрэг горилох сургалт нь өөрт байгаа туршлага дээр тулгуурлан бизнесийн хүрээллээ тэлэх, ажил мэргэжлийн замналдаа өөрчлөлт хийхийг хүсэж буй нэгэнд илүү тохиромжтой. Мөн энэхүү зэрэг нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дэлхий дахины ажил олгогч эздэд танигдсан гэдгээрээ давуу талтай.

Чанартай боловсролыг сонгох, тухайн боловсролоо хаана эзэмших нь хүний амьдралыг өөрчлөхүйц томоохон шийдвэр

байдаг. Ер нь Лондонгийн Худалдааны сургуулийг сонгон суралцах олон шалтгаан бий л дээ. Мөн энэхүү сургууль нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Англи боловсролыг олгодгоороо давуу талтай.

Англид суралцсан цаг хугацаа надад олон шинэ, гайхамшигтай зүйлтэй танилцах завшааныг олгосон. Харь улсад амьдарч, гадаад хэлээр ярьж, шинэ хүмүүстэй танилцан, нөхөрлөх нь намайг илүү бие даан амьдрахад, өөрийгөө танин мэдэхэд тусалсан.

Лондон хот нь өөрөө шинэ танил, найз нөхөдтэй болоход яг тохирсон газар. Учир нь энэ хотод олон төрлийн хэл, соёл, зан заншилтай 270 гаруй үндэстэн амьдардаг. Лондонгийн гудамжаар алхах нь Английн өөрийн хэв маягийг харуулахаас гадна заримдаа Хятад, Пакистан, Энэтхэг, Өмнөд Америк, Европ зэрэг оронд ирсэн мэт сэтгэгдэл ч төрүүлдэг. Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүс нь Лондоныг бусад хотуудаас онцгой, олон үндэстний хэв маягтай болгосноороо онцлог. ■

ЭРҮҮЛ МЭНД

АНГЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТОГТОЛЦОО

Б.БАЯР

Азийн хөгжлийн банк /АХБ/-ны дэмжлэгтэйгээр Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Сангийн яам, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны төлөөлөл бүхий цомхон баг энэ оны тавдугаар сард Их Британи улсад долоо хоногийн хугацаанд айлчилсан билээ. Тус баг нь Английн эрүүл

мэндийн системийн онцлог, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний талаар туршлага судлахаар ийн ажиллаад ирсэн юм. Айлчлалын хүрээнд манай тал гурван зүйлд анхаарлаа хандуулжээ. Эмнэлгийн шинэчлэл, Эрүүл мэндийн санхүүжилт, Анхан шатны эрүүл мэндийн шинэчлэл гэсэн чиглэлээр голлон туршлага судалсан байна. Тус айлчлалын бүрэлдэхүүнд багтсан холбогдох албаны хүмүүсийн сэтгэгдлийг хүргэе.

Нотолгоонд суурилсан анагаах ухааныг сайн хөгжүүлжээ



Б.Булганчимэг
/Эрүүл мэндийн яам,
АХБ-ны
“Эрүүл мэндийн
салбарын хөгжил
хөтөлбөр-3, 4” төслийн
удирдагч/

-Английн эрүүл мэндийн тогтолцоо нь манай улсын эрүүл мэндийн тогтолцооноос нэлээд ялгаатай. Монгол эрүүл мэндийн тогтолцоо нь хэд хэдэн эх үүсвэрээс санхүүжилттэй. Улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, хувь хүний төлбөрөөс төсөв нь бүрддэг бол Английн эрүүл мэндийн систем ихэвчлэн улсын төсвөөс санхүүжилт авдаг. Үүнээсээ хамаараад багагүй ялгаатай болж байгаа юм. Их Британийн анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллага нь манай улсад үйл ажиллагаа явуулж буй өрхийн болон сумын эмнэлэгтэй ижил гэж хэлж болно. Англи нь өрхийн эмнэлгийн тогтолцоотой. Мэдээж өндөр хөгжилтэй, хөгжсөн орон учраас эрүүл мэндийн тогтолцоо нь бие даасан, хөрөнгө мөнгөний асуудалгүй. Үүнтэй холбоотойгоор орон байр, тоног төхөөрөмж, тэнд ажиллаж буй хүмүүсийн цалин хангамж харьцангуй өндөр юм билээ. Түүнээс гадна нийгмийн шинжтэй үйл ажиллагааг эрүүл мэндийн байгууллага нь идэвхтэй зохион байгуулдаг нь харагдаж байсан. Тухайлбал, бидний танилцсан өрхийн эрүүл мэндийн төв нь

хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлсан өрөө гаргаж, үйлчилгээг үзүүлдэг. Анхан шатны эрүүл мэндийн төв нь нийгмийн шинжтэй үйл ажиллагааг сайтар зохион байгуулдаг юм байна.

Их Британийн Эрүүл мэндийн яаманд нь шаардлагатай бодлого, зөвлөмж, стандартыг нь боловсруулж өгдөг мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа бидний анхаарлыг ихэд татсан. Манай эрүүл мэндийн яам дэргэдээ дээрх чиглэлийн байгууллагатай байвал их зүгээр санагдсан. Мэргэжлийн холбоо, их сургууль нь нэлээн хүчирхэг. Тухайлбал, Их сургууль нь мэргэжлийн холбоо, давхар үйлдвэрчний эвлэлийн үүргийг гүйцэтгэж байна.

Английн бага, дунд мэргэжлийн сувилагчдын эгнээндээ нэгтгэсэн, татвар хураамжийн систем нь тогтсон гэж хэлж болно. Тиймээс сувилагчдынхаа дуу хоолойг хамгаалсан, мэдээ мэдээлэл түгээсэн сонин, сэтгүүл хүртэл гаргадаг юм байна. Англи эдийн засгийн хувьд боломжтой, чадавхтай учраас нотолгоонд суурилсан анагаах ухааныг сайн хөгжүүлжээ. ▶

► Англид эрүүл мэндийн мэргэжлийн холбоод хүчтэй хөгжсөн байна



О.Хуягцогт
/Сангийн яамны
Баялгийн сангийн
удирдлагын
хэлтсийн дарга/

-Их Британийн эрүүл мэндийн салбар өндөр хөгжсөн юм билээ. Тэр тусмаа салбарын техник технологи, үзүүлж буй үйлчилгээний үр ашигтай байдал нь дэлхийн хөгжингүй орнуудаас хол давуу болохыг Английн эрүүл мэндийн салбарынхан өөрсдөө ч хэлж байсан. Эмнэлгийн бие даасан удирдлагын менежмент амжилттай сайн хөгжиж байна. Түүнчлэн эрүүл мэндийн анхан шатны тогтолцоо нь олон улсад жишиг болохуйц санагдсан. Тэнд татвар төлж буй Их Британийн иргэн бүр эрүүл мэндийн үйлчилгээг хүртэх ёстой гэсэн зарчим үйлчилдэг. Уг зарчмын дагуу иргэдийнх нь эрүүл мэндийн чанар харьцангуй сайн.

Англи эрүүл мэндийн цогц системийг хөгжүүлэхээс гадна бусад орны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулж байгааг онцлон тэмдэглэе. Тус улсын эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх байгууллагад хуваарилах улсын төсвийн хэмжээг хүн амынх нь тоотой уялдуулж олгодог юм билээ. Өөрөөр хэлбэл, тухайн бүсэд хэчнээн иргэн амьдарч байгаа, түүний хэчнээн нь өндөр настан, хүүхэд гээд нарийн статистик судалгаанд үндэслэн төсвийг нь олгодог гэсэн үг. Мөн хэр үр дүнтэй ажиллаж байгаагаас гадна үр ашигтай ажилласан эсэхээс хамаарч төсвийг нь тогтоодог. Уг жишиг үзүүлэлтийг манайд хэрэгжүүлбэл бодитой үр дүн гарах болов уу.

Английн зарим эмнэлэг нь бие даасан

удирдлагатай. Хэдий улсаас санхүүжилтээ авах боловч бусад менежментийн асуудлаа удирдлагын баг нь дангаар шийдээд явдаг. Тухайлбал, ямар багаж хэрэгсэл авах, хаана, хэнээр шинэ эмнэлэг бариулах гээд тухайн эмнэлгийн дотоод "гал тогоо"-ны асуудлыг нь бүрэн хариуцдаг. Энэ нь эргээд эмнэлэг үр ашигтай ажиллах, төсвөө хэмнэх, сайн засаглал хөгжих эх үндэс болдог аж. Тухайн эмнэлэг ямар менежментээр явахыг баг нь шийддэг гэсэн үг. Удирдлагын баг хэрхэн үр ашигтай ажиллахаас эмнэлгийн ирээдүй хамаардаг тогтолцоог төлөвшүүлээд хэрэгжиж байна. Тодорхой хэмжээний өрсөлдөөнийг бий болгох замаар хувийн эмнэлэгт зарим эрх үүргээ шилжүүлсэн байдаг юм билээ. Их Британийн эрүүл мэндийн систем тусламж үйлчилгээ үзүүлэхдээ шинжлэх ухааны нотолгоонд үндэслэсэн. Хамгийн үр дүнтэй эмчилгээг хөндлөнгөөс судалдаг. Энэ нь бага зардлаар оновчтой эмчилгээ үзүүлэх хөшүүрэг болдог аж. Мөн эрүүл мэндийн мэргэжлийн холбоо хүчтэй хөгжсөн. Тус мэргэжлийн холбоод нь эрүүл мэндийн стандартыг хэрхэн мөрдөх, чанар, үйлчилгээг яаж хүргэх талаарх зөвлөмж, зөвлөгөөг өгч байдаг, хараат бус, зэрэглэл тогтоох хэмжээний эрх үүрэг бүхий хөндлөнгийн мэргэжлийн байгууллага болтлоо хүрээгээ тэлсэн байна. Товчхондоо Английн эрүүл мэндийн мэргэжлийн холбоодоос суралцах, туршлага судлах зүйл их байна.

Эмнэлэгт хэвтэх өвчтөний тоог бууруулахад ихэд анхаарчээ

-Английн эрүүл мэндийн тогтолцоо хүн амын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтээрээ дэлхийд дээгүүр ордог. Хүн амын нь эрүүл мэндийн байдал, иргэддээ үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар, хүргэж байгаа байдлаараа тэргүүлдэг гэж хэлж болно. Мөн өндөр хөгжилтэй орон учраас эрүүл мэнддээ зарцуулж буй зардал нь өндөр буюу дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ ес орчим хувийг зарцуулж байна. Энэ хэрээр эрүүл мэндийн салбар нь сайн хөгжсөн. Хөрөнгө мөнгөний таатай нөхцөл байдал нь он удаан жилийн турш эрүүл мэндийн тогтолцоогоо тууштайгаар

хөгжүүлэхэд бас нөлөөлжээ. Монгол Улс болон Английн эрүүл мэндийн тогтолцоонд ялгаатай зүйл олон бий. Ижил төстэй хэд хэдэн зүйл буй ч суралцмаар асуудлууд байна. Тухайлбал, анхан шатны тусламж үйлчилгээг хүргэж байгаа байдал нь нэлээд төстэй гэж хэлж болно.

1999 онд анхан шатны эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг Монгол Улсад бий болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Английн загварт үндэслэж, өөрийнхөө орны нөхцөл байдалд уялдуулан нутагшуулсан. Өнөөдрийн өндөрлөгөөс өрхийн эрүүл ►



Ц.Цолмонгэрэл
/Эрүүл мэндийн яамны
Бодлого, төлөвлөлтийн
газрын дарга/

► мэндийн тогтолцоонд сайжирсан зүйл олон байна. Мөн иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар ч дээшилж байгаа.

Нөгөө талаар Английн эрүүл мэндийн салбартаа хийж буй шинэчлэлийн нэг чиглэл нь иргэдэд үзүүлж буй эмнэлгийн үйлчилгээгээ илүү цогц байдлаар авч үзэж, иргэдийн эрүүл мэндийн хэрэгцээ болон орчин үеийн нөхцөлд нийцсэн байдлаар зохион байгуулж, нөгөө талаар өрхийн эрүүл мэндийн төвүүдээ санхүүгийн болон бусад дэмжлэгээр маш сайн дэмжиж өгсөнд оршино. Мөн Англид эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмнэлгийн ачаалал, эмнэлэгт хэвтэлтийг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч ажилласан байна. Үүнийг бид өөрийн оронд нэвтрүүлбэл тодорхой үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Тухайлбал, орчин үеийн амьдралын хэв маягтай уялдуулан нийгмийн стресс, сэтгэцийн өвчлөл ихсэж байна. Иймээс ийм өвчтөнүүдийг бий болохоос урьдчилан сэргийлж хамт олны цуглардаг нийгэмд

түшиглэсэн төвүүдийг нээж тэндээ стресс тайлах, хоорондоо харилцах, нийлэх, асуудлаа хуваалцах зэргээр өртөг, зардал багатай арга хэмжээг хэрэгжүүлж эмнэлэгт хэвтэлтийг бууруулан ачааллыг багасгах талаар ажиллажээ.

Англид чадварлаг, мэргэжлийн өндөр түвшний эрүүл мэндийн ажилтнуудыг бэлтгэж байна. Тэднийг сургах тогтолцоо нь нэлээн боловсронгуй. Тухайлбал, Англи улсад эмч болон сувилагчийн ажлын үүргийг зохистой болгож сувилагчийн эрх, үүргийг дээгүүр тавьж өгсөн байна. Сувилагч зөвхөн манайд байгаа шиг эмчийн туслах биш эм бичих эрхтэй болох хүртлээ хөгжжээ. Тиймээс эрүүл мэндийн тусламж дийлэнх үйлчилгээг бага өртөг, зардал бүхий ажиллах хүчнээр хүргэж байна. Энэ нь бас давуу талтай. Үүнээс манайх суралцаж, сувилахуйн тусламж үйлчилгээнд анхаарлаа хандуулж, сувилагчдаа сургаж бэлтгэх учиртай. ■

МЭДЭЭ

МОНГОЛ ЗУРААЧДЫН НҮДЭЭР ЕВРОП

Европ тивд тавтай морил. Ингэж хэлэхийн учир нь “Цагаандариум” галлерейд ирэх арванхоёрдугаар сард “Европын тэмдэглэлүүд-2” үзэсгэлэн нээлтээ хийх юм. Монголын алдарт зураач, Соёлын гавьяат зүтгэлтэн Ц.Нарангэрэл, Төрийн соёрхолт Ш.Чимэддорж нар хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд “М-Си-Эс” группын ерөнхийлөгч Ж.Одын санаачилснаар нэг сарын турш Англи, Дани тэргүүтэй Европын долоон орноор аялсан байна.

Тус үзэсгэлэнгээс зураачдын аяллынхаа туршид зурсан тэмдэглэл, эскиз, судалбараас бүрдсэн шинэхэн бүтээлүүдийг харж болох аж. Тэдний уран бүтээл Ази тивд байдаггүй эртний байшин барилгын архитектур болон байгалийн өвөрмөц шинэ өнгө төрхөөр баяжиж, олон сайхан санаа урган гарсан талаар Ц.Нарангэрэл зураач хэлсэн юм.

“Европын тэмдэглэлүүд” зургийн үзэсгэлэнг гаргах, Европ тивээр уран бүтээлийн аялал хийх санааг анх Ц.Нарангэрэл тэргүүтэй зураачид “М-Си-Эс” группын ерөнхийлөгч Ж.Оджаргалтай ярилцаж санаачилсан түүхтэй. Зураачдын “хөгшин” Европоор хоёр дахь удаагаа аялж, олон улсын урлаг соёлын ялгааг уран

сэтгэмжээрээ хөглөж, бийрний үзүүрээр амилуулсан гайхалтай бүтээлүүд үзэгчдийн хүртээл болох цаг удахгүй нь ээ.



Зүүн гар талаас Ц.Нарангэрэл, Ш.Чимэддорж.
Лондон хот



Фотог Э.Зоригт

СЭТГҮҮЛ ЗҮЙ

“Financial Times” сонины редакци

THE ECONOMIST, FINANCIAL TIMES-ийн РЕДАКЦИД ЗОЧИЛОО

Д.БЭХБАЯР

Financial Times

Дэлхийд тэргүүлэх эдийн засгийн сонины редакцид хоёр сэтгүүлчийнхээ хамт зочиллоо. “Mongolian Economy” сэтгүүлийн сурвалжлах тусгай баг Лондон хотод ажиллах үеэрээ тус сонины редакциар орох боломж тохиосон юм.

Биднийг “Financial Times” сонины Эрхлэгч болон мэдээ, уул уурхай,

маркетинг хариуцсан Эрхлэгч нар хүлээн авч уулзсан нь Монголын сэтгүүлчдийн хувьд том хүндэтгэл хэмээн ойлгосон. Бидний уулзалт ярилцлага сонин сэтгүүлийн хоорондын хамтын ажиллагаанаас гадна Монголын эдийн засгийн хөгжил, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, уул уурхайн томоохон төслүүд, Оюутолгой, Тавантолгойн ордын талаар өрнөсөн. Уул уурхайгаас орж ирэх мөнгийг Монголын Засгийн газар хэрхэн зарцуулж, эдийн засгийг дэмжих төлөвлөгөөг тус сонины

Эрхлэгч нар түлхүү сонирхож байлаа. Мөн дэлхийд тэргүүлэх Оюутолгойн төслийг урагшлуулахад төр, засаг ямар бодлого барьж байгаа талаар асуултууд тавьж байсан.

“Financial Times” сонины редакцийн том, уужим саруулхан өрөөнд олон сэтгүүлч сууна. Гаднын хүмүүсийг анзаарах манатай ажил руугаа анхаарлаа хандуулах өдөр тутмын сонины сэтгүүлчдийн хариуцлага үнэхээрийн өндөр.

“Financial Times” бол 1888 онд үүсгэн байгуулагдсан эдийн засаг, ▶

► бизнесийн англи хэлээр гардаг өдөр тутмын сонин юм. Анхлан "London Financial Guide" нэртэйгээр гараад удалгүй өнөөдрийн нэрээр өөрчилж, "шударга санхүүч, хүндтэй брокеруудад зориулсан дөрвөн хуудас бүхий сэтгүүл гаргаж байжээ. Тухайн үеийн цорын ганц өрсөлдөгч болох "Financial News" сониноос ялгарахын тулд тус сонин 1893 онд өнгөө ягаанд хувиргасан түүхтэй бөгөөд Брэндан Бракин гэдэг хүн энэ хоёр сониныг 1945 онд нэгтгээд "Pearson PLC" 1957 онд уг сониныг худалдан авчээ.

1970 оноос гадаад зах зээлдээ анхаарч, томоохон улс орнуудад сэтгүүлчид томилон ажиллуулж, 1979 онд тус сонины гадаад хэвлэл Германы Франкуртад анх хэвлэгдсэн байна. Одоо дэлхийн 22 байрлалд

"Financial Times" гарч байгаа бөгөөд Их Британи, Европ, АНУ, Ази болон Дундад Азид нийтдээ өдөртөө 2,2 сая уншигч, интернэтийн бүртгэгдсэн 4,5 сая хэрэглэгчтэйгээр дэлхийг хамарсан үйл ажиллагаа явуулж байна.

Зуун дамнасан түүхтэй сонины гол бодлого нь мэдээ мэдээллийг маш хурдтайгаар үнэн зөв, тал талын эх сурвалжтайгаар олон нийтэд хүргэхэд чиглэдэг. Хэн нэгний, ямар нэг намын эрх ашгийн үүднээс асуудалд хандах ойлголт байдаггүй хэмээн Эрхлэгч Леонел Барбэр тайлбарласан юм.

The Economist

Гайхалтай үйл явдал бус гэж үү? "Financial Times" бол миний

"Өнөөдөр" сонины Эдийн засаг, бизнесийн албанд ажиллах үеийн мөрөөдөл байсан бол "The Economist"-ийн редакцид зочлох тухай бодол одоогийн хийж буй ажилтай маань холбоотой.

"Mongolian Economy" сэтгүүлээ анхлан үүсгэн байгуулахдаа The Economist сэтгүүлийг ерөнхий чигээ болгож байснаа би нууж хаалгүй хэлэх дуртай. Улмаар бид өөрийн өвөрмөц төрхтэй, үндэсний онцлог бүхий эдийн засаг, бизнесийн Монголын "Economist" сэтгүүлийг бий болгох зорилго агуулан ажиллаж байна.

Манай сэтгүүл байгуулагдаад 2,5 жил болж байгаа бол "The Economist" 1843 онд анхлан хэвлэгджээ. Олон жилийн түүхэнд угаагдаж, өнөөдрийн өнгөө олсон дэлхийн өндөр түвшний хамгийн том сэтгүүл юм. Тус сэтгүүлийн олон улсын салбар хариуцсан Эрхлэгч Эдвард Лукас буурал түүхийн нугачаанд шарласан гэртээ 1800-гаад оны анхны нийтлэлүүдийг эмхэтгэсэн зузаан гэгчийн номыг бидэнд үзүүллээ. The Economist-ийнхон түүгээрээ ихэд бахархдаг ажээ.

Долоо хоног тутмын англи хэлээр гардаг энэ сэтгүүлийг 1843 оны есдүгээр сард Жэймс Вилсон үүсгэн байгуулжээ. Эдүгээ тус сэтгүүлийн тал хувь нь "The Economist" группийн, тал нь "Financial Times"-ийн оролцоотой "Pearson PLC"-ийн эзэмшилд байдаг аж. 2006 оны мэдээллээр долоо хоногт 1,5 сая ширхэг хэвлэгддэг ба үүний тал хувь нь АНУ-д борлогддог байна.

"The Economist" нь "Эдийн засгийг он, сараар дараалан бичсэн хуанли биш, харин оюун ухааныг урагшлуулах ширүүн тулаанд мэдлэг нэмэн оролцох зорилготой" хэмээн сэтгүүлийнхээ зорилгыг тодорхойлжээ. Уламжлалт эдийн засгийн үзэл бодлыг тусгасан, чөлөөт худалдаа, даяаршил, нийгмийн чөлөөт байдлыг дэмждэг сэтгүүл юм. Өндөр боловсролтой, нөлөө бүхий удирдлага, захиралууд, шийдвэр гаргагчдын түвшний хүмүүсийг уншигчдынхаа хүрээлэлд байлгахыг зорьдог гэнэ. Тэдний ►



"The Economist"-ийн редакцид. Баруун гар талаас "Mongolian Economy" сэтгүүлийн Эрхлэгч Д.Бэхбаяр, The Economist сэтгүүлийн олон улсын харилцааны Эрхлэгч Эдвард Лукас, "Mongolian Economy" сэтгүүлийн сэтгүүлч Б.Энхцэцэг

▶ зарим уншигч олон нийтэд зориулсан сонин хэвлэлийг уншдаг тухай ч онцлон хэлж байлаа. 1990-ээд онд ажиглагдаад XXI зууны эхэнд түргэссэн дэлхийн даяаршлын өнөөгийн өөрчлөлтийн талаар тус сэтгүүлийн захирал “Масс оюун ухааны шинэ эрин ирлээ” хэмээн хэлснийг сэтгүүлийнхэн онцлох нь бий.

“The Economist”-ийн төв байр нь нэлээд хуучны байшингуудын нэгд тооцогддог бөгөөд Лондонгийн төвд буюу хамгийн үнэтэй газарт байрладаг.

14 давхар оффисын 1-2 хүн л багтах жижиг, жижиг өрөөнүүдэд сэтгүүлчид ажиллана. Овоолгоостой цаас, бичиг баримт дунд тэд сууж харагдлаа. Харин сэтгүүлийн маркетинг, борлуулалтын менежерүүд нь хотын захын оффистоо байдаг гэнэ. “Манайх маш өндөр түвшний сэтгүүл. Уншигчид маань өндөр түвшний хүмүүс байдаг тул бид өндөр түвшний бүтээгдэхүүн хийдэг. Тиймээс удирдлага, сэтгүүлчид, ажилтнууд маань ч мэдлэг боловсрол өндөртэй” хэмээн Эдвард Лукас ярина.

Өндөр түвшний, чанартай гэдэг үгс Эдвард Лукасийн амнаас байсхийгээд гарах аж. Өмнөд Африкийн Ерөнхийлөгч асан Нельсон Манделаг нас барангуут хэвлэх сэтгүүлийн шинэ дугаарыг хэдийнэ бэлтгээд бэлэн болгосноо тэрбээр үзүүлээ. Дэлхийн томоохон үйл явдлуудыг урьдчилан харж бэлтгээд уншигчдадаа цаг алдалгүй хүргэх нь “The Economist”-ийн гол бодлого бөгөөд бичлэгийн хэлбэр, өвөрмөц сонирхолтой, бага зайд ихийг өгүүлэхэд сэтгүүлчдийнх нь ур чадвар харагддаг бөгөөд сэтгүүлчдийн голлон анхаардаг зүйлс нь ч эдгээр юм.

“The Economist” нь Ази, Европ, Африк, мөн салбар салбарыг хариуцсан сэтгүүлчидтэй. Нийтдээ 80-аад сэтгүүлчтэйн гуравны хоёр нь Лондонд ажилладаг.

190 жилийн түүхтэй сэтгүүлийн Эрхлэгч хоёр настай “Mongolian Economy” сэтгүүлийн Эрхлэгчид хамгаас үнэтэй зөвөлгөө өгч,

туршлагаасаа хуваалцсан нь бидэнд олдох ховор боломж байсан юм. Мөн хоёр сэтгүүлийн хамтын ажиллагааны талаар ч ярилцсан билээ. Түүний зөвлөгөөг бид цаашид ажилдаа хэрэгжүүлэн, нэвтрүүлэн ажиллах болно. Манай сэтгүүлийн зарим уншигч сэтгүүлийг маань “The Economist”-той харьцуулан санал шүүмжлэл хэлж, шинэ содон санаа оноог бидэнд дэвшүүлдэг. Монгол Улсад эдийн засаг, бизнесийн чанартай, сайн сэтгүүл байгаасай гэсэн чин сэтгэлийн угаас хандсан тэдгээр уншигч захиалагч нартаа талархаж байна.

Ийнхүү Англид “төрсөн” ч хэдийнэ дэлхийн тодотголоор яригдах эдийн засаг, бизнесийн хамгийн шилдэг сэтгүүл, сонины редакциар зочилж, мэдээлэл солилцож, хамтын ажиллагаа ярилцаж, туршлага хуваалцсан нь

зөвхөн манай сэтгүүл бус Монголын сэтгүүл зүйд шинэхэн зүйл болохын сацуу хариуцлагатай, эрүүл сэтгүүл зүйг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм аа. Аль нэг намын харьяалалд автаж, мөнгөтэй бүлэглэлийн мөнгөөр сэтгүүлчийн үзэг, үзэл санаа хөдөлж эхэлбэл тэр нь эрүүл, хариуцлагатай сэтгүүл зүй биш болж, сэтгүүл зүйн салбар уналтад орж эхэлдэг тухай “The Economist”, “Financial Times”-ийн Эрхлэгч нар хэлсэн юм.

Тэгвэл өнөөдөр Монголын сэтгүүл зүйн салбар ямар нөхцөл байдалд буйг хүмүүс надаар хэлүүлэлтгүй сайн мэднэ. Ямар ч тохиолдолд улс төрөөс хараат байж мэдээллийг тал талын эх сурвалжтайгаар үнэн зөвөөр уншигчдад хүргэх гол зорилгоосоо хазайлгүй урагшлахыг дээрх хэвлэлийн Эрхлэгч нар бидэнд хэлж, амжилт хүссэн билээ. ■



“The Economist” нь “Эдийн засгийг он, сараар дараалан бичсэн хуанли биш, харин оюун ухааныг урагшуулах ширүүн тулаанд мэдлэг нэмэн оролцох зорилготой” хэмээн сэтгүүлийнхээ зорилгыг тодорхойлжээ



ФЕДЕРИКО ЛЮВИС
Англо Американ, Перу улс

Англо Американы хэн ч бай, байгал орчны мэргэжилтэн, геологич, эрдсийн судлаач, уурхайчин бид бүгд нэг зорилгын төлөө нэгдсэн сэтгэлээр ажилладаг.

Компанийн үүсгэн байгуулагч Эрнест Оппенхаймер үндсэн зорилгоо “Үйл ажиллагаа эрхэлж буй газар нутгийн ард иргэдэд урт удаан хугацааны бодит хувь нэмэр оруулах замаар хувьцаа эзэмшигчдэд ашиг авчрахад оршино” гэж тодорхойлсон байдаг.

Энэ бизнесийн зарчмыг манай компани өнөөг хүртэл чандлан биелүүлж ирсэн.

Яагаад? Учир нь бид зөв төлөвшсөн уул уурхайн компани юм.

www.angloamerican.com

**БИДНИЙ АЖЛЫН АРГА БАРИЛ:
НЭГДСЭН ЗОРИЛГОТОЙ БАЙЖ ИЛҮҮ
ҮНЭ ЦЭНИЙГ БИЙ БОЛГОХ**

**MINING 2013
MONGOLIA**



**POWER &
RENEWABLE ENERGY
MONGOLIA 2013**



**2013 ОНЫ 9 САРЫН 19-21-НД
БУЯНТ-УХАА СПОРТ ЦОГЦОЛБОРТ**

IPAD2 ХОЖИХ БОЛОМЖ



Яг одоо онлайнаар бүртгүүгээд үнэ төлбөргүй үзэсгэлэн үзэх зочны мандат шуудангаар хүлээж авах төдийгүй таны бүртгэл автоматаар 2 ширхэг iPad2-ын нэгийг хожих азын сугалаанд оролцох эрхтэй болно. 2013 оны 9-р сарын 19, 20 ны өдрүүдэд тус бүр 1, нийт 2 азтан iPad2-ын эзэн болох болно.



Яг одоо

www.miningandconstructionmongolia.com

хаягаар бүртгүүлнэ үү.

ГАЙХАЛТАЙ БОЛОМЖУУДАД ХҮРГЭХ

УРИЛГА

3 өдрийн турш шинэ нөөц бололцоо, шинэ санаа,

*18 орны 120 компани
уул уурхай, барилга, цахилгаан
эрчим хүчний салбарт салбарт
зориулсан технологи, үйлчилгээгээ
урд өмнө нь Монголд болж
байгаагүй өргөн цар хүрээнд
дэлгэн үзүүлэх болно.*



ҮЗЭСГЭЛЭНГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

2013 оны 9-р сарын 19-20 10:00-17:00

2013 оны 9-р сарын 21 10:00-16:00

Болох газар: БУЯНТ-УХАА СПОРТ ЦОГЦОЛБОРТ

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД



УУЛ УУРХАЙН ЯАМ



ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМ



БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



AN ALLWORLD
EXHIBITIONS
EVENT

AWED

**MONGOLIAN
ECONOMY**

www.miningandconstructionmongolia.com

Утас: 976-11-344488 цахим шуудан: sales@lookmongolia.com